Арван долоотой байхад

Манайх Цээлд, Бөөдэйнх Улаандэлд зусч байлаа. Цээлийн тойром нуурлачихсанаас хойш тэдний адуу тэмээ усны үнэрээр цуван ирэх болж бид хоёрын уулзаж байхад ганц сайн шалтаг болсон юм.

Бөөдэй ээжтэйгээ хоёулхнаа суудаг болохоор тэмээ малдаа өөрөө л явна. Хааяа унаагаа юүлүүлэх гэж адуугаа тууж ирэхэд нь би уургынхаа хээрийг барьж мордоод хорь хүрэхгүй адууг нь хураан хөндөлсүүлж явсаар барих морио тэгэхээс тэгж адуунаас нь гарган элдээд сүүл дэрлэн дагах хэвтээ дэмтэй сайхан хээрийнхээ дөрөө зуран эргэх яг л тэр агшинд бөхийн цацаж, сүүлэндээ салхи татуулан зугатаах морины нарийн хоншоороор уургалан эргүүлээд үргэн давхисан адууныхаа хойноос янцгаан тэмүүлэх түүнийг эмнэг уургалсан мэт цухалзуураар нь эрж Бөөдэйг хүлээж зогсоно.

Бөөдэй үсрэн бууж олмоо тавиад, эмээлээ өргөн, мориныхоо нурууг нар харвахаас болгоомжлон салхи оруулж хэсэг сүүдэрлэн зогссоноо хазаараа мулталж инээсээр ирнэ.

Энэ бол миний арван долоон насанд хамгийн жаргалтай мөч байлаа. Гэвч энэ маань өглөөдөө үзэгдэх хөвчийн манан шиг байжээ.

Чойдогийн хүү цэргээс иржээ, нутаг усны айлуудаар бууж явна гэсэн сураг уснаас ус дамжин, саахалтын бүсгүйчүүд хонинд явахдаа ч гоёж гоодох болов. Би ч түүнийг үзэхийн хүслэн болж байтал ашгүй нэг ирлээ. Тэрбээр аавынхаа төхөөрч тавьсан бэсрэг хэрэгсэлтэй боржгон эмээл тохож, шанхалж дэллэсэн өндөр шарга морь унажээ. Нэрийг нь Ойдов гэнэ. Хараар гурав эмжсэн саарал даавуу дээл хөөргөн өмсөж бор бүрх малгай сагалдаргалаад шажигнасан чимээтэй хороомон гутал өмссөн нь гоёлын дээд бөгөөд өргөн ханхар мөр, тэгш цагаан шүд, шооч байрын хүрэн нүд нь ер сумандаа л би гэж хэлээд байх шиг санагдана.

Ойдовынх бас Улаандэлд, түүнийг манайхаар буугаад мордсоноос хойш Бөөдэйн адуу тэмээ нууранд ирэхээ больчихов. Нэг өдөр айлын адуунд байсан даагатай гүү авчрах далимаар Улаандэл орж хэргээр орой болгоод Бөөдэйн адууг бэлчээрээс нь хөөн Цээлийн нууранд авчирчихаад маргааш нь Бөөдэйг ирнэ гэж нуурын баруун овоон дээр харуулдан суутал Ойдов хархүү алаг морьтой давхиж ирээд хөөгөөд явчихлаа. Тэдний мал удтал нууранд ирээгүй учрыг би сая л нэг гадарлаж чичигнэн инээдэг хөөрхөн Бөөдэйг минь хулгайлан хөөгөөд явчихаж байгаа юм шиг хойноос нь удтал ширтэн зогсохдоо Ойдовын эрдэм чадал, сайн сайханд хязгааргүй атаархаж байгаагаа мэдэв.

Ойдовын энэ сайхан бүхэн цэрэгт алба хаасны л ач гэж өөрөө өөртөө батлаад, насаа нэмж байгаад ч хамаагүй энэ жил л цэрэгт явчихъя гэж хатуу шийдэж билээ. Тэгээд сумын наадам дээр Ойдовыг хаячхаад урт түрүүтэй хороомон гутлаа шажигнуулан дэлж Бөөдэйн хажуугаар харалгүй өнгөрнө дөө гэж бодоход сэтгэлийн тээг сэмрэн, ярс ярс алхлан яваа цэрэг эрчүүдийн жагсаалд орчихсон юм шиг хөгжилтэй сэргэлэн болов оо.

Жагдалын Лхагва

1. Дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийн дугаарыг олоорой.

1. Эмнэг	a) Нуур байгаад хатаж ширгэсэн шаварлаг хөрстэй газар
2. Саахалт	b) Догшин, атар, уналгаа эдэлгээнд сургаагүй адгуус
3. Тойром	c) Морь уургалахад сургасан морь
4. Уургын хээр	d) Морио солих
5. Унаагаа юүлэх	e) Ойрхон буусан хоёр айл

A. 1c2e3b4a5d B. 1c2a3b4d5e C. 1e2c3b4d5a
D. 1a2b3c4d5e E. 1b2e3a4c5d

2. "Чойдогийн хүү цэргээс иржээ, нутаг усны айлуудаар бууж явна гэсэн сураг **уснаас ус дамжин**, саахалтын бүсгүйчүүд хонинд явахдаа ч гоёж гоодох болов." өгүүлбэрийн онцолсон хэсгийг солин найруулбал аль хэсэг нь илүү тохиромжтой вэ?
A. Уулнаас уул дамжин B. Агаар салхиар дамжин
C. Амнаас ам дамжин D. Хөвчийн манан дамжин
E. Саахалтаас саахалт дамжин

3. ***Бөөдэйн адуу тэмээ Цээлийн тойром руу ирдэг гол шалтгаан юу вэ?***
A. Би Бөөдэйтэй уулзах гэж адуу тэмээг нь тууж ирдэг
B. Бөөдэй нуур луу адуу тэмээгээ туудаг
C. Бөөдэйг надтай уулзуулах гэж ээж нь адуу тэмээгээ нуур луу туудаг
D. Усны үнэрээр
E. Цээлийн нуур Улаан дэлд ойрхон болохоор

4. Эхэд юуны тухай өгүүлсэн бэ?
A. Цэргий алба B. Арван долоон нас
C. Аз жаргал D. Анхны хайр
E. Сумын наадам

5. *Эхийн гол санааг олоорой.*
A. Цэргийн албанд эрт явах нь чухал байдаг
B. Арван долоон нас хамгийн жаргалтай үе байдаг
C. Анхны хайрын гэмгүй цагаан атаархал
D. Морины нурууг нар харвахаас болгоомжлох хэрэгтэй
E. Адуу малаа сайн усалж байх хэрэгтэй

6. "... ярс ярс алхлан яваа цэрэг эрчүүдийн жагсаалд орчихсон юм шиг " *дүрслэх ур маягийн алинд хамаарах вэ?*
А. Адилтгал Б. Ёгтлол В. Зүйрлэл Г. Ихэсгэл Д. Амьдчилал

7. Өгүүллэгийн хэсгүүдийн зөв дараалыг олоорой.

A. Бөөдэй Цээлийн тойромд ирсэнгүй, Жаргалтай мөч, Цэрэгт явахаар шийдэв, Чойдогийн хүү цэргээс ирэв

B. Бөөдэй Цээлийн тойромд ирсэнгүй, Цэрэгт явахаар шийдэв, Жаргалтай мөч, Чойдогийн хүү цэргээс ирэв

C. Жаргалтай мөч, Бөөдэй Цээлийн тойромд ирсэнгүй, Цэрэгт явахаар шийдэв, Чойдогийн хүү цэргээс ирэв

D. Жаргалтай мөч, Чойдогийн хүү цэргээс ирэв, Бөөдэй Цээлийн тойромд ирсэнгүй, Цэрэгт явахаар шийдэв

E. Жаргалтай мөч, Бөөдэй Цээлийн тойромд ирсэнгүй, Чойдогийн хүү цэргээс ирэв, Цэрэгт явахаар шийдэв

8. "Бор бүрх малгай сагалдраглаж хараар гурав эмжсэн саарал даавуу дээл хөөргөн өмсөж шажигнасан чимээтэй хороомон гутал өмссөн нь гоёлын дээд..." өгүүлбэрт ямар хувиргал хийснийг олоорой.

A. Хураах B. Дэлгэрүүлэх
C. Салаалах D. Тонгоргох
E. Дэлгэрүүлэгч гишүүд нэмсэн

9. **"сэтгэлийн тээг сэмрэн"** гэсэн холбоо үгтэй ойролцоо утгатай хэлцийг олоорой.

A. Сэтгэл алдан B. Сэтгэл эмтрэн
C. Сэтгэл сэргэн D. Сэтгэл зовон D. Сэтгэл сэвтэн

10. ***"Би" баатар яагаад цэрэгт явахаар шийдсэн бэ?***

A. Арван найман нас хүрсэн учраас
B. Урт түрүүтэй хороомон гутал өмсөхийн тулд
C. Сумын наадмаар Ойдовыг хаях
D. Ойдов шиг эрдэм чадалтай, сайн сайхан болохоор
E. Бөөдэйд гомдсон учраас

ХОЁРДУГААР ХЭСЭГ [30 оноо]

2.1 Дараах эхийн хэсгийг уншаад зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай 1 үгийг олвол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо. [5 оноо]

Багийн найз

Миний багийн найзыг Сэрдамба гэдэг. Бид хоёр бүр цэцэрлэгт нэг ангид байлаа шүү дээ. Би найзынхаа хөдөлмөрч, шудрага, үнэнч зангаар бахархдаг. Найз минь одоо алдартай тамирчин болсон төдийгүй "Ирвэс" багийн дасгалжуулагчаар ажиллаж байна. Би багийн найзынхаа зөвөлгөөг ажил амьдралдаа хэрэгжүүлхийг хичээж явдаг. Миний найз олон тэмцээнд нударга зөрүүлэн, амжилт байгуулсан бөгөөд алдарын тавцанд гарч, эх орныхоо алтан соёмбот далбааг мандуулсан билээ.

Ташаарсан нь	Залруулсан нь

2.2 Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. [5 оноо]



2.3 Дараах сэдвээр эх зохион бичихдээ бүтэц, хэв шинж, сэдэв, агуулгын харьцаа болон найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглаарай. Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 150-180/ [20 оноо]

Жилийн дөрвөн улирал

……

……

Хувилбар 2

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ [20 оноо]

Нутаг

Балдан өвгөн Талын хайрхны оройд гарч лус савдгийг аргадан сан тавьж, өл овоонд мөргөн малгайн утаа сэргээгээд буцаж явлаа. Цагаан өвс аниргүйхэн ганхах их тал эл хульхан, бялзуухай ч үл жиргэх бөгөөтөл манан будангийн л дуу ийм байдаг болов уу гэмээр нэгэн бүдэгхэн цагаан аялгуу чихний үзүүрт сонсогдохтой үгүйтэй холдон ойртон эгшиглэнэ.

Түүний унасан нойрмог номхон нүд, хүнд хөшүүн хөлтэй хашин хул морь омруун дороосоо туулай босон харайсан ч үргэж цочих янзгүй сал сал шогшино. Агь нүдэлсэн, алаг цоог цастай, эрээн тарлан газар дэлхий дээгүүр үл мэдэг хөхөлбөр туяатай бүлээн дулаан будан татжээ. Нас ахиж, сэтгэл зөөлрөөд ирэхийн цагт өөрийнхөө ганц хар толгойг бус ёс жудгийг эрхэмлэн хичээж, хорвоогийн жамаар уул овоондоо хүртэл сүсэглэн залбирч, бишрэх хоргодох юмтай болдог ажээ.

Балдан ийнхүү ертөнцийн нүгэл буян, хар цагааныг дэнслэн бодолдоо зүүрмэглэн явтал морь гэнэт чихээ сортосхийлгэн зөөлөн хээр дуугаар үүрслээ. Айл малын анир бараагүй энэ эзэнгүй талд юу харахлаараа морь ийнхүү үүрсдэг билээ гэж бодох зуур өвгөн анилдах шахам явсан зовхио өргөн харвал ойрхон саахалтын зайтай газар адуу гэхэд адуу биш чоно гэхэд чоно биш нэгэн зэгэл саарал амьтан огтхон ч хөдөлгөөнгүй хөндөлдөн зогсож байх нь тэр.

“Юу юм бол гүү унагалаад унагаа хээр хаячихсан юм биш байгаа” гэж санаснаа жолоогоо тэр зүг эргүүлэн бөг бөг шогшсоор ойртон очвоос чөдөртэй болов уу гэмээр ганц бүгээн адуу байлаа. Унаатай хүн хараад хөдөлдөггүй яасан хачин мал вэ? хэмээн айх, гайхах сацуу өвгөний сэтгэлд муу зүгийн эрээн бараан юмс үзэгдэх шиг болоход ар нуруу нь хүйт даан зарсхийжээ. Ясархаг зэгзгэр биетэй эцэж ядрахын туйлыг үзсэн яндан буурал морь нүдээ анилдуулан зүүрмэглэн зогсох нь яавч эрүүлийн шинжгүй. Гэтэл түүний туурайны нөмөрт цас туулайлан шуурсан байхыг Балдан ажиглаатхав. Дөрвөн хөл дээрээ ширээлдэн цахлан зогсож, босоогоороо нүд аньсныг дөнгөж сая ухаарсан өвгөн ханцуйдаа наминчлан залбираад уртаар шүүрс алдлаа. Нэгийгээ үхүүлсэн мэт халаглан, харамссан өвгөний нүд тэрхэн зуур мөнөөх үхсэн морины гуяны толион дээрх “галтай саран” тамган дээр тусаж, төрөл арилжсан амьтан босож ирэхийг үзсэнээс дутуугүй сандрав. “Манай унаган тамгатай юун адуу хаанаас гүйгээд ирдэг сэн билээ. Би энэ яваа насандаа ийм буурал морь хол, ойрын хүнд арилжаагүй шиг санагдах юм” гэж бодсоноо Балдан өвдөг нугалан, хөлөө бохирон сууж тамхи татахаар гаансаа гарган зуутал хүйтэн чулуун соруул түүний шүдгүй буйлыг хайрав. Тэрхэн агшинд өвгөний сэтгэлийг жихүүн амьсгалтай хар бараан сүүдэр зугуухан нөмрөх шиг болоход бодлоосоо цочин ухасхийн бослоо.

Аль дивангарт амьсгал хураан хөшиж хөрсөн тэр морины магнай дээгүүр цас хяруу шиг мөнгөн буурал сор унаж цохон дээрх жижигхэн цагаан сар нь бүдгэрэн цайжээ.

Олоон жилийн тэртээ, бараг залуухандаа Балдан өөрийн унаган адуунаас нэг зээрд үрээ наадамд сойж, тэр нь сумандаа олны цагаан хэл ам хүрмээр дэндүү тасархай түрүүлэн анх удаа айраг амсаж билээ. Гэтэл газрын хаанаас гараад ирснийг бүү мэд наадам тарсны маргааш хол нутгийн нэг хижээл хар хүн “зээрд үрээгээ зарчих, үнэ өртгийн хувьд би гар татахгүй шүү” гэж оровч гаравч шалсаар байгаад Балдангийн одоо энэ зууж яваа сөөм цагаан гаансаар түүний зээрд морийг худалдан аваад эргэж ч харалгүй тоос татуулан давхин одсоноос хойш хорин хэдэн жил улирсан юмсанж.

“Заяа нь орхисон тэнэг толгой. Азарга адуугаар арилжимгүй ийм сайхан “буянаа” нэг муу утаатай чулуугаар солих гэж байх уу. Энэ гаанснаас надад юу наалдав. Мэнгэр, бохь хоёр. Удахгүй энэ нүглийн мод толгойноос би хар толгойгоо өгнө. Намайг үхсэний дараа энэ гаанс миний дэрэн дороос гарч бас нэг хүнд гай болно. Гучин хэдэн жил гашуун утаагаар хоол хийлээ.

Хэдийгээр хэлгүй адгуус ч гэсэн энэ морь насныхаа эцэст нутагтаа ирж, ясаа тавих тавилантай байж, хөөрхий. Мунхаг эзэн надаасаа илүү Талын хайрхныхаа оройд толгойгоо залуулан, онголж тахиулах заяатай амьтан байсан юмсанж” гэж санаснаа зээрд мориныхоо цан хүүрэг болсон аниастай нүд сормуусыг хараад өрөвдөн, өөрийн эрхгүй нулимс унагалаа.

Дулаахан бор сүүдэр хүүшилсэн их талын дунд сондгойдуухан ургасан хэдэн сөөг цагаан дэрс өвгөний үймж гашуудсан сэтгэлийн хар салхинд гэнэт алгадуулсан мэт толгой гудайлган гунигтайхан бөхөлзөнө. Худлаа хэлэхгүй хүн, арван мянган төгрөгийн үнэ өгөхөд нь хайрлаад өгч чадаагүй сөөм цагаан гаансаа Балдан согтуу хөлчүү хүнийхтэй төсөөтэй харц нь төөрсөн нүдээр алмайран ширтсэнээ хөлийнхөө доорх хөндлөн хөх чулуунд ороолгон хага цохив.

Бут үсрэн газрын нэг тарсан хаш цагаан соруулын хэлтэрхий Балдан өвгөний нүгэл, харуусал хоёрыг тавлан инээмсэглэх мэт өглөөний нарны гэрэлд түүний нулимстай зовхины завсраар солонгорон гялалзана.

Амин халуун хайраар холбоотой төрж, өссөн нутаг уснаасаа харь хол яваа эр хүн, хүлэг морь хоёрын сэтгэлийн үзүүрийг сэрвэлзүүлсэн хөх ногооны униар ид татаж байсан цаг юмсанж.

/Б.Догмид/

1. Эхэд орсон дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийн дугаарыг олоорой.

1. мэнгэр	a) гаансны дотор тогтох муухай үнэртэй хар юм
2. яндан	b) мал, амьтны ноолууртай хольцолдон ургасан урт ширүүн үс
3. бохь	c) эцэнхий туранхай
4. цох	d) гавлын ясны магнайн төв хэсэг
5. сор	e) уушгины цагаан гуурснуудын салст бүрхэвч үрэвсэж өвчлөх өвчин

A. 1c2e3b4a5d B. 1c2a3b4d5e C. 1e2c3b4d5a
D. 1a2b3c4d5e E. 1e2c3a4d5b

2. *"Дөрвөн хөл дээрээ ширээлдэн **цахлан** зогсож, босоогоороо нүд аньсныг дөнгөж сая ухаарсан өвгөн ханцуйдаа наминчлан залбираад уртаар шүүрс алдлаа*." -өгүүлбэрийн онцолсон үгийн утгыг олоорой.
   A. биеэ тэнцүүлэн эгц хөндлөн зогсох
   B. хөлөө тулгуурлаж захаар нь зогсох
   C. чангаахад хөдлөхгүй, хөлөө солбин зогсох
   D. тэнцүүрээ олж, зайдуу зогсох
   E. хөлөө газарт чанга жийн зогсох 3. "Заяа нь орхисон тэнэг толгой..." гэсэн санааг батлах баримт аль нь вэ?
   A. Би энэ яваа насандаа ийм буурал морь хол, ойрын хүнд арилжаагүй шиг санагдах юм
   B. Гэтэл түүний туурайны нөмөрт цас туулайлан шуурсан байхыг Балдан ажиглаатхав.
   C. Манай унаган тамгатай юун адуу хаанаас гүйгээд ирдэгсэн билээ
   D. Азарга адуугаар арилжимгүй ийм сайхан "буянаа" нэг муу утаатай чулуугаар солих гэж байх уу.
   E. Дөрвөн хөл дээрээ ширээлдэн захлан зогсож, босоогоороо нүд аньсныг дөнгөж сая ухаарсан

4. Өгүүлэгчийн ялгуун буурал морийг өрөвдөн хайрлаж буй хандлагыг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
   A. Юу юм бол гүү унагалаад унагаа хээр хаячихсан юм биш байгаа
   B. Унаатай хүн хараад хөдөлдөггүй яасан хачин мал вэ?
   C. Тэр нь сумандаа олны цагаан хэл ам хүрмээр дэндүү тасархай түрүүлэн анх удаа айраг амсаж билээ.
   D. Гучин хэдэн жил гашуун утаагаар хоол хийлээ.
   E. Хэдийгээр хэлгүй адгуус ч гэсэн энэ морь насныхаа эцэст нутагтаа ирж, ясаа тавих тавилантай байж, хөөрхий.

5. *Азарга адуугаар арилжимгүй ийм сайхан "буянаа" нэг муу утаатай чулуугаар солих гэж байх уу. Энэ гаанснаас надад юу наалдав. Мэнгэр, бохь хоёр.*- өгүүлбэрийн санааг хамгийн оновчтой илэрхийлсэн хэлцийг олоорой.
   A. бушуу туулай борвиндоо баастай B. гэм нь урдаа, гэмшил нь хойноо
   C. яарвал даарна D. нэр хугарахаар яс хугар
   E. буян нь ирэхэд бух нь хээлтэнэ

6. Өвгөн Балданд тохиолдсон хэрэг явдлын цаг үеийг олоорой.
   A. өвлийн улиралд
   B. хаврын улиралд
   C. намрын улиралд
   D. зуны улиралд
   E. овооны баярын үеэр
7. "*Тэр морины магнай дээгүүр цас хяруу шиг мөнгөн буурал сор унаж цохон дээрх жижигхэн цагаан сар нь бүдгэрэн цайжээ.*"- өгүүлбэрийн дүрслэх ур маягийг олоорой.
   A. хүншүүлэл B. төлөөлөл C. зүйрлэл
   D. тойруулал E. ёгтлол
8. Эхийн сэдэв буюу дэвшүүлэн тавьсан асуудлыг олоорой.

A. морины тухай
B. эр хүн, хүлэг морины тухай
C. хожимдсон харууслын тухай
D. хорвоогийн жам ёсны тухай
E. эх нутаг юунаас ч үнэтэй байдаг тухай

9. Эхийн гол санаанд тохирох хэлцийг олоорой.
A. Хүн муу боловч ёстой нь дээр, хүлэг муу боловч хазаартай нь дээр
B. Огторгуйн нар шингэдэг, оройн очир шилждэг
C. Сайн моринд эзэн олон, сайн хүнд нөхөр олон
D. Хүн өтлөхөөр нутгаа, тураг өтлөхөөр уулаа
E. Морьтон явганы зовлонг мэдэхгүй, мэрэгчүүд мунхагийн зовлонг мэдэхгүй

10. Эхийн онцолсон хэсгийн хэв маягийг тодорхойлоорой.
A. Өвгөн Балданы морь үүрсэхийн учир начрыг баталсан тул эргэцүүлэмж
B. Өвгөн Балданы морины шинж байдлыг зурагласан тул тоочимж
C. Өвгөн Балданы бодлыг олон талаар задлан тайлбарласан тул тайлбарламж
D. Өвгөн Балданд тохиолдсон явдлыг дараалан гаргасан тул хүүрнэмж
E. Өвгөн Балданы хийсэн үйлүүдийг дэс дараалан өгүүлж, морины шинж байдлыг зурагласан тул хүүрнэмж, тоочимж хосолсон хэв маяг

ХОЁРДУГААР ХЭСЭГ [30 оноо]

2.1 Дараах эхийн хэсгийг уншаад зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай 1 үгийг олбол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо. [5 оноо]

Төрийн далбаа соёмбо тэмдэгтэй бөгөөд гал шиг өөдлөж, нар сар шиг өдөр шөнөгүй мандан гийхийн санаа агуулсан гэдэг. Голын хоёр загас эр эмгүй энх жаргалын далайд умбаад өнийн хугцаанд өдөржин жаргахдаа загас мэт нүд цавчалгүй сонор сэрэмжтэй байхыг сургажээ. Олон хоногоор хурц нар шараж, хур чийг дутагдхад ган гачиг болно.

Ташаарсан нь	Залруулсан нь

2.2 Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. [5 оноо]



....
....
....
....
....
....
.....

2.3 "*Гэм нь урдаа, гэмшил нь хойноо*" сэдвээр эх зохион бичээрэй. (Бичихдээ бүтэц, хэв шинж, сэдэв, агуулгын харьцаа болон найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглаарай.) Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 150-180/ [20 оноо]

Хувилбар 3

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ [20 оноо]

Үрт амьтан

Дэмбээ их талд тарлантан хөхрөх Оорцогийн хэдэн өндрийн барааг харж, гулалзтал алхаж явсан тэмээнийхээ бурантгийг татасхийв.

“Одоо болсон байлгүй. Нутгийн дээс алхаад хэдэн саахалт явчхав даа” гэж бодов. Тэгээд тэмээгээ сөглөн хэвтүүлж, урд бөхөнд нь өлгөсөн хурганы уутыг авч, улаан замаас холдон хэдэн сөөсийсөн цагаан дэрсний дэргэд уутныхаа амыг яран, ёроолоос нь сэгсрэн тохой хэрийн дээсний тасархай мэт нэг юм, сурны өөдөс мэт гогцоорсон хэдэн юм унагаж, лав ямар нэгэн шившлэг үг хэлдэг байх...” гэж санаснаа зурсхийн орж ирснээр нь “Дэлхий дээрээ дэгдэж яв” гэж шивнэв.

Тэгээд нэг л их ёс төртэй үйл бүтээсэн мэт тээхийн зогсохдоо, газрын өнгөтэй урт амьтан, сөөм хүрэхгүй гурван нарийхан үрээ өөртөө дөхүүлэн мурилзахыг хараад эргэжээ. Тэр унаа тэмээгээ хэвтүүлэх зөөлөн газар нүдээрээ эрэлхийлэн баахан явснаа сая эрснээ олсон мэт бурантгаа сулхан дугтран хэвтүүлж мордоод ирсэн замаа орхин, нар жаргахаас өмнө айлын бараа харахаар тэмээндээ бутан толгой хамхуул өвс шүүрүүлэн алхуулав. Дэмбээ гурван өдөржийн газрыг өдөртөө хээв нэг залгах мэт ирсэн тэмээгээ**рээ** нэг бахархан, нэг өрөвдөн, сайн амрааж аваад өглөө замаа хөөе гэж бодож явлаа. Дэмбээгийн чээжинд нэг их өгөөмөр өрөвч сэтгэл шуудайд хийсэн унгас шиг цэндийж байх шиг санагдана. Тэр буцаж очоод жингийн даамал Дандий, хөтөч Гэпил хоёрт, өөрийгөө хэтэрхий элэг барьж, хурууны үзүүрт ялимгүй юманд зарлаа хэмээн хэлэх хэлэхгүй үгээр дайрч, бухимдаж хорссон сэтгэлээ тайлна хэмээн санаж яваагаа ч мартаж орхисон байлаа.

Бутат хөндлөн гүвээ нуруу дамнан бор толгод шар хөндийгөөр хөвөрсөн халзан замд гарсан нэг гал жингийн цуваа гурав дахь буудлаа буугаад байтал ийм нэгэн явдал болжээ. Хөтөч Гэпил өглөө тэмээ мал, ачаа сэлтээ болгоож явснаа “Ээ хайрхан минь” хэмээн нэг дуу тэнгэрт , нэг дуу газарт хадаан төдөлгүй майхны амаар нүд нь орой дээрээ гарчихсан “Өнөө гайхал чинь бас хүрээд ирчхэж” гэснээ “Ямар гай дагаад байна аа та минь” гээд эргэжээ. Чингэхэд нь Дандий, Дэмбээ хоёр гайхан босож гарвал, Гэпил ачаа бараа руугаа сэмээрхэн нударгаа далбагануулан заагаад үг хэлэхгүй цаашаа харайх нь тэр. Мань хоёр түүний заасан зүг рүү нь хартал, Гэпил тээр тэнд цэрвэн зогсоод “Цаад... өнөө гурав дахь тэмээний дээр...” гээд бас л хэдэн алхам чанагшлан зогсжээ.

Хоёр жинчин Гэпилийн зааснаар шорыг нь унагаж мулталсан ачаан дээр очвол, үнэхээр нэг урт хорхой мушгиран хэвтээстэй, тэдний бараанаар толгойгоо цогнойлгон хэлээ гялалзуулж байлаа.

Чингэхэд нь хэзээний гүжир, гүндүүгүй Дэмбээгийн дүрсгүй зан хөдөлж, мөнөөхөн урт амьтныг шилэн дээрээс нь чимхэж, Гэпил рүү гүйх агаад, цаадах нь бут дэрсэн дундуур таварсан тэмээ шиг дэнтэй дунтай харайн холдоод, “Чамайг наашаа ахиад дөхдөг юм бол данхар толгойгий чинь хагалаад өгч дөнгөнө шүү, шидэл минь” гэснээ газраас барьцтай аргагүй чулуу шүүрэн авч, нэг гараараа ум хумгуй шороо цацан “Чи наадхаа хаяна уу, үгүй юү” гэж хашхирсаар байлаа. Гэпил урт хорхойн бараа харж чаддаггүй, айж эмээдэг ажээ. Дэмбээ нөхрөө айлган ойрдоо инээгээгүйгээрээ инээж бах таваа ханган зогстол Дандий бүлтэн нүдээ аяганаас нь бүлт үсэрмээр бүлтгэнүүлэн сандарч “Хөөе дамшиг минь, наадхаа хараач“ гэв. Дэмбээ гартаа муригнах урт амьтнаа ажвал гэдсэн бие нь улаан нялга, хавирга нь гэрэлтэн харагдах шиг болоход нуруу нь хүйт оргиж үс нь өрвийх нь тэр. Тэр “Муугаа үзэх хүнд могой хөлөө үзүүлдэг юм” гэсэн үг дуулснаа санаж бие сэтгэл нь дорхноо донсолжээ. Тэгээд “Надад хавирга нь харагдав уу, хөл нь харагдав уу“ хэмээн сэжиглэн ширвэтэж өнөөх амьтнаа тавих байх газраа олж ядан байтал Дандий “Үгүй хө, ингэтлээ мөлхөх гэж...хавирга нь хэрзийж байх шив ээ. Газар тавиач, зовсон амьтны үйлийг нь үзэж байх” гэж сандран өгүүлэхэд Дэмбээ сая гартахаа газар тавибал өнөөх нь нөгөө л хэвтэж байсан ачаа руугаа хөдөлж цөхөн мөлхжээ. Тэгэхэд нь Дандий “Базарваань хум пад... хүйтэн цустай амьтныг хөөрхий ингэж болдог юм болов уу. Наадах чинь хөө зүдэж яваа амьтан байна даа” гэв. Дэмбээ гэмшсэн ч юм шиг бас сэжиг сүжгийн манан сэтгэлдээ хөшилдүүлэн алмайрч байтал Дандий дахиад “Энэ ер нь нэг жиг ургалаа шүү. Гурван шөнө нэг тэн дээр ирж хонодог. ...нэг жиг байна даа хө” гэснээ бүлтэн нүдээ дүрлэгнүүлэн бөхийж “Арай бид зулзагыг нь тээж яваа юм биш байгаа даа, аль чи нааш ир, үүнийг тайлж үзье” гэжээ. Хоёул шалбалзан баглаатай ачаагаа задлан үзвэл үнэхээр нэг адасганы завсар сурны өөдөс шиг гурван бор юм үрчилзэн хөрвөж байлаа. Мань хоёр адасгатай нь урт хорхойдоо дөхүүлэн тавибал цаадах нь элэг гэдсээ нялга болсноо ч үл анзааран тэмүүлэн очиж мушгиран эвхэрчээ. Дандий хөлстэй духаа ханцуйгаараа шудран арчаад “Ваа зайлуул... үрт амьтан гэдэг...” гэж уулга алдаад “Дэмбээ минь чи л наадхаа аваад мордохоом...нутгийн чулуу төөрүүлж болохгүй...Оорцог хайрханы амьтан байлгүй...тэр аяараа лус ч байгаа юм бил үү? Үхтэл үр гэж энэ дээ...ийм нүдэнд зэвүүн амьтнаас, тийм хүч тэнхээ, зөөлөн сэтгэл гарна гэдэг...хүнд ярихад нь үнэмшимгүй юм...явж үз! Бидэнд хараал хорлол цацах юм бил үү. Хэлэх ч юм биш” гэж адган өгүүлэв. Дэмбээгийн сэтгэлд нэгэн зуур “Юун ч сүржин юм. Энд нь орхичихно биз” гэж бодсоноо, өөртөө дэм эрэх санаатай Гэпил рүү харвал цаадах нь тээр тэнд овойж товойгоод сууж байлаа. Чингэхэд нь эгдүүцэн түүн рүү хэд хялалзаад өнөө урт амьтан руугаа харвал тэр өөдсийн чинээ үрээ өмөөрч хамгаалах аятай нүдээ гялалзуулан, хэлээ бултализуулан, ууртай эвхэрч байлаа. Дандий түүнийг нь ухаарсан янзтай толгойгоо бөнжигнүүлэн сэгсэрч “Түргэлж үз хөл хөнгөнөөр нь миний хар атаар яв” гээд хот орон газар сольж өмсөх дээл хувцас хийсэн хурганы уутаа суллан өнөө урт хорхойгоо зулзагатай нь хийх гэж Дэмбээг нудран ханджээ. Тэгээд л Дэмбээ уул мэт хар ат унаалан замд гарч зорьсноо бүтээгээд буцаж байгаа нь энэ ажээ. Дэмбээ атан тэмээнийхээ зөөлөн явдалд бүүвэйлэгдэн юундаа ч ялыгүй юманд зарагдлаа хэмээн гоморхож явав гэж, харин ч үрт хүний үйл бүтээсэн хүний цатгалан халуун царай гэрэлтүүлэн явлаа.

/С.Дашдоров/

1. Дараах хэлц үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийн дугаарыг сонгоорой.

1. Элэг барьж	a. Морь малын ялгуун гавшгай
2. Бах таваа ханган	b. Яаруу сандруу
2. Ум хумгүй	c. Бусдын мууд сэтгэл ханах
3. Нүд нь орой дээрээ гарчихсан	d. Ихэд сандрах, айн балмагдах
4. Хөл хөнгөн	e. Бусдыг басамжлан дээрэлхэх

A. 1c2e3b4a5d B. 1c2a3b4d5e C. 1e2c3b4d5a
D. 1a2b3c4d5e E. 1e2c3a4d5b

2. “Дэмбээгийн чээжинд нэг их өгөөмөр өрөвч сэтгэл шуудайд хийсэн **унгас** шиг цэндийж байх шиг санагдана.” -өгүүлбэрийн онцолсон үгийн утгыг олоорой.

A. Сагаг B. Саваг C. Ноос D. Ноолуур E. Хөөвөр

3. Дэмбээ нэг л их ёс төртэй үйл бүтээсэн мэт тээхийн зогссоны учир юу вэ?
   A. Үрт хүний үйл бүтээсэн учраас
   B. Нутгийн дээс алхсан учраас
   C. Жингийн даамал Дандийн захиасыг биелүүлсэн учраас
   D. Дандий, Гэпил хоёрт бухимдаж хорссон сэтгэлээ тайлсан учраас
   E. Гэпилийн айдсыг холдуулсан учраас

4. Эхийн гол санааг илэрхийлсэн тулгуур өгүүлбэрийг олоорой.
   A. Оорцог хайрханы амьтан байлгүй.
   B. Ваа зайлуул...үрт амьтан гэдэг...
   C. Үхтэл үр гэж энэ дээ...
   D. Тэр аяараа лус ч байгаа юм бил үү? E. Нутгийн чулуу төөрүүлж болохгүй.

5. "Гэпил урт хорхойн бараа харж чаддаггүй, айж эмээдэг ажээ" гэсэн өгүүлбэрийн санаанд үл тохирох хэсгийг олоорой.
   A. Гэпил ачаа бараа руугаа сэмээрхэн нударгаа далбагануулан заагаад үг хэлэхгүй цаашаа харайх нь тэр.
   B. Гэпил тээр тэнд цэрвэн зогсоод "Цаад... өнөө гурав дахь тэмээний дээр ..." гээд бас л хэдэн алхам чанагшлан зогсжээ.
   C. ...цаадах нь бут дэрсэн дундуур таварсан тэмээ шиг дэнтэй дунтай харайн холдоод...
   D. "Муугаа үзэх хүнд могой хөлөө үзүүлдэг юм" гэсэн үг дуулснаа санаж бие сэтгэл нь дорхноо донсолжээ.
   E. ...өөртөө дэм эрэх санаатай Гэпил рүү харвал цаадах нь тээр тэнд овойж товойгоод сууж байлаа.

6. Могойг нутагт нь буцаах болсны учир нь зохиолын аль хэсэгтэй холбоотой вэ?
   A. Гэпил урт хорхойн бараа харж чаддаггүй, айж эмээдэг ажээ.
   B. Муугаа үзэх хүнд могой хөлөө үзүүлдэг юм.
   C. Дэмбээ гэмшсэн ч юм шиг бас сэжиг сүжгийн манан сэтгэлдээ хөшилдүүлэн алмайрч байтал...
   D. ...нутгийн чулуу төөрүүлж болохгүй...
   E. ...цаадах нь элэг гэдсээ нялга болсноо ч үл анзааран тэмүүлэн очиж мушгиран эвхэрчээ.

7. "Тэгээд л Дэмбээ уул мэт хар ат унаалан замд гарч зорьсноо бүтээгээд буцаж байгаа нь энэ ажээ" – өгүүлбэрийн дүрслэх ур маягийг тодорхойлоорой. A. Хар атыг уултэй зүйрлэн ихэсгэсэн.
   B. Хар атыг уул хэмээн ихэсгэн дүрсэлсэн.
   C. Хар атыг уулаар төлөөлүүлсөн.
   D. Хар атыг уул хэмээн тойруулсан.
   E. Хар атыг уултай адилтган ихэсгэсэн.

8. Эхэд дэвшүүлсэн асуудал буюу сэдэв нь юу вэ?
   A. Могойн тухай
   B. Эх амьтны тухай
   C. Жинчдийн тухай
   D. Лусын амьтны тухай
   E. Жин тээхэд тохиолддог явдлын тухай

9. Тухайн үйл явдалд дургүйцсэн өнгө аяс бүхий хэсгийг олоорой. A. Тэр аяараа лус ч байгаа юм бил үү?
   B. Лав ямар нэгэн шившлэг үг хэлдэг байх.
   C. Өнөө гайхал чинь бас хүрээд ирчхэж.
   D. Юун ч сүржин юм.
   E. Ямар гай дагаад байна аа, та минь.

10. Үгсийн утгыг ажиглаад бүгд могойн үйл хөдлөлтэй хэсгийг олоорой.
   A. Мурилзах, мушгиран, муригнах, мөлхөх, үрчилзэн хөрвөх, гулалзтал
   B. Мурилзах, мушгиран, муригнах, сөглөн, үрчилзэн хөрвөх, эвхрэх
   C. Мурилзах, мушгиран, муригнах, мөлхөх, сөөсийсөн, эвхрэх
   D. Мурилзах, мушгиран, муригнах, мөлхөх, үрчилзэн хөрвөх, эвхрэх
   E. Мурилзах, тээхийн зогсох, муригнах, мөлхөх, үрчилзэн хөрвөх, эвхрэх

2.1 **Дараах эхийн хэсгийг уншаад зөв бичих дүрмийн алдаатай 5 үг олоод, засаж бичээрэй. Алдаатай нэг үг олбол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо. [5 оноо]**

... Шавьдаа мамба дацангын хамбын олбогоо шилжүүлчихээд Ерлөгийн ууландаа гарч хөдөөлье байз. Дөчин жил хэнд ч ам нээгээгүй хадгалсан "Алтан жүн жор"-ынхоо нууцыг шавьдаа тайлсан маань онолоо. Баргийн маарамба дийлхээргүй энэхүү ганц тангийнхаа жорыг улаан буйландаа зуусаар ертөнцөөс хальвал нүгэл шүү дээ. Одоо энэ хүүгийн мөч богинодно уу гэхээс бурхнаас хайралсан ухаанаар бол маниас ч илүү.

2.1 **Дараах өгөгдлийг үргэлжлүүлэн эх зохион бичнэ үү. Бичихдээ эхийн сэдэв, агуулга, бүтэц, хэв шинж, найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл, уран дүрслэлээр баяжуулахыг зөвлөж байна. Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 150-180/**

"Хэвийн сайхан байсан ямар ч зүйлд бидний гар хүрэхэд л сүйрч сүйддэг тул хүмүүс аймшигт халдварыг тээж явдаг хэмээн үзэж болох нь ээ..."

Хувилбар 10

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ [20 оноо]

Нүнжиг

Үүрээр. Халуун хөнжил хуу татахад уулын сэрүүн цэнгэг агаар намайг тэврэн авна. "Эр хүн шиг эрвэлзэнэ ээ, хө. Морьдоо татах боллоо" гэх Цогоо ахын дуу сонсогдоно. Хэлтгий саран баруун уулын шил дээр очиж, цолмон хөөрчээ. Шүүдэрт ногоонд хөл нүцгэн гүйхэд уулын хүүшид таван алдын аргамжаатай бага зээрд намайг таньж, аяархан үүрсэнэ. Болжмор жиргэж, хөх агийн үнэр үүлэн сүүдэр шиг унана.

Наадмын замд. Цогоо ах хоёр загалаа хөтлөөд, морин цагаан шүд гарган "Бор борын бялзуухай"-г салхи сэвэлзтэл исгэрнэ. Унаж яваа урт борлог морь нь даага шиг багадаж харагдана. Би шагай зээрдийг хөтөлж, бага зээрд хантайргатай сул дагана. Маргааш яах бол гэхээс миний зүрх огшин амьсгал дээрдэнэ. "Хүний газар нэрээ хичээнэ. Морьдоосоо нүд салгаж болохгүй" гэж Цогоо ах захина. Наадмын замд явахад газар дэндүү холдож, уулс хэтэрхий томдож үзэгдэнэ.

Наадмын 2 дахь өдөр. Инээхийн дон туссан Цогоо ах, хоёр зээрдийн хооронд хотонгийн хошуун хусуураа барин гүйж, "хөдөлгө хөдөлгө" гэж бахардан хэлнэ. Би бага зээрдээ хөтлөн тойрон шавсан олны дундуур зай гарган явахад гайхан биширсэн түмэн харц өвдөг чичрүүлнэ. Хоолой арган нүдэнд чийг даана. “ Бугатын хоёр зээрд , “Өчигдөр их насанд удаа ташаа түрүү магнайлсан хоёр загалын дүү морьд юм гэнэ ээ” гэх үгс чихэнд там тум атлаа цээжинд яруу.

Монгол эр, хүлэг морь хоёр аз баярын тэнгэр нэгтэй юм сан уу даа.

Наадмын нөгөөдөр. Намайг нутгийн уулс бараадуулж өгөөд Цогоо ах шагай зээрдээ хөтлөн зам салан давхиж одлоо. Будар будар тоос нь миний цээжинд суунаглана. Аргагүй шүү дээ, миний ах биш юм чинь. "Эрхэлж дагадаг бага зээрд минь танихгүй хүнд хөтлүүлэн хаа газар янцгааж яваа бол" хэмээн санахад би дотуур мэгшинэ. Их хоёр загал ч гэсэн дээ. Буга хайрханыхаа мөнх цасан усаар ундаалж өссөн болохоор бусдын газрын ногоо нь хүртэл амнаас унаж байгаа биз. Цогоо ахын түнтгэр хар түрийвч ямар үнэртэйг мэддэг болов уу. Уг нь Цогоо ахын л үнэр шүү дээ. Гэртээ харина гэхээс газар дэндүү ойртож, уулс хэтэрхий намсана. Дүү нартаа авсан хайрцаг ёотон хавирга холгоно.

Сар өнгөрлөө. "Хэнхэр Цогоогийн азаргатай адууг Цахирын хясаанд аянга ниргэчихэж гэнэ. Юм мөн ч нарийн учиртайяа. Хайран сайхан хурдан удмын адуу. Хэнхэр Цогоод хүлгийн тэнгэр аргагүй л гомдож дээ" гэж хөгшид хөөрөлдөн, буурал толгойгоо сэгсэрнэ. Шагай зээрд нь яасан бол гэж асуух гэвч өвгөдөөс далдирна. Ижилдээ ганц хурдан хүлэг үлдсэн юм сан. Хүлгийн тэнгэр гэдэг нь нүдтэй болов уу, үгүй болов уу гэж бодоход тарвага хошгирч, царцаа шаргин, нохой хуцаж, сэтгэл үймүүлнэ.

Тэр нэгэн шөнө. Аав, Цогоо ах хоёр халамцуухан ярилцаж суув. Ээжийн цайны ааг ханхална. Би тоононы даага тэгнэсэн хоёр цагаан одыг ширтэн, алин дээр нь хүлгийн тэнгэр байдаг бол гэж бодно. "Хүний буян худгийн ус хоёр хэмжээтэй дээ" гэж аав хэлнэ. "Яадаг юм надад мөнгө хэрэгтэй. Нутгийн та нар л намайг ойлгохгүй болохоор би хаачих болж байна. Би уг нь захчины нутгаас нэг хүүхэн босгож ирэх гэсэн юмсан. Сайн ч хүний үр, сайхан ч хүүхэн. Хүний тийм үрийг авчраад би янгиа тохуулж, ямбуу эдлүүлж, адсага унуулахгүй гэсэндээ л гурван морио зарсан юм. Би хүнээ бодох уу, адуу бодох уу" гэж Цогоо ах цээж түрэхэд уулын чинээ хар сүүдэрт нь унийн толгой үзэгдэхгүй болно.

Намайг дахин сэрэхэд. Тооно тэгнэсэн хоёр од хэлтийжээ. "Шагай зээрдэд хэчнээн их үнэ хаясан гээч. Гэтэл энэ борхүү уйлаад салдаггүй. Ерөөсөө эхлээд л загалаа хүнд өгөхөд мэлтэлзүүлж эхэлсэн юм. Аргадаж, аашилж ядлаа. Сүүлдээ бүр дотор эвдрээд... Тэгээд шагай зээрдээ аваад үлдсэн юм. Тэгтэл арван найман адууг минь хүйгээр нь аянга ниргэчихсэн мөртөө ганц шагай зээрд зүгээр шүү. Нөгөө хэдийгээ санадаг ч юм уу, адгуусны зөн ч юм уу, адуу захлаад, салж зогсоод нэг л биш байсан юм" гэх Цогоо ахын дуу сонсогдоно. "Эр хүний гундаж, гонсойж явах өдрийн алийг тэр гэхэв дүү минь" гэж аав сэтгэл засна. Тэгснээ дууллаа.

“Талын шар цэцэг нь Сайхан нарандаа гандана” гээд л Цогоо ах, аав хоёр хоолой нийлүүлэн цангинуулахад эрхлэн дагадаг бага зээрдийн минь мэл хар нүд тоонон зайцаар харагдаж, цоргио хонгор янцгаалт нь уулын чанадаас сонсогдов. Ай хөөрхий. Сайхан нарандаа гандах заяатай шар талын цэцэг ээ гэж...

Өглөө нь айргаар мялаалгасан юм шиг бэлгэт цагаан сортай, хана сайхан хавирга, хаан суудал ташаатай шагай зээрд морь манай шузганд уяатай байх юм гэж хэн ч санасангүй. Амгай зуузайд нь алд цэнхэр хадаг зүүгээд орхижээ. Шагай зээрд намайг танив уу, эвшээн тамшаагаад, толгойгоо өгөн маажуулах гэж шөргөөнө. Тэр тоолонд хадаг намирна. Мичид гудайлгаад мордсон Цогоо ах маань хаана дуулж яваа бол гэж санахад дуртмал нарны туяанд уул тал налайвч, тэртээ хөндийн хөх униар Хүүхэн хутагтын хөөсөн гучин гурван шаргын тоос уу гэлтэй балартан суунаглана. Бор бор бялзуухай нь босон суун жиргэнэ.

Тав хоног өнгөрөв. Цогоо ахыг ятгаж, шагай зээрдийг нь буцаахаар мордсон аавын бараа дурангийн аманд тодорч, тодрох тусмаа томорно. Дэргэтэл хатирах морины салхинд шагай зээрдийн зуузайн дахь цэнхэр хадаг дэрвэлзэнэ. Уяан дээр угтсан ээжид хэлсэн үгийг нь сонсвоос ирээд буцсаныхаа маргааш Цогоо ах сайхан захчин хүүхнийхээ нутаг руу аймаг дамжаад нүүгээд явчихсан байна гэнэ. Талд таана хэнзэлж, ууланд тошлог хүрэнтэж эхэлсэн тэр цагт орой дээрээ хоёр цохиотойМөстийн их нуруу, уужим суудалтай монгол эмээл шиг эзгүйрч харагдаж билээ. Д.Норов

1. **Дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийн дугаарыг олоорой**.

1. Уулын хүүш	a. Үрээр зүүн зүгт үзэгдэх хамгийн гэрэлтэй од
2. Хантайрга	b. Явах зорчиход бэрх хэцүү эгц өндөр, хадан хавцал
3. Хясаа	c. Шөнийн тэнгэрт тод харагдах оддын бөөгнөрөл
4. Цолмон	d. Морины жолоог сойж, эмээлийн бүүрэгт углан, хойд ганзаганд татаж уях
5. Мичид	e. Нар огт тусдаггүй, их сүүдэртэй газар

A. 1c2e3b4a5d
B. 1c2a3b4d5e
C. 1e2c3b4d5a
D. 1a2b3c4d5e
E. 1e2d3b4a5c

2. **Аль үйл явдлаас хойш тав хоног өнгөрөв?**
   A. Би шагай зээрдийг хөтөлж, бага зээрд хантайргатай дагана.
   B. Аав Цогоо ах хоёр халамцуухан ярилцаж суув.
   C. Дүү нартаа авсан хайрцаг ёотон хавирга холгоно.
   D. Хэнхэр Цогоогийн азаргатай адууг ... аянга ниргэчихсэн гэнэ.
   E. Намайг нутгийн уулс бараадуулж өгөөд ... зам саландавхиж одлоо.

3. **Монгол эр хүний нэр нүүрээ боддог нүнжигтэй занг батлах баримтыг олоорой.**
   A. Морьдоосоо нүд салгаж болохгүй" гэж Цогоо ах захина.
   B. Би бага зээрдээ хөтлөн тойрон шавсан олны дундуур зай гарган явахад гайхан биширсэн түмэн харц өвдөг чичрүүлнэ.
   C. Намайг нутгийн уулс бараадуулж өгөөд Цогоо ах шагай зээрдээ хөтлөн зам салан давхиж одлоо.
   D. ... Хүний тийм үрийг авчраад би янгиа тохуулж, ямбуу эдлүүлж, адсага унуулахгүй гэсэн юм.
   E. Цогоо ах сайхан захчин хүүхнийхээ нутаг руу аймаг дамжаад нүүгээд явчихсан.

4. **“Ай хөөрхий. Сайхан нарандаа гандах заяатай шар талын цэцэг ээ гэж...” өгүүлбэрийн өнгө аясыг тодорхойлоорой.**
   A. Цогоо ахыгаа морио зарсанд дургүйцсэн
   B. Аав, Цогоо ах хоёрыгоо дуулахыг сонсоод бахархсан
   C. Ургаж төлжсөн бүхэн унаж, мөхөх тавилантайг ойлгож санааширсан.
   D. Хүлгийн тэнгэр нүдтэй байдаг болов уу гэж эргэлзсэн
   E. Эрхэлж дагадаг бага зээрдээ санаж, өрөвдсөн.

5. **“Зохиолын эхлэл болон төгсгөл хэсэгт болж буй үйл явдлын цаг хугацааг ажиглаад тохирох хэлцийг олоорой.**
   A. Цаг цагаараа байдаггүй, цахилдаг хөхөөрөө байдаггүй.
   B. Нохой хэлээ гаргах үед хийгээгүйг тахиа хөлөө өргөх цагт хийх
   C. Нүүдлээр зусвал сэрүүн, суудлаар өвөлжвөл дулаан
   D. Хүйтний ам цаашилж, хөхүүрийн ам наашлах
   E. Ханан гэр холдож, хадан гэр ойртох

6. **“ Уралдсан морьд нь түрүүлснийг аль хэсэгт дүрсэлсэн байна вэ?**
   A. Наадмын хоёр дахь өдөр
   B. Наадмын нөгөөдөр
   C. Сар өнгөрлөө

D. Тэр нэгэн шөнө.
E. Намайг дахин сэрэхэд

7. **Хэтрүүллийн жишээг олоорой.**
   A. Ижилдээ ганц хурдан хүлэг үлдсэн юм сан.
   B. Унаж яваа урт борлог морь нь даага шиг багадаж харагдана.
   C. Хүний буян худгийн ус хоёр хэмжээтэй дээ.
   D. Тооно тэгнэсэн хоёр од хэлтийжээ.
   E. Орой дээрээ хоёр цохиотой Мөстийн их нуруу, уужим суудалтай монгол эмээл шиг эзгүйрч харагдаж билээ.

8. **Эхэд ямар сэдэв буюу асуудлыг дэвшүүлэн тавьсан байна вэ?**
   A. Наадмын тухай
   B. Унаач хүүгийн тухай
   C. Монгол морь, хүн хоёрын тухай
   D. Уяач хүний тухай
   E. Наймаа арилжааны тухай

9. **Дээрх эхийн гол санааг илэрхийлэх жишээ аль вэ?**
   A. Наадмын замд явахад газар дэндүү холдож, уулс хэтэрхий томдож үзэгдэнэ.
   B. Эр хүний гундаж, гонсойж явах өдөр олон.
   C. Талын шар цэцэг нь сайхан нарандаа гандана.
   D. Монгол морь, монгол эр хоёр аз баярын тэнгэр нэгтэй.
   E. Орой дээрээ хоёр цохиотой Мөстийн их нуруу, уужим суудалтай монгол эмээл шиг эзгүйрч харагдаж билээ.

10. “ Тарвага хошгир-, царцаа шарги-, нохой хуц-, болжмор жиргэ- ...” зэрэг холбоо үгстэй нэг утгын зүйлчлэлд багтах холбоо үгийг олоорой.
   A. Хоолой арга-
   B. Өвдөг чичир-
   C. Хавирга холго-
   D. Би мэгш-
   E. Адуу үүрс-

ХОЁРДУГААР ХЭСЭГ [30 оноо]

2.1 Дараах эхийн хэсгийг уншаад зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай 1 үгийг олбол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо. [5 оноо]

... Хар багадаа хурга хариулж яваад, ээжийн даллахыг харах мөн ч сайхан сан. Хурганаас ирэхэд сэнжтэй төмөр аяганд будаатай унд хийж, тависныг хүртэхэд ёстой гоё.
Ээж уулга алдахдаа “Цөг”, өөрийгөө чамалсан үедээ “ Буруу хойшоо” гэж хэлдэг.
Анх сургуульд орсон намар “Гадаа дуу нь гарах шиг санагдаад хардаг байж билээ. Тэгэхэд шонгын хэцэн дээр бялзуухай жиргэж байдаг” гэж ээж минь хэлдэг сэн. Гэрийн хамаг ажилыг хийдэг болхоор сумын наадамд явах завдал ээжид олддоггүй байв...

Ташаарсан нь	Залруулсан нь

2.2 Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. [5 оноо]



.....
....
....
....
....
....
.....
.....

2.3 Дараах сэдвээр эх зохион бичихдээ бүтэц, хэв шинж, сэдэв, агуулгын харьцаа болон найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглаарай. Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 150-180/ [20 оноо]

Ухаарал

Хувилбар 5

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ [20 оноо]

Ингэн нулимс

Усан бар жилийн зун нь гэлцдэг юм. Дулам гуайнх, манайхан гурван гэрээрээ Сайн-Усны баруухан хойно байсан юм даг. Малаа услах гээд манайхан голдуу нар битүү эртэлнэ. Харин хөл хүндтэй Эрдэнэ-Зул эгч бид хоёр аргал түүж, ботго, тугал эргүүлэх ажилтай үлдэнэ. Аргал түүхийгээ адуунд явна гэж ярьдаг сан. Адуунд явах болоход тэдний хайдаг ингэ Эрдэнэ-Зул эгчийг заавал дагана.

Ботгоо эндэж осолдсоноос хойш ганцхан хүний аясаар гаршиж саалгадаг байсных юм уу, гаравч оровч үүдэн хавьцаа эргэлдэж намуухан гунганан чимээ өгнө. Харахад тэмээ болохоос биш, ханан ширээ бөхнийхөө доор утаагүй шатсан галт уул, хайлган нулимсандаа зогдроо нэвтэлсэн уяхан ятга байсан юм. Ижил сүрэг нь зэрэглээ гишгэлэн алслахад саахалтын газар аргамжаатай юм шиг эргэцэж, саамшсан дэлэнгээ чинэрүүлэн тэшиж алдан ирэхдээ Эрдэнэ-Зул эгчийн цэнхэр алчуурыг нэгэнтээ үнэрлэн уужирч хөл хойш талибуун өег цатгалан хивсээр шаагитал ивлэнэ. Өөр хүнд бол ганц үнэрлээд тас тийрч самсаа нь сарталзан холдоно.

Эрдэнэ-Зул эгчийг нэг удаа эзгүйд манай ээж цэнхэр алчуурыг нь зангидаж, саах гэж гараад орж ирэхдээ “Хөөрхий дөө, алчуур үнэрлээд яг л хүн шиг санаа алдаж, дутуу зуурам ивлэсэн боллоо. Үйлийн хорвоод хагацал амсахын эрхээр үйгүйг бийд бодож сэтгэлээ хуурах гэдэг малд ч гэлээ ямар хэцүү юм бэ” гэж билээ. Горьдлого үл тасрах ингэний нулимстай нүдээр хэрэв харах юм бол Эрдэнэ-Зул эгч эргүүлэг уяандаа тогтож ядан тэмүүлэх энхэр цагаан ботго ч болж харагддаг ч юм бил үү, хэн мэднэ...

Аргал түүж явахдаа заримдаа миний зүггүй зан хөдөлж Эрдэнэ-Зул эгчийг элдвээр шоглох маяг үзүүлнэ. Хайдаг ингэ амандаа өвс зуулттай хэвээр тэшин тэшин ирэхдээ нүд нь алаглан эргэлдэж, шүд нь орсон буур адил хангинан чээж хүржгэнүүлнэ. Намайг холдохоор санаа амарсан янзтай тэрүүхэндээ идээшилнэ. Тэгж харамлахыг үзэх гэж би өдөрт хэчнээн ч удаа үйлийг нь үздэг байсан юм бэ дээ. Зоргоор бага насны эрхийн халуундаа шатаж, зовлонгоор тоглож болдоггүйг чихэр гэж эндүүрсэн давс дааанч олон жил амтагдсан даа. Шүтэлцээ үл тасрах чандмань мэт бие биедээ холбоотой ийнхүү гурван амьтан Сайн-Усны дэнж дээр тогоруу шиг өнжинө. Би алаг цахиур түүж, энгэр задгай цамцандаа салхи татуулан эрээн бутны эрвээхийтэй хөөцөлдөж, эрвээхий бус нар атгаж хоцорсондоо элгээ хөштөл инээнэ. Эгч, араг дүүрэн мөнгөн баавар шиг аргал түүж гунигийн хөнгөн манантай тогтуухан алаг нүдээрээ хааяа нэгхэн инээмсэглэн,

“Оонын хоёр эврийг

Ороож барьж болдоггүй ээ хө

Орчлон хорвоогийн жамаар

Ор л үгүй тойрч болдоггүй ээ хө...” хэмээн дуулж надаас нууцхан санаа алдана. Хэзээ ч билээ энэ дууг Дэндэв гуайн найран дээр бас Дамбий хувилгаан гэгч, ялимгүй халамцуухан дуулж байсныг үзээд тойрч болдоггүй, дайрч гардаг хорвоогийн жам гэж юу болохыг ухаарч ядан зогсож билээ.

Нэг орой саахны хурга зөрүүлчхээд иртэл Дулам гуайн үүднээс ер үзээгүй сонин хачин чийчаан оройн наранд гял цал ойлгон хөдөлж дэргэдүүр эргэлээ. Арын суудлын цонхоор ЭрдэнэЗул эгчийн нүүр цухасхан үзэгдэж, хоолой нь зангиран нэг юм хэлэх шиг болоод нар салхинд онгошсон эгчийн танил содон үнэртэй цэнхэр алчуур утаа тоосон дундаас мөрөн дээр тунаран үлдлээ.

Би яах ч ухаанаа олохгүй, манайхан ч газар хөдөлж орох оронгүй болсон мэт балмагдан бүгд гаднаа. Саамшсан дэлэн хөх нь сарвайж сүүн гуя хасаа даган өөрийн эрхгүй асгарсан хайдаг ингэ л харин алтан хумс, дөрвөн тавхайгаа халтал хойноос нь бөн бөн тэшиж нэг үзэж, хошлонгоосоо зууран сөхөрч үлдсэн Дулам гуайд хоргодоо юм уу эргэж нэгэн тэшиж... тэр оройн үндэс бүхэн нялхарч билээ...

Хувилгаан Дамбийг үр үндсээр нь устгасан гэх тэр нэгэн цаг, ар хөндлөн булаг Сайн-Усны хөндийн цахилдаг бүхэн цэнхэр алчуур алдуурсан мэт цоморлигоо дэлгэн аргадсан ч ангирын халиун дэгдээхий усандаа дэлхэн буух дэлгэр зуныг хугаслан хайдаг ингэ зовсон сүүгээ татаж, амарлингуй тунгалаг нүдэндээ уй татсан уярлын халуун нулимстай зэрэглээ сэмэртэл буйлсаар Хөх-Усны ширээг хотойтол хэчнээн удаа ч бөн бөн тэшлээ дээ.

Оонын хоёр эврийг ороож барьж хэрэв болдог сон бол амьдын жаргалыг амсах байсан юм биш байгаа Эрдэнэ-Зул эгч минь, орчлон хорвоогийн жамыг гажиж хэрэв болдог сон бол ангир уургаа залгилах байсан юм биш байгаа, энхэр цагаан ботго минь.

/ А.Шартолгой /

1. Дараах хэлц үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийн дугаарыг сонгоорой.

1. Хөл хүндтэй	a. Сэтгэл тавгүйдэх
2. Санаа амарсан	b. Ихэд зовоох
3. Үйлийг нь үздэг	c. Тайвшрах
4. Элгээ хөштөл	d. Маш их инээх
5. Санаа алдаж	e. Жирэмсэн

A. 1c2e3b4a5d B. 1c2a3b4d5e C. 1e2c3b4d5a
D. 1a2b3c4d5e E. 1e2c3a4d5b

2. “Эрдэнэ-Зул эгчийн цэнхэр алчуурыг нэгэнтээ үнэрлэн уужирч хөл хойш талибуун өег цатгалан хивсээр шаагитал **ивлэнэ.**” -өгүүлбэрийн онцолсон үгийн утгыг олоорой.
A. Хүн, амьтны хөх дэлэнд сүү ихээр хуралдах
B. Хүн, амьтны сүү саамшин хөхөндөө бууж ирэх
C. Хүн, мал, амьтны дэлэн хөхийг шувтарч сүү гаргах
D. Хүн, амьтны үр зулзага эхийнхээ хөхийг шимэн сорох
E. Сүү гарахаа болих

3. “Оонын хоёр эврийг Ороож барьж болдоггүй ээ хө
Орчлон хорвоогийн жамаар

Ор л үгүй тойрч болдоггүй ээ хө...” хэмээн Эрдэнэ-Зул дуулчхаад нууцхан санаа алдсаны учир юу вэ?

A. Аргал түүх нь гунигтай ажил учраас
B. Эр нөхрөө алдсан учраас
C. Хайдаг ингээ өрөвдсөн болохоор
D. Дууны утга нь санаа алдахад хүргэсэн
E. Өөрийг нь хөл хүндтэй байхад орхиод явсан нөхөртөө гомдоод

4. Эхэд дэвшүүлсэн асуудал буюу сэдэв нь юу вэ?
   A. Хагацлын тухай
   B. Хайдаг ингэний тухай
   C. Хэлмэгдүүлэлтийн тухай
   D. Эрдэнэ-Зул эгчийн тухай
   E. Хүн ба амьтны холбоо

5. Эхийн гол санааг зөв тодорхойлсон хэсгийг олоорой. A. Ботгоо алдсан ингэний зовлон барагдахгүй.
   B. Хэлмэгдүүлэлтийн хор уршиг их.
   C. Тойрч болдоггүй, дайрч гардаг хорвоогийн жам бол хагацал юм.
   D. Эрдэнэ-Зул эгч сэтгэлийн хаттай хүн.
   E. Хүн ба амьтны холбоог үгээр илэрхийлэхийн аргагүй.

6. Хайдаг ингэ Эрдэнэ-Зулыг **харамлахдаа** ямар ямар үйлдэл хийдгийг эргэцүүлээд зөв дугаартай хэсгийг сонгоно уу.
   1. Адуунд явах болоход тэдний хайдаг ингэ Эрдэнэ-Зул эгчийг заавал дагана.
   2. Хайдаг ингэ амандаа өвс зуулттай хэвээр тэшин тэшин ирдэг.
   3. Эрдэнэ-Зул эгчийн цэнхэр алчуурыг нэгэнтээ үнэрлэн уужирч хөл хойш талибуун өег цатгалан хивсээр шаагитал ивлэнэ.
   4. Нүд нь алаглан эргэлдэнэ.
   5. Хайдаг ингэ зовсон сүүгээ татсан.
   6. Шүд нь орсон буур адил хангинана.
   7. Чээж хүржгэнүүлнэ.
   8. Зэрэглээ сэмэртэл буйлсан.

   A. 2, 4, 6, 7 B. 1, 2, 4, 6 C. 2, 3, 6, 8
   D. 3, 4, 5, 6 E. 4, 5, 6, 7

7. Их хэлмэгдүүлэлтэд нөхрөө алдсан гэдгийг нь батлах баримт аль вэ?
   A. Оонын хоёр эврийг ороож барьж хэрэв болдог сон бол амьдын жаргалыг амсах байсан юм биш байгаа Эрдэнэ-Зул эгч минь
   B. Арын суудлын цонхоор Эрдэнэ-Зул эгчийн нүүр цухасхан үзэгдэж, хоолой нь зангиран нэг юм хэлэх шиг болоод
   C. “Оонын хоёр эврийг Ороож барьж болдоггүй ээ хө
      Орчлон хорвоогийн жамаар
      Ор л үгүй тойрч болдоггүй ээ хө...”
   D. Хувилгаан Дамбийг үр үндсээр нь устгасан
   E. Хэзээ ч билээ энэ дууг Дэндэв гуайн найран дээр бас Дамбий хувилгаан гэгч, ялимгүй халамцуухан дуулж байсан.

8. “Хөөрхий дөө, алчуур үнэрлээд яг л хүн шиг санаа алдаж, дутуу зуурам ивлэсэн боллоо” хэсэгт сэтгэлийн ямар өнгө аяс илэрч байна вэ?
   A. Өхөөрдсөн
   B. Энхрийлсэн
   C. Дорд үзсэн
   D. Бахархсан
   E. Өрөвдсөн

9. Дүрслэх ур маягийг зөв харгалзуулаарай.

1. ...ханан ширээ бөхнийхөө доор утаагүй шатсан галт уул	а. Төлөөлөл

2. …чихэр гэж эндүүрсэн давс дааанч олон жил амтагдсан даа.	b. Зүйрлэл
3. …араг дүүрэн мөнгөн баавар шиг аргал түүж	c. Адилтгал
4. …цоморлигоо дэлгэн аргадсан	d. Хүншүүлэл
5. … зэрэглээ сэмэртэл буйлсаар	e. Ихэсгэл

A. 1c2e3b4a5d B. 1c2a3b4d5e C. 1e2c3b4d5a
E. 1a2b3c4d5e E. 1e2c3a4d5b

10. Бүгд хайдаг ингэний санан гансарч, ганцаадсан байдлыг илэрхийлсэн хэсгийг олоорой.

A. Эрдэнэ-Зул эгчийг заавал дагана, амарлингуй тунгалаг нүдэндээ уй татсан уярлын халуун нулимстай, зэрэглээ сэмэртэл буйлсаар, Хөх-Усны ширээг хотойтол бөн бөн тэшсэн.
B. Зовсон сүүгээ татсан, хайдаг ингэ амандаа өвс зуулттай хэвээр тэшин тэшин ирдэг,, зэрэглээ сэмэртэл буйлсаар, Хөх-Усны ширээг хотойтол бөн бөн тэшсэн.
C. Намуухан гунганан чимээ өгнө, зовсон сүүгээ татсан, амарлингуй тунгалаг нүдэндээ уй татсан уярлын халуун нулимстай, Хөх-Усны ширээг хотойтол бөн бөн тэшсэн.
D. Зовсон сүүгээ татсан, амарлингуй тунгалаг нүдэндээ уй татсан уярлын халуун нулимстай, зэрэглээ сэмэртэл буйлсаар, Хөх-Усны ширээг хотойтол бөн бөн тэшсэн.
E. Самсаа нь сартлзан холдоно, зовсон сүүгээ татсан, амарлингуй тунгалаг нүдэндээ уй татсан уярлын халуун нулимстай, зэрэглээ сэмэртэл буйлсаар.

ХОЁРДУГААР ХЭСЭГ [30 оноо]

2.1 **Дараах эхийн хэсгийг уншаад зөв бичих дүрмийн алдаатай 5 үг олоод, засаж бичээрэй. Алдаатай нэг үг олбол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо. [5 оноо]**

... Энэ Дөшийн ус эгэл биш шүү. Жаахан уухлаар дуулмаар санагдаад байдаг юм. Орчлонгын ус уух заяа гэдэг энэ дээ. Ховоогоор биш, алтан аягаар л уумаар рашаан. Дааанч чи бид хоёрт алтан аяга байхгүй гэснээ,
–Хоёулаа худгийн амитай хүйтэн ус ууж жаахан дуулая л даа гэж надаас гуйна. Цэвэгийн хуурай согтож дуулхыг сонсох сон гэхдээ би ховоотой ус дундаа тавьчихаад айраг ууж байгаа улс шиг хоёр талаас нь ээлжлэн залгилна.

/ Б.Догмид “Ус уухын заяа” /

Ташаарсан нь	**Залруулсан нь**

2.2 **Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. [5 оноо]**



.....
.....
.....
.....
.....
.....
.....

2.3 **Дараах өгөгдлийг үргэлжлүүлэн эх зохион бичнэ үү. Бичихдээ эхийн сэдэв, агуулга, бүтэц, хэв шинж, найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл, уран дүрслэлээр баяжуулахыг зөвлөж байна. Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 150-180/ [20 оноо]**

“Орчин тойронд маань эрүүл хүмүүсийн хөгжилтэй царай ямагт харагдаж байгаасай гэж би хүсдэг...”

Хувилбар 6

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ [20 оноо]

Эвэр

Алтайн хүрэн цохионы нөмөрт хавсаргатай өдөр эхээс мэндэлсэн янгирын бор ишиг наран наашлах тутам хөрвөжин торниж, шөрмөс чангаран туурай хатахын хирээр толгой дээр нь хоёр газар товойж, арьс загатнах болов. Ишиг эхлээд яах гэж загатнаж байгааг үл мэдэн хаданд хааяа үрчхээд л ээвэр газар тагшин тоглож сүрэг даган тачигнаж явах бөлгөө. Удахгүй арьс загатнахаа болиод өвдөж эхлэв. Өвдөх нь өвчин биш зүгээр л нэг хүлээлт ч биш албан тушаал дэвших гэж байгаа хүнд дээд газрын шийд ирж өгөхгүй удах мэт аятайхан шаналгаа байлаа. Тэг тэгсээр товойсон газар нь үс халцарч арьс нимгэрсээр хоёр хөөрхөн эвэр цухуйв. Энэ үеэс л ишиг тэх болох гэж байгааг там түм гадарлан урт сүрлэг эвэртэй болохын дон тусчээ. Тэрээр цохионы орой дахь тогтоол уснаас уух бүрийдээ тугалмай нь бяджаагүй бяцхан эврээ харан харан чамлаж, тэр л өдрийнхөө талыг сэтгэл гунин өнгөрөөх болжээ.

Шүдлэн насанд эвэр нь овоо хэвээ олж дугуйран, хэдэн сайхан эржгэртэй болоод үзүүр нь шовхорч ирэв. Аргил тэхийн долоон төө эвэр, эцэг тэхийн таван төө эвэр гадаад анчны ганзага мялааж Берлин, Парис одсон болохоор эдүгээ бор халиун сүрэгтээ эхний дөрөвт орох болжээ. Энэ нь хэдийгээр шүдлэн ямаанд багадахааргүй байр суурь боловч сүрэг тэргүүлэх хүсэлд эрт донтсон залуу янгирт шившигтэй санагдана

Нэгэн өдөр янгирын сүрэг байрлал солих болж хавцлын ирмэг нарийн жимээр бэдрэв. Янгирын хуулиар бол ганц ганцаар цувран явах ёстой боловч эх янгир бор шүдлэнг туурай гүйцэд хатаагүй юм хэмээн хамгийн хавцал талаас нь түшиж явлаа. Удаан ургаж байгаа эвэр, ургаж ядсан цаг хугацаа хоёрыг зүхэн бухимдаж явсан залуу янгирын цус дээшээ огшин эврийн үзүүрт халуу оргин чинэрээд ирэв. Хадан хана руу *хадарч* орхивол яс тугалмай янгинан тархи дүйрээд уурандаа эргэж эхийн бөөр лүү сэжив. Санаандгүй явсан эх янгир ганц тэрсхийгээд хавцлын харанхуй руу пижигнэн одоход залуу янгир айсан ч үгүй, ичсэн ч үгүй, гэмшсэн ч үгүй гагцхүү яах гэж тэр хөгшин зөнөг цувж явалгүй зэрэгцэн чихэлдээд байсанд л баахан гайхаж, зай чөлөөтэй болсонд баярлах бөлгөө

Эхээ ольсон эврийн үзүүрт арьс үс шалбарч, дусал цус наалдаад байвч залуу янгирт анхаарч мэдэх зав байсангүй.

Харин хожим нь тогтоол уснаас уухдаа тольдон харахад тэр талын эвэр арай дотогшоо дугуйраад байгаа нь ажиглагдах болжээ. Хоёр өөр эвэртэй байх нь сүргийн тэргүүний сүр хүчинд сайнгүй ч гэсэн урт л ургаж байвал учиртай гэж тэр бодно.

Хоёр жил өнгөрлөө. Дахиад хоёр тэх ногоон мөнгөний золиосонд одож, бор халиун сүргийн тэргүүнтэн болоход ганц хуруу дутав. Гэвч түүнд тэргүүн болохын хүслэнгээс өөр нэг бодох юм бий боллоо. Юу гэвэл нөгөө дотогшоо дугуйрсан эврийн үзүүр явсаар чамархайд тулжээ. Яагаад тэгснийг тэрбээр яаж ч бодоод эс ухаарна. Эвэр хэдхэн сарын дотор араасаа хонхойлгон дарж өвтгөх болов. Тэгснээ арьс цоороод цус шүүс гоожиж ялаа батгана салахаа болилоо.

Залуу янгир дэндүү хурдан ургаж байгаа эвэр хайр найргүй довтолгох цаг хугацаа хоёрыг зүхэн бухимдавч эвэр хэдүйнээ маханд шигдэн оржээ. Бусдын эвэр толгой тойрон ургаж эсвэл дээшээ сэрийж байхад миний эвэр яагаад ? хэмээн тэрбээр шаналан бодовч хариу үл олдоно. Эвэр

ургасаар ясаа цоолов. Тэсгэлгүй өвдөхийн манан дотор "яагаад" гэсэн асуултын хариу төөрсөн янзага шиг сүүтийвч бие нь үл баригдана. Эвэр тархиндаа тулжээ. Тархины бор хальс цоорох хоромд л "Миний эвэр буруу ургажээ" гэсэн там тумхан ухаарал янгирын толгойд нэг орж ирээд үүрд замхарсан нь шувуу суунгуут үргэн нисэхийн адил
бөлгөө. / Ж.Лхагва /

1. Дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгуулсан хэсгийн дугаарыг олоорой.

1. Хавсарга	a) Нарны илч тусгал сайтай, нөмөр газар
2. Ээвэр	b) Амьтны эврийн доторх яс
3. Цохио	c) Хуурай хүйтэн салхи
4. Тугалмай нь	d) Онцгойдуу тогтсон өндөр хад
5. Чамархай	e) Духны хоёр хажуу тал

A. 1a3c2d4e5b B. 1c2a3b4e5d C. 1c2a3d4b5e
D. 1a2b3c4d5e E. 1d2c3a4e5b

2. “Гэвч түүнд тэргүүн болохын хүслэнгээс өөр нэг бодох юм бий боллоо” гэжээ. Үүний шалтгаан юу вэ?
   A. Толгой дээр нь хоёр газар товойж, арьс нь загатнах болов.
   B. Эхээ ольсон эврийн үзүүрт арьс үс шалбарч, дусал цус наалдаад байв.
   C. Хоёр өөр эвэртэй байх нь сүргийн тэргүүний сүр хүчинд сайнгүй.
   D. Дотогшоо дугуйрсан эврийн үзүүр явсаар чамархайд тулжээ. E. Тархины бор хальс цооров.

3. Ишигний хурдхан сүргийн тэргүүн болох сон гэх хүслийг батлах баримт нь аль вэ?
   A. Удаан ургаж байгаа эвэр, ургаж ядсан цаг хугацаа хоёрыг зүхэн бухимдаж явав.
   B. Эх янгир бор шүдлэнг туурай гүйцэд хатаагүй юм хэмээн хамгийн хавцал талаас нь түшиж явлаа.
   C. Залуу янгир дэндүү хурдан ургаж байгаа эвэр хайр найргүй довтолгох цаг хугацаа хоёрыг зүхэн бухимдав.
   D. ...Тэр хөгшин зөнөг цувж явалгүй зэрэгцэн чихэлдээд байсанд л баахан гайхаж, зай чөлөөтэй болсонд баярлах бөлгөө.
   E. Бусдын эвэр толгой тойрон ургаж эсвэл дээшээ сэрийж байхад миний эвэр яагаад? хэмээн тэрбээр шаналан бодовч хариу үл олдоно.

4. Сүргийн манлайлагч болоход ганц хуруу дутсан баримт нь аль вэ?
   A. Аргил тэхийн долоон төө, эцэг тэхийн таван төө эвэр гадаад анчны ганзага мялаасан.
   B. Сүрэгтээ эхний дөрөвт орсноос хойш хоёр тэх ногоон мөнгөний золионд явсан.
   C. Шүдлэн насанд эвэр нь хэдэн сайхан эржгэртэй болоод үззүр нь шовхорч эхлэв.
   D. Санаандгүй явсан эх янгир ганц тэрсхийгээд хавцлын уруу пижигнэн одсон E. Эвэр нь тархиндаа тулжээ.

5. “Бусдын эвэр толгой тойрон ургаж эсвэл дээшээ сэрийж байхад миний эвэр яагаад? хэмээн тэрбээр шаналан бодовч хариу үл олдоно.” гэсэн өгүүлбэрийн санаанд тохирох хэлцийг олоорой.
   A. Буруу замаар будаа тээвэл буцахдаа шороо тээнэ.
   B. Зүрхэнд нь орох
   C. Өнгөрсөн борооны хойноос цув нөмрөх
   D. Бодоод бодоод бодын шийр дөрөв
   E. Гэм нь урдаа гэмшил нь хойноо

6. Буруу ургасан эврийг юутай адилтгасан бэ?
   A. Буруу үйл B. Буруу бодол C. Буруу мөрөөдөл
   D. Буруу цаг хугацаа E. Буруу байр суурь

7. “ ... эх янгир бор шүдлэнг **туурай гүйцэд хатаагүй** юм хэмээн хамгийн хавцал талаас нь түшиж явлаа” гэсэн өгүүлбэрт онцолсон үгийн дүрслэх ур маягийг олоорой.

A. Төлөөлөл B. Адилтгал C. Тойруулал
D. Зүйрлэл E. Ёгтлол

B. Эхэд ямар асуудлыг дэвшүүлэн тавьсан байна вэ?
A. Буруу ургасан эвэрний тухай B. Эхийн хайр халамжны тухай
C. Алтайн хөх цохионы тухай D. Янгирын сүргийн тухай
E. Шунал хүслийн тухай

C. Дээрх өгүүллэгийн утга санаанд тохирох хэлцийг олоорой.
A. Ишиг эврээ ургахаар эхийгээ мөргөнө.
B. Өрөвдөхөд өр өшиглөнө.
C. Шунал ихэдвэл шулам болно.
D. Тусыг усаар, ачийг бачаар
E. Тэжээсэн бяруу тэрэг эвдэнэ.

D. Холбоо үгсийн утгыг ажиглаад эвэр ургасан явцын зөв дараалыг олоорой.
A. Чамархайд тулах, манахд шигдэх, ясаа цоолох, арьс цоолох, тархинд тулах
B. Тархинд тулах, ясаа цоолох, яамархайд тулах, маханд шигдэх, арьс цоолох
C. Ясаа цоолох, чамархайд тулах, тархинд тулах, манахд шигдэх, арьс цоолох
D. Чамархайд тусах, арьс цоолох, маханд шигдэх, яс цоолох, тархинд тулах
E. Маханд шигдэх, арьс цоолох, чамархайд тулах, яс цоолох, тархинд тулах

ХОЁРДУГААР ХЭСЭГ [30 оноо]

2.1 Дараах эхийн хэсгийг уншаад зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай 1 үгийг олвол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо. [5 оноо]

Гэдсийг нь хагаллаа
Гэзгийг нь таслалаа гэдэг доог хэлц

Эрт цагт нэгэн эрэлчин өөр хошууны үл таних айлд үдэш иржээ. Гэрийн эзэн морийг нь аргамжхаар одож, гэргий нь хоноцдоо дал дөрвөн өндөр, бор богтос тэргүүт бүхэл мах чанаж өгчээ.

Тарган маханд тааруу, ёс жаягт бүр ч маруу хоноц маань хальсийг нь хуулж тависан нэгэн богтос аваад залаанаас нь огтолтол тэр айлын ихэр хоёр жаал:

- Тэр ахыг хараач! Тэргүүнийг нь огтоллоо гэж дооголжээ.

Ташаарсан нь	Залруулсан нь

2.2 Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно.
[5 оноо]



.....
.....
.....
.....
.....
.....
.....

2.3 Дараах сэдвээр эх зохион бичихдээ бүтэц, хэв шинж, сэдэв, агуулгын харьцаа болон найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглаарай. Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 150-180/
[20 оноо]

Сайн санааны үзүүрт тос

ХУВИЛБАР 8

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ [20 оноо]

Саарал даага

Шувтаргын дөрвөн бөх цол гуншингаа дуудуулсаар сүртэйеэ дэвэн гарахад наадмын асар тойрон гийнгоолж байсан хурдан морьтой хүүхдүүд давхилдан өнгөрч байлаа. Тэдний дунд би нэгдлийнхээ хөөрхөн саарал даагыг аавааараа хөтлүүлэн явлаа. Ингэж хөтлүүлж явах нь надад эвгүй санагдавч хамаг амьтан ингэж байгаа юм чинь одоо яая гэх вэ дээ. Миний саарал даага манай нэгдлийн уяанд хамгийн бага нь, би өөрөө морь унаж яваа хүүхдүүдийн хамгийн жижиг нь. Тийм учраас хамаг амьтан бид хоёрыг өхөөрдөж байлаа. Миний унаж яваа саарал даагыг нэгдлийн хурдан хээрийн унага гэж мэдэх хэдэн адуучин мал бригадын дарга Гүнрэв гуай зэрэг хэдхэн хүнээс бусад нь сайн давхина гэж зүүдэлсэнгүй бололтой. Хурдан морь сайн таньдаг гэгдэх хэдэн хашир өвгөчүүл ч эхээ хөхөж байсан хэдэн бүдүүн даагыг л сайн давхина гэж амлацгааж байлаа. Тэд саарал зүстэй байхлаар нь хурдан хээрийн унага гэж мэдсэнгүй л дээ. Энэ хээр азарга манайд байхдаа олон жил дараалан түрүүлсэн юм. Нэгдэлд нийгэмчилснээс хойш ч жил бүр түрүүлж байгаа юм. Алс холоос морины хорхойтой хүмүүс ирж өндөр үнэ өгнө гэж хонуут өнжүүтээр шалаад аавыг залхаадагсан. Ойр хавийн морь уядаг хүмүүс аавд атаархаж тийм хурдантай болохын тулд хааяа манай адуунд ганц хоёр гүү авчраад тавьчихсан байдаг сан. Аавыг нэгдэлд хурдан хээр азаргаа нийгэмчлэхэд их л олон янзын яриа гарч билээ. Дорж хунз гэгч манайд согтуу ирээд аавыг элдвээр хэлж,

- Чи надад азаргаа өгсөнгүй. Очиж очиж нэгдэлд зүгээр өгчихнө гэнэ ээ! Заяагүй муу новш! Би чамд гаансан дээрээ дөрвөн бод нэмж өгье гэж мөн их гуйсан даа. Чиний муу хээр үрээг аваагүйгээр Дорж хунз хохироо ч уу, үгүй ч үү? Тэр сүйд болоод байгаа нэгдэл чинь чамайг яаж

гялайлгахыг харахсан гээд “Түй” гэж нулимаад жороо хараа халбилзуулж хоёр тал дээр ээлжлэн гарсаар хойноосоо хөөсөн нохдыг хайр гамгүй зодог одсоныг л лав тод санаж байна.

Аав минь одоо нэгдлийн тэргүүний малчин, энгэр дээр нь алтан гадас одон гялалзаж байгаа. Аавын минь одонг жижиг хүүхдүүд шохоорхон харахад би өөрөө одонтой юм шиг бахархаж явдаг. Нэгдэл, хөдөлмөр хоёр аавыг минь яаж гялайлгасныг Дорж хунз одоо ч харж явна. Тэр бас морь уяжээ. Түүний хурдны шинж бүрдсэн өндөр хээр даага өнөөдөр хүн бүхний харааг булааж байна. Түүнийг түрүүлнэ гэж ихэнх хүмүүс ярина. Дорж хунз өөрөө элбэг халхгар торгон дээл өмсөж, бүсэндээ зандан хусуур хавчуулжээ. Дааганд нь тийнхүү амьтны ам сайн байгаад Дорж хунз их л бардам явна. Дороос нухаж зовоомоор мөнгөн хэрэглэлтэй эмээл дээрээ хазгай сууж, тэнзэн ташуур хөндөлдүүлэн барьжээ. Үнэтэй торгон өмд, түрийнээс цухуйх цав цагаан соруултай гаансаа үзүүлэхийн тулд хормойгоо шуужээ.

Морь эргэх газар нэлээд зайтай, нар орой болж байгаа учир ширүүхэн явцгаалаа. Ергөх нь морины гэдэс зайлчихна гэж хашир хүмүүс голдуу цогиулах ажээ. Удалгүй морь эргэх тэмдэгт газар ирцгээхэд аав намайг хөтөлж нэлээд түрүүгээр гаргаад тавилаа. Морь тавьсан улсуудын морьд цөм л дааганаас хоцрохоргүй байсан боловч журмыг сахиж томчууд морьдынхоо амыг татав. Дорж хунз л ганцаараа хоцорсонгүй тэр даагатайгаа зэрэгцэн давхиж,

- Амыг нь сайн татаад ширвээд бай. Жаахан явуул... Жолоогий нь сулруулахгүй юу, муу мангуу ! гэх зэргээр дуу хадуулж явлаа.

Газрын дунд орж ирэхэд дааганууд цуварч эхэллээ. Би Дорж хунзын хээр дааганы дараах хоёр дааганы ард л яваад байлаа. Миний өмнөх хоёр даага бие биенийхээ өмнө гарах гэж тэмцэлдсээр байгаад хүч нь суларчихсан тул аяндаа саарлаас минь хоцрох нь тэр.

Би хэдэнтээ хүчтэй ширвээд хашхираад орхисон чинь хээр даагатай зэрэгцээд очлоо. Дорж хунз муухай муухай хялалзаж өөрийн хүүхдэд юм заасаар байлаа. Тэр хэдэн удаа хүүхдэдээ “Гарга!” гэж хашгирсан боловч миний саарал салсангүй, барианы газар саахалт хэртэй болж ирэхэд нэг гуядаад авлаа.

Буруу талаар нь хариугүй хошуу өлгөөд ирлээ. Түрүүлэхэд нь баярласан гэж хязгаар алга. Гэтэл дааганы минь хоншоор дундуур ташуурын сур тас буув.

Саарал хажуу тийшээ огло харайлаа. Би арай л ойчсонгүй, тэвдэж эмээлийнхээ хажуу дээр гарсан боловч азаар тогтлоо. Гэвч ташуураа алдчихжээ. Энэ хоорондо Дорж хунзын хээр даага нэлээд зайлчихсан байв. Өнгөрчээ...

Давирч гуугалсаар ард нь нэлээд ойрхон очлоо. “Гэвч хээр даага хэдхэн харайгаад барианд орно... за байз... яая даа... ташуурдай ч болоосой”.

Гэнэт барианы зүгээс хангинатал янцгаах сонсогдов. Миний саарлын нүд нь сэргэж, янцаглан хүчээ нэмлээ. Яах ийхийн завдалгүй саарал минь жирэлзэн хурдалж хээр даага, улаан дарцаг ээлжлэн өнгөрөв. Түрүүлчихлээ. Морь барих хүмүүс хүртэл барьж чадалгүй алдчихжээ. Саарал дааганы эх янцгаасан юмсанж. Тэр янцгаалт ямар ч ташуураас илүү хэрэг боллоо. Эхийн нь янцгаалт саарал дааганд юу юунаас илүү хүчийг өгчээ. Юутай сайхан янцгаалт, энэ янцгаалтыг би зөвхөн чихээрээ ч биш бүх эрхтнээрээ хүлээн мэдэрсэн биз. Энэ янцгаалт одоо ч гэсэн миний чихэнд хангинан сонсогдсоор билээ.

Хөлстэй тохмоо шилгээн эхээ хөхөж байсан хөөрхөн саарал даагыг минь хамаг амьтан бүчин ирлээ. Тэдний магтах, өхөөрдөх хоёрыг өгүүлээд баршгүй ээ. Харин хээр дааганыхаа хөлсийг хусаж зогсоо Дорж хунз дээр хэн ч очсонгүй. Гэвч Дорж хунз өөрөө наашаа ирэх байлгүй дээ. (Ж.Лхагва)

1. Дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

1. бүчих	a) унасан малыг хөл буюу дөрөөгөөр дэлдэх
2. нийгэмчлэх	b) юмаар сажиж цохих, цавчих
3. ширвэх	c) нийгмийн болгох, нийгэмчлэн татварлах
4. гуядах	d) хурж шавах
5. давирах	e) унасан морь мал зэргийг ташуур мэтийн юмаар гуяны тус газар занчих, дэлдэх

A. 1d2e3a4c5b *B. 1d2c3b4e5a* *C. 1d2e3b4a5c*

D. 1b2c3a4e5d *E. 1d2c3a4e5b*

2. “**Ергөх** нь морины гэдэс зайлчихна гэж хашир хүмүүс голдуу цогиулах ажээ.”өгүүлбэрийн онцолсон үгийн утгыг олоорой.
   A. Морины шогших хатирах хоёрын дунд ширүүвтэрхэн явах явдал
   B. Морины довтлон явах явдал
   C. Морины хатираар явах явдал
   D. Морь малын хатир сэглэгт хүрэхгүй шогшоо явдлаар явах
   E. Морь малын өмнөд хоёр хөл зэргээр, хойд хоёр хөл зэргээр ээлжлэн харайлан явах

3. *“Эхийнх нь янцгаалт саарал дааганд юу юунаас илүү хүчийг өгсөн”* гэсэн санааг батлах баримт аль нь вэ?
   A. Энэ янцгаалтыг би зөвхөн чихээрээ биш бүх эрхтнээрээ ч хүлээн мэдэрсэн биз.
   B. Хөлстэй тохмоо шилгээн эхээ хөхөж байсан хөөрхөн саарал даагыг минь хамаг амьтан бүчин ирлээ.
   C. Гэнэт барианы зүгээс хангинатал янцгаах дуу сонсогдов. Миний саарлын нүд нь сэргэж, янцаглан хүчээ нэмлээ.
   D. Тэр янцгаалт ямар ч ташуураас илүү хэрэг боллоо.
   E. Буруу талаар нь хариугүй хошуу өлгөөд ирлээ. Түрүүлэхэд нь баярласан гэж хязгаар алга.

4. Дорж хунз яагаад саарал даганы хоншоор дундуур ташуурдсан бэ?
   A. Саарал даагыг нэгдлийн хурдан хээрийн удам гэдгийг мэдсэн учраас
   B. Саарал даага өөрийнх нь хээр даагыг гүйцээд ирсэн учраас
   C. Саарал даага наадамд түрүүлсэн учраас
   D. Хээр даагаа дагаж давхиж байгаад санамсаргүй ташуурдсан
   E. Дорж хунз ташуурдаагүй

5. Эхэд дэвшүүлсэн асуудал буюу сэдвийг олоорой.
   A. Саарал даганы тухай B. Наадмын тухай C. Даганы уралдааны тухай
   D. Эх үрийн холбооны тухай E. Шударга бус зангийн тухай

6. Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
   A. Эхийн нь янцгаалт саарал даганд юу юунаас илүү хүчийг өгчээ.
   B. Дорж хунз дээр хэн ч очсонгүй.
   C. Гэвч Дорж хунз өөрөө наашаа ирэх байлгүй дээ.
   D. Яах ийхийн завдалгүй саарал минь жирэлзэн хурдалж хээр даага, улаан дарцаг ээлжлэн өнгөрөв. Түрүүлчихлээ.
   E. Түрүүлэхэд нь баярласан гэж хязгаар алга.

7. Өгүүлэгчийн харамсах сэтгэлийн байдлыг илэрхийлсэн өгүүлбэр аль нь вэ?
   A. Яах ийхийн завдалгүй саарал минь жирэлзэн хурдалж хээр даага, улаан дарцаг ээлжлэн өнгөрөв. Түрүүлчихлээ.
   B. Энэ хооронд Дорж хунзын хээр даага нэлээд зайлчихсан байв. Өнгөрчээ...
   C. “Гэвч хээр даага хэдхэн харайгаад барианд орно... за байз... яая даа...
   D. Гэвч Дорж хунз өөрөө наашаа ирэх байлгүй дээ.
   E. Би хэдэнтээ хүчтэй ширвээд хашхираад орхисон чинь хээр даагатай зэрэгцээд очлоо.

8. *“... аяндаа **саарлаас минь** хоцрох нь тэр”, “**жороо хараа** халбилзуулж”, “тийм **хурдантай** болохын тулд*”- хэсгээс тодруулсан үгсийг ажиглан дүрслэх ур маягийг олоорой.

A. адилтгал B.ихэсгэл C. багасгал D. төлөөлөл F. тойруулал

9. Дорж хунзыг хөндлөнгөөс дүгнэсэн өгүүлбэрийг олоорой.

A. Чи надад азаргаа өгсөнгүй. Очиж очиж нэгдэлд зүгээр өгчихнө гэнэ ээ!
B. Чиний муу хээр үрээг аваагүйгээр Дорж хунз хохироо ч уу, үгүй ч үү?
C. Жаахан явуул... Жолоогий нь сулруулахгүй юу, муу мангуу!
D. Дааганд нь тийнхүү амьтны ам сайн байгаад Дорж хунз их л бардам явна.
E. Би чамд гаансан дээрээ дөрвөн бод нэмж өгье гэж мөн их гуйсан даа

10. Өгүүлбэрийг эсрэг утгаар нь зөв харгалуулсан хэсгийг олоорой.

1. Морь тавьсан улсуудын морьд цөм л дааганаас хоцрохоргүй байсан боловч журмыг сахиж томчууд морьдынхоо амыг татав.
2. Тэр сүйд болоод байгаа нэгдэл чинь чамайг яаж гялайлгахыг харахсан.
3. Хөлстэй тохмоо шилгээн эхээ хөхөж байсан хөөрхөн саарал даагыг минь хамаг амьтан бүчин ирлээ.
4. Түүний хурдны шинж бүрдсэн өндөр хээр даагыг түрүүлнэ гэж ихэнх хүмүүс ярина.
5. Буруу талаар нь хариугүй хошуу өлгөөд ирлээ. Түрүүлэхэд нь баярласан гэж хязгаар алга.

a) Нэгдэл, хөдөлмөр хоёр аавыг минь яаж гялайлгасныг Дорж хунз одоо ч харж явна.
b) Миний ... саарал даагыг нэгдлийн хурдан хээрийн унага гэж мэдэх ... хэдхэн хүнээс бусад нь сайн давхина гэж зүүдэлсэнгүй бололтой.
c) Энэ хоорондд Дорж хунзын хээр даага нэлээд зайлчихсан байв. Өнгөрчээ...
d) Дорж хунз л ганцаараа хоцорсонгүй тэр даагатайгаа зэрэгцэн давхиж, ... гэх зэргээр дуу хадуулж явлаа.
e) Хээр даганыхаа хөлсийг хусаж зогсоо Дорж хунз дээр хэн ч очсонгүй.

A. 1d2a3e4c5b *B. 1d2a3c4e5b* *C. 1d2a3e4b5c*
D. 1e2c3a4b5d *E. 1d2e3a4b5c*

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1 Дараах эхээс уншаад зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай 1 үгийг олвол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо [5 оноо]

“Айлаас ирэхээр авдраа уудла” гэсэн монгол үг бий. Хүн бүрийн оюун ухааны авдарт “хүслийг хангагч чандмань эрдэнэ” дүүрэн байдаг юм. Гагцхүү авдарынхаа тагыг итгэлтэй сөхөж, хэрэгтэй зүйлээ оролдлого зүтгэлээр эрж хайж, эцэж цуцашгүй чармайлтаар олж илрүүлэн, оновчтой ашиглах л хэрэгтэй. Мөрөөдөл тэмүүлэл, өөдрөг сэтгэл, хичээл зүтгэл, тэсвэр тэвчээр, цөхрөлтгүй оролдлого, ажилсаг бүтээлч чадвар энэ бүгд бүтээлч хүнд зайлашгүй байх шилдэг чанарууд.

Ташаарсан нь	Залруулсан нь

2.2. Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. [5 оноо]



.....

.....

.....

.....

.....

....

.....

2.3 4. **“Эдийн ашиг эхэндээ, эрдмийн ашиг эцэстээ**” сэдвээр эх зохион бичээрэй. Бичихдээ бүтэц, хэв шинж, сэдэв, агуулгын харьцаа болон найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглаарай. Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 150-180/

[20 оноо]

Алтан жүн жор

Зовуурилж шаналснаасаа болоод шанааны яс нь шөнтийн чамархайны судас нь бараг гогдож болохоор гүрэлзэх өвгөн хэрзгэр цээжнийхээ угт мэнгэртэн ханиаж, арай гэж уушгинд нь жаахан хий очих шиг амьсгаа авахтайгаа болов.

-Ээ бурхан минь гэж, хоногийн тоо гүйцэх нь шив. Түжгэр бандийнхаа хүчээр эхний удаа ч арай үхчихгүй байх аа гэж бодсоноо ямааны арьсан илгэн дээр баахан цэцэг навчийг хамрын тамхи шиг нунтаглаж суугаа горзгор шар банди руу зөөлөн ширтсэнээ:

-Хоолой аргаад. Бүлээн юм амсдаг юм билүү? гэхэд нөгөө хүү шалавхан босч өвгөний хэрзгэр цээжийг эвлэгхэн өргөж орны толгой налуулав. Тэр халуун цай хэд оочоод духанд нь хүйтэн хөлс чийхарснаа бие нь гайгүй тавирав.

“Хөгшин азарганы дэл нь сүртэй” гэгчээр амь нь цааш орчихсон намайг олон түмэн эгээ л бурханчлаад, энэ хүүг ер тоох янзгүй. Шавьдаа манба дацангийн хамбын олбогоо шилжүүлчхээд Ерлөгийн ууландаа гарч хөдөөлье байз. Дөчин жил хэнд ч ам нээгээгүй хадгалсан “Алтан жүн” жорынхоо нууцыг шавьдаа тайлсан маань онолоо. Баргийн маарамба дийлэхээргүй энэхүү ганц тангийнхаа жорыг улаан буйландаа зуусаар ертөнцөөс халивал нүгэл шүү дээ. Одоо энэ хүүгийн мөч богинодно уу гэхээс бурхнаас хайрласан ухаанаар бол маниас ч илүү. Өнгөнд нь магтдаггүй болохоос биш, миний шавьд цаст Төвд орны босго ч өндөрдөхгүй. Цагаа болохоор ч...” гэж хэнд ч сонсогдохоор хэлчхээд зовнив.

-Багш аа, Та хэвтэж болгооно уу? гэхэд тэрбээр өмнө бохирон суусан шавийнхаа мулзан толгойг зөөлөн илэв. Хариг хатуу багшийн ганц шагнал нь энэ гэдгийг ламын тогоо шанага хангинуулахдаа хүү сайн мэддэг болжээ.

-За хүү минь, эртээрийн чамд заасан есөн эрдэнэ, таван махбод шингэсэн танг гаргах аргыг тайлснаар багшийн чинь насны хүслэн ханалаа. Одоо би ташаад хаясан шаантны яс шиг болжээ. Байдаг чөмгөө чамаас харамласангүй. Тэр тан л хөгшин зовлогыг чангаах биз гэхэд:

-Жа болгооё багш аа гэж хүү чимээгүйхэн алга хавсрав. “Хачин шүү. Энэ хүүгийн зүүн нүдний буланд нэг л хачин хяруу сэрвэгнээд байх шиг санагдаад, бие хаа нь өсөж томорлоо гэхэд ер арилахгүй юм гээч” гэж өвгөн өөрөөсөө жийрхэв. Шөнө огт танихгүй газар мориор шогшиж яваад:

-Энд таван төрлийн эмийн ургамал байна, үнэрээр нь нэрлэ гэхэд энэ л хүү яг олоод хэлчихдэг сэн. Тэр ч байтугай нүдээ боолгоод тэмтрэхэд ав адилхан чулууны дундаас гиваантайг нь олно гээч. Ховор оо, ховор бурхан минь, яахав дээ, Цахиуртын дэлдэн хөх маарамба жанч халахад миний нэрийг шавь минь авч үлдэнэ” хэмээн өвгөн бахархаж, утаа тортогноос будаг нь ялгарахаа байсан тооныг ширтэж хэвтэв.

-Багш аа, тан бэлэн боллоо гэх бүдэг дуунаар өвгөн ур шиг доош нь унжсан үрчлээтэй зовхио алгуур нээж, “Надаас нэг өдрийн өмнө амжиж байна шүү. Түрүү ургасан чихнээс хожуу ургасан эвэр гэж энэ дээ” гэж дотроо баясав. Тангийн даруулга болох хойлгийн шөлний нялуувтар үнэр гэр дүүрэн ханхална. Хүү газар шүргэсэн орхимжоо зассанаа, түмэн өлзий хээг ган утас гүйлгэн цувьсан мөнгөн гүцтэй эмийг хадганд ороогоод багшийнхаа өөдөөс барилаа. **Өвгөн маарамба тангаа хүртэхийн өмнө нүдээ анин алга хавсран наманчилж уншлагаа тайвуухан дуусгаад, түүнийг хоёр гардан ёсорхуу тослоо.**

Гүцнийхээ тагийг онгойлгосноо хамартаа ойртуулан үнэрлэв. Өөртөө үл итгэсэн янзтай гайхширснаа, дахин үнэрлэв. Ухархайдаа ширгэсэн юм шиг нүд нь гэнэт хурцаар гялтганаж шавийнхаа нүүрийг цоргих адил ширтлээ. Хүүгийн нимгэн шар хацар час улайж, хамар дээгүүр нь хөлс бурзайна.

-Хүү минь, шавь минь. Чи үүнийг хийчихлээ гэж үү дээ? хэмээн багш цаанаа бядгүй дуугаар арай хийж асуув.

-Тиймээ, багш аа. Би би... хүү түгдчин дальдрахдаа мөнөөх зүүн нүднийх нь хяруу шумуулын сүүдэр мэт тодорсныг өвгөн сая л олж хараад цочжээ.

“Аа, тийм учиртай сүүдэр байж. Одоо надаас авах юмаа авч ханаж. Аваагүй үлдсэн юм юу билээ? Хамбын суудал. Аграмбын зиндаа, алдар нэр юм байна. Тэр сүг сүнс нь нүдэнд орчихсон надад үзэгдээд байж. Ээ лам гурван эрдэнэ гончигсүм. Эм, хор хоёрыг ялгахгүй байна гэдэг бол эрхи, судраа мань нь ялгахаа байсантай адилхан. Ийм нүгэлтэй чаралбыг гэмгүй түмний дунд орхиж болохгүй. Эрлэг номун хаанд л хамт очоод өчгөө мэдүүлье” гэж өвгөн эргэцүүлээд гүцтэй тангаа хүүгийн урдаас цочмог барив. Хүүгийн царай үнсэн саарал болж, уруул нь өмөлзөн арагшаа ухарлаа.

“Үгүй ээ, бурхан тахилынхаа өмнө шавийнхаа сүүдрийг үргээх гэж үү? Үйлийн үр эзэн нь би юм байна. Тэр “алтан жүн” жорыг өдий болтол илчлээгүй гор нь гарч” гэж шивнээд сунгасан гараа татав.

-Шавь минь, чи үүнийг үнэхээр надад зориулсан уу? гэхэд хүү харцаа ширдэг дээр унаган толгой дохив.

-За тэгвэл багш нь хүртье ээ, шавхруу ч үлдээлгүй хүртье гэж цэл хүйтэн уруулынхаа дор гүцийг авчран, шавиа юу хэлэхийг хүлээзнэлээ. Ганц хором гэдэг аюултай урт ужиг болохыг тэр хоёр зүрхэндээ ортол мэдрэв. “Жа гүйцээе” гээд өвгөн гүцтэйг ховх соров.

Дэндүү эрдэм чадал төгс, дагсал буюу ном хаялцах ухаанаараа Лхас, Утай хүртэл шагшигдсан өвгөн аграмбын гараас мөнгөн гүц сугарч хүүгийн өлмий дор өнхрөв. “Алтан жүн” жор хэмээх алдарт эмээ алдчих вий гэсэн шиг өврөө тэмтрээд зогсож байгаа хүүгийн нүдэн дэх хяруу аль хэдийнээ алга болсныг олж харахаар байлаа.

До.Цэнджав

1. Эхэд орсон дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийн дугаарыг олоорой.

1. гиваан	a) Эсгий, цэмбэ, торго зэргээр өнгөлж хийсэн дөрвөлжин дэвсгэр
2. хяруу	b) Энэтхэг Түвдийн эмийн 4 үндсийг судалсан, эмч лам /оточ/
3. олбог	c) Газарт унасан шүүдрийн хүйтэнд царцсан цан
4. хамба	d) Шашны сүм хийдийг тэргүүлэн удирдах хүний тушаалын нэр
5. маарамба	e) Шар өнгөтэй шороо, чулуу

A. 1c2e3b4a5d B. 1c2a3b4d5e C. 1e2c3b4d5a
D. 1a2b3c4d5e E. 1e2c3a4d5b

2. “ ... тэрбээр өмнө **бохирон** суусан шавийнхаа мулзан толгойг зөөлөн илэв” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийн утгыг олоорой.
   A. Тавгаараа гишгэж, хоёр хөл дээрээ суух
   B. Хоёр өвдгөө нугалж, шилбэ өлмийгөө зөрүүлдэн суух
   C. Биеэ эвхэн, атийн суух
   D. Халшран хойш, арагш суух
   E. Хоёр хөлөө нугалан өвдгөөр тулж суух
3. Багшийн, шавь хүүгээ харьд ч үнэлэгдэж чадах хүн гэдгийг харуулах баримт нь аль вэ?
   A. Энд таван төрлийн эмийн ургамал байна. Үнэрээр нь нэрлэ гэхэд яг л олоод хэлчихдэг.
   B. Нүдээ боолгоод тэмтрэхэд ав адилхан чулууны дундаас гиваантайг нь олно гээч.
   C. Өнгөнд нь магтахгүй болохоос биш, Цаст Төвдийн босго ч өндөрдөхгүй.
   D. Энэ хүүгийн мөч богинодоно уу гэхээс, бурхнаас хайрласан ухаанаар бол маниас илүү.
   E. Цахиуртын дэлдэн хөх маарамба жанч халахад миний нэрийг шавь минь авч үлдэнэ.
4. Маарамбын тааварлан барагцаалж буй хандлагыг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
   A. Чи үүнийг үнэхээр надад зориулсан уу?
   B. Тэр тан л хөгшин зовлогыг чангаах биз
   C. Бие хаа нь өсч томорлоо гэхэд ер арилахгүй юм гээч
   D. Ав адилхан чулууны дундаас гиваантайг нь олно гээч.
   E. Түрүү ургасан чихнээс хожуу ургасан эвэр гэж энэ дээ
5. Лам нарын насан эцэслэхийн хүндэтгэлийн утгатай хэлцийг олоорой.
   A. Ууланд хөдөөлөх
   B. Жанч халах
   C. Хоногийн тоо гүйцэх
   D. Сүүдрийг үргээх
   E. Эрлэг номун хааныд очих
6. *Одоо энэ хүүгийн мөч богинодно уу гэхээс бурхнаас хайрласан ухаанаар бол маниас ч илүү* - өгүүлбэрийн санааг илэрхийлсэн хэлцийг олоорой.
   A. Бие өтлөвч санаа өтлөхгүй.
   B. Бие нь бага ч бэлчээр нь хол.
   C. Бага багаар цугласаар нэг юм бүтдэг, цаг цагаар өнгөрсөөр нэг жил болдог.
   D. Биеэ тоодог хүн мунхгийн туйл, биеэ хичээдэг хүн мэргэний туйл. E. Бага чулуугаар их чулууг доргиулах.
7. “*...хүү түгдчин дальдрахдаа мөнөөх зүүн нүднийх нь хяруу шумуулын сүүдэр мэт тодорсныг өвгөн сая л олж хараад цочжээ.*”- өгүүлбэрийн дүрслэх ур маягийг олоорой.
   A. хүншүүлэл B. төлөөлөл C. зүйрлэл
   D. тойруулал E. ёгтлол
8. Эхийн сэдэв буюу дэвшүүлсэн асуудлыг олоорой.
   A. Хүн хүндээ итгэх итгэлийн тухай
   B. Багш шавийн нандин харилцааны тухай
   C. Аминд тустай жорын тухай
   D. Хорон муу санааны тухай
   E. Өтөлж хөгшрөх жам ёсны тухай
9. Эхийн гол санаанд тохирох хэлцийг олоорой.
   A. Бурхангүйд бумба галзуурна

B. Огторгуйн нар шингэдэг, оройн очир шилждэг
C. Ишиг эврээ ургахаар эхийгээ мөргөнө
D. Багшийн эзгүйд банди галзуурч, ламын эзгүйд бумба галзуурна
E. Багшийн эрдэм шавиас, зулын гэрэл тосноос

10. Эхийн онцолсон хэсгийн хэв маягийг тодорхойлоорой.
A. Өвгөн маарамбын гайхширсны учрыг баталсан тул эргэцүүлэмж
B. Өвгөн маарамбад бэлтгэж өгсөн тангийн шинж байдлыг зурагласан тул тоочимж
C. Өвгөн маарамбын бодлыг олон талаар задлан тайлбарласан тул тайлбарламж
D. Өвгөн маарамбад тохиолдсон явдлыг дараалан гаргасан тул хүүрнэмж
E. Өвгөн маарамбын хийсэн үйлүүдийг дэс дараалан өгүүлж, шавийнх нь гадаад төрх байдлыг зурагласан тул хүүрнэмж, тоочимж хосолсон хэв маяг

2.1 Дараах эхийн хэсгийг уншаад зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай 1 үгийг олбол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо. [5 оноо]

Хорвоогын жам, амьдарлын хатуу хуулийн эрхшээл ёсоор эцгийн бие өвчөнд нэрвэгдэн доройтож, нэг л өдөр хэвтэрт орлоо. Амьд хүн байна, арга чарга хайна л даа. “За даа, тийм ч юм сайн гэнэ, ийм ч юм сайн гэнэ, тэрийг л олвол, ээ дээ энийг л идвэл үү, хамаг хууч арилах юм гэнэ” гэж ирээд л амтай бүхэн яридаг байлаа.

2.3 Дараах сэдвээр эх зохион бичээрэй. (Бичихдээ бүтэц, хэв шинж, сэдэв, агуулгын харьцаа болон найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглаарай.) Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. / Үгийн тоо 150-180/ [20 оноо]

Тэвчээр

….....

.....

Хувилбар 10

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ [20 оноо]

Эрүүл биед саруул ухаан оршино

Би залуудаа биеийн тамираар дагнан хичээллэж байсангүй. Хүүхэд байхдаа хөвгүүдтэй нэг удаа тоглож байгаад хөлөө бэртээснээс хойш хөл бөмбөгийг бүр мөсөн орхисон. Мөн одон бөмбөг тоглож сурах гэж хэдэн өдөр оролдсон. Бөмбөгөө онож цохиж чаддаггүй байлаа. Бас нэг хэсэг гүйлтээр хичээллэв. Гэтэл хамт гүйдэг хүмүүсээс надад гүйцэгдэх нэг ч хүн байгаагүй юм. Биеийн тамираар хичээллэх гэсэн миний түүх иймэрхүү байдлаар өрнөж байлаа. Сэлж сурах гэж оролдлоо. Дасгалжуулагч багш маань хичнээн зааж өгөөд сурдаггүй. Их усанд орвол живэхээр байлаа. Эцэст нь алхаагаар хичээллэвэл үр дүнтэй байх юм шиг надад санагдав. Тэгээд байнга алхдаг болов. Олон ч жил алхлаа. Өдөрт 6-10 км алхах нь энүүхэнд. Биеийн тамирын бусад төрлийг бодвол алхаа нь надад сайн тохирч байв. Ингээд би гучин наснаасаа биеийн тамираар идэвхтэй хичээллэж эхэлсэн юм. Гуч дөнгөж гарсан надад бүх амьдрал минь дуусан юм шиг нэг үе санагдаж байж билээ. Мөн ууган хүүгээ ахлах сургууль төгсөөд их сургуульд элсэхэд би дөч дөнгөж хүрч байсан. Тэр үед бас л миний амьдрал дуусан мэт санагдаж сэтгэл зүйчээс зөвлөгөө авдаг байв. Харин тавин нас хүрээд биеийн тамирын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сайн дурын байгууллага байгуулж түүндээ идэвхтэй ажиллалаа. Энэ үеэс бүх зүйл ид шидийн юм шиг сайхан байх боллоо. Би эрч хүчээр дүүрэн байсан ч нэг өдөр багтраа /астам/ өвчтэй болов. Удалгүй зүрхээр өвдөж эхлэв. Мөн үе мөчний өвчин намайг зовоож эхлэв. Хүмүүст сайхан харагдахын тулд залуудаа өвөл нимгэн хувцаслаж явсны хор уршиг хожим гарсан юм. Тавин насандаа чихрийн шижингээр өвдлөө. Эм, тариа нэлээд хэрэглэж, биеийн дархлаагаа сайжруулж чадсаны хүчинд эрүүл болов. Алхаагаар хичээллэсэн маань талаар болоогүй юм байна.

Би жаргах нарыг харах дуртай нэгэн. Байгаль бол ид шидээр адислагдсан юм шиг гайхамшигтай сайхан. Удалгүй надад ургах нарыг угтах нь сайхан санагдах боллоо. Залуу насандаа өглөө эртлэн босож, дэлхий ертөнцийн сайхныг сонирхдоггүй байсандаа жаахан харамсдаг. Хаврын улиралд амьдрал эхэлж, намар навчис салхинд хийсэн одохыг цэцэрлэгт зугаалан явахдаа ажиглах сайхан байна. Өвлийн анхны цас орсон өдөр гадаа алхаж, зуны улиралд байгаль дэлхийн ногоон өнгийг ажиглан харах сайхан. Мөн амьдралын жамаар нас ахихын хэрээр өвчин эмгэг тусах нь их болдог юм байна гэж бодох болсон. Энэ үеэс эрүүл саруул гялалзаж явсан оргил үе минь дуусаж байх шиг санагдана. Бодол санаагаа цэгцлэн мөргөл залбирал үйлдэж, амрах цаг маань иржээ. Харин нас

ахиж, хашир суух тусам “Санаа зовох” гэдэг гинжнээс өөрийгөө чөлөөлж сурч байна. Би насан туршдаа болоод өнгөрсөн зүйлдээ дэмий харамсаж, ирээдүйд юу болох бол хэмээн санаа зовнин амьдарсаар иржээ. Энэ бүхэн хүний өнөөдөр гэгч сайхан өдрийг жаргалтай өнгөрүүлэхэд саад болдог байж дээ гэж бодох болсон. Миний амьдралд уулзаж учирч, үзэж туулсан бүхэн тохиолдлын зүйл байгаагүй бөгөөд юм бүхэн утга учиртай, хоорондоо үйлийн холбоотой болохыг ухаарсан. Удалгүй бие маань сульдаж эхэллээ. Сандал түшин явж, зогсохдоо өөрийгөө толинд хараад инээмсэглэж, цэл залуухан байсан үеэ дурсан бодлоо. Цээж эгцлэн алхаж, үүрд иймээрээ байх юм шиг санаж явсан үе маань аль хэдийнээ өнгөрчээ.

Гэхдээ миний амьдрал, аз жаргал, баяраар дүүрэн байсан. Хувь заяа минь надад сайн найз нөхөд, сайхан гэр бүл, эрүүл чийрэг амьдралыг харамгүй бэлэглэжээ. Хүн эрүүл явбал амьдралын урт удаан замд аз жаргал, сайн сайхан бүхнийг заавал үздэг. Харин эрүүл байхад бага наснаасаа бэлдэх ёстой. Залуу үедээ биеийн хүчний ажил хийхгүй, хэвтэж унтаж, залхууран, бусад хүн ажлыг минь хийгээд өгчихвөл сайн хэмээн боддог. Хөдөлгөөнгүй, идэвхгүй амьдралын хор уршиг хөгшрөх үед илэрдэг аж. Иймд залуу наснаасаа муу зуршилд автахгүй, аль болох хөдөлгөөнтэй, гүйж харайж, ажил хөдөлмөр хийж зүтгэж байвал хөгшрөхийн цагт эрүүл амьдрахын жаргалыг амсана. Харин залхуурал, идэвхгүй амьдрал нь ирээдүйд өвчин, зовлон болж ирдгийг үргэлж санаж яваарай.

1. Дараах үгсийн утгыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

1.Ид шид	a. Тамирдах, ядрах
2.сульдаа	b. тавилан
3.зовнил	c. насны намар
4.жам	d. шаналал
5. хөгшрөлт	e. Гайхамшиг

A. 1e2a3c4b5d B. 1e2b3a4d5c C. 1e2a3d4b5c
D. 1c2e3b4a5d E. 1b2e3a4c5d

2. “Бодол санаагаа цэгцлэн, мөргөл залбирал үйлдэж, **амрах цаг** маань иржээ.” гэсэн өгүүлбэрийн онцолсон гийн утгыг олоорой.
   A. Идэр үе
   B. Балчир үе
   C. ээлжийн амралтын үе
   D. Залуу үе
   E. Нас тогтсон үе
3. “Эм, тариа нэлээд хэрэглэж, биеийн **дархлаагаа** сайжруулж чадсаны хүчинд эрүүл болов.” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийн утгыг олоорой.
   A. Биеийг засан сайжруулах
   B. Биеийн өвчин эсэргүүцэх чадвар
   C. Үйл ажиллагааны бат бэх чанар
   D. Бүрэн эрх, эрх чөлөө олгох
   E. Эд зүйл, юм урлан бүтээх
4. Өгүүлэгчээс туулж өнгөрүүлсэн амьдралаа дүгнэсэн санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
   A. Хөдөлгөөнгүй, идэвхгүй амьдралын хор уршиг хөгшрөх үед илэрдэг аж.
   B. Би залуудаа биеийн тамираар дагнан хичээллэж байсангүй.
   C. Мөн амьдралын жамаар нас ахихын хэрээр өвчин эмгэг тусах нь их болдог юм байна гэж бодох болсон.
   D. Би насан туршдаа болоод өнгөрсөн зүйлдээ дэмий харамсаж, ирээдүйд юу болох бол хэмээн санаа зовнин амьдарсаар иржээ. E. Харин эрүүл байхад бага наснаасаа бэлдэх ёстой.

5. “Хүмүүст сайхан харагдахын тулд залуудаа өвөл нимгэн хувцаслаж явсны хор уршиг хожим гарсан юм.” гэсэн өгүүлбэтэй утгаараа хамгийн ойр хэлц аль нь вэ?
   A. Эрүүл мэндээ алдвал бүхнийг алдана B.
   Өргүй бол баян өвчингүй бол жаргал
   C. Эрүүл биед саруул ухаан оршино.
   D. Шинэхэн эмчээс ширгээсэн ус
   E. Дулаан явбал мянган лан
6. Өнөөдөр гэгч сайхан өдрийг жаргалтай өнгөрүүлэхэд саад болдог байсан зүйл юу вэ?
   A. Биеийн тамираар тогтмол хичээллэдэггүй, эрүүл мэнддээ анхаардаггүй байсан нь
   B. Залуудаа хайхрамжгүй явснаас шалтгаалан, олон төрлийн өвчин дараалан тусч байсан нь
   C. Өнгөрсөн зүйлдээ дэмий харамсаж, ирээдүйд юу болох бол хэмээн санаа зовнидог байсан нь
   D. Байгалийн жамаар нас ахиж хөгшин болж, хүссэн зүйлээ хийж чадахгүй болсон нь E. Залуу насандаа өглөө эртлэн босож, дэлхий ертөнцийн сайхныг сонирхдоггүй байсан нь
7. “Харин нас ахиж, хашир суух тусам “Санаа зовох” гэдэг гинжнээс өөрийгөө чөлөөлж сурч байна.” гэсэн өгүүлбэрийн дүрслэх ур маягийг олоорой.
   A. хүншүүлэл B. төлөөлөл C. зүйрлэл
   D. тойруулал E. Ёгтлол
8. Өгүүллэгээр ямар санааг дэвшүүлэн тавьсан бэ?
   A. Нас ахих тусам хүн өвчлөх магадлал ихтэй
   B. Сэтгэл санаагаар өөдрөг явбал өвчин тусахгүй
   C. Залуу наснаасаа дасгал сургууль хийж, аль болох хөдөлгөөнтэй байвал эрүүл мэндэд тустай
   D. Учирсан юм бүхэн утга учиртай, хоорондоо үйлийн холбоотой
   E. Залуудаа даарч хөрөх нь өвчин үүсэх эх үндэс
9. Өгүүллэгт ямар сэдэв, дэвшүүлсэн асуудал хөндсөнийг олно уу?
   A. Өвчний тухай
   B. Явган явахын ач холбогдлын талаар
   C. Хүний бодол санаа, сэтгэл зүйн тухай
   D. Эрүүл байх шалтгааны тухай
   E. Хүний хөгшрөлтийн тухай
10. Дараах өгүүлбэрүүдийг уншаад үйл явдлын зөв дараалалд оруулаарай.
    1. Харин тавин нас хүрээд биеийн тамирын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сайн дурын байгууллага байгуулж түүндээ идэвхтэй ажиллалаа.
    2. Хүмүүст сайхан харагдахын тулд залуудаа өвөл нимгэн хувцаслаж явсны хор уршиг хожим гарсан юм.
    3. Эцэст нь алхаагаар хичээллэвэл үр дүнтэй байх юм шиг надад санагдав.
    4. Хүүхэд байхдаа хөвгүүдтэй нэг удаа тоглож байгаад хөлөө бэртээснээс хойш хөл бөмбөгийг бүр мөсөн орхисон.
    5. Харин залхуурал, идэвхгүй амьдрал нь ирээдүйд өвчин, зовлон болж ирдгийг үргэлж санаж яваарай.
    A. 1, 5, 2, 3, 4 B. 4, 3, 1, 2, 5 C. 1, 2, 3, 4, 5
    D. 4, 3, 1, 5, 2 E. 3, 1, 2, 4, 5

ХОЁРДУГААР ХЭСЭГ [30 оноо]

2.1 Дараах түүвэр өгүүлбэрүүдийг уншаарай. Зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод засаж бичээрэй. Алдаатай 1 үгийг олбол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо.

[5 оноо]

Дэлхийн **бөмбөрцөгийн** нартай талыг өдөр, сартай талыг шөнө гэж нэрлэдэг. Эрүүл мэндийн хичээлийн ач холбогдол их. Хүүхэд бүрийг багаас нь эрүүл мэндийн зөв дадал хэвшилд сургая. Миний дүү долоо хоногийн гурван өдөрт нь биеийн тамираар **хичээлэлдэг.** Гарын ариун цэврийг **сахъя. Дасгалжуулагчын** мэргэшүүлэх сургалт маргааш **эхлэнэ.**

Ташаарсан нь	Залруулсан нь

2.2 Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. [5 оноо]



.....
.....
.....
.....
.....

2.3 “*Жаргалыг хүсвэл эрүүлийг хүс* ” сэдвээр эх зохион бичээрэй. (Бичихдээ бүтэц, хэв шинж, сэдэв, агуулгын харьцаа болон найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглаарай.)

Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 150-180/ [20 оноо]

Хувилбар 11

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ [20 оноо]

Гашуухан заяаны зурвас

Цуут Егүзэр хутагтын нутагт би хэдэн жилийн өмнө нэгэн өвгөнтэй танилцаж билээ. **Буурал санчигтай, том дөрвөлжин толгойтой тэр өвгөнийг нутгийнхан нь "хашир" Мажиг гэнэ. Үзтэл үхэхээс бусдыг үзсэн байрын олон үрчлээт нүүрнийх нь баруун шанаанд хөндлөн гялайсан сорви нь бий. Түүнийг нь Халх голоос олсон сумны сорви гэж бас нэг танил маань хэлсэн билээ.**

Холоос очсон намайг сонжих мэт үе үе ажиглан байгаа цэхэр хүрээ суусан жартгай нүд нь ч гэсэн аргагүй л хашрыг илтгэнэ. Сүрхий урт ургасан буурал хөмсөг нь хүртэл болгоомжлон сэрвийж байх шиг ээ. Тэгээд ч нутгийнхан нь олон Мажигаасаа ялган "Хашир" гэдэг тодотгол түүний нэрэнд зүүгээ биз. Эрт эдүгээгийн олон юм ярилцаж байж, сэтгэл нээлцсэн хойноо би,

-Танай энэ нутаг ч гайхалтай сайхан газар юм аа. Тал, ухаа толгод, хайлаасан шугуй, ан амьтан... гэж ярьтал Мажиг гуайн үрчлээт нүүр тэнийсхийх шиг болон инээмсэглээд "Нэг байтугай хэдэн нас заяасан ч уйдаж салахын аргагүй нутаг шүү" гэлээ. Тэгснээ санаа алдаж бодлогошроод "Би чамд нэг сонин юм ярья" гэв. Би уухайн тас чих дэвслээ.

-1939 оны хавар цаг сан. Би Дорнод хилд цэргийн алба хааж байлаа. Цаг түгшүүртэй. Япончууд Халх голын цаад талд хүчээ хуралдуулж байв. Манай застав суурингаа орхиод, хилдээ ойртон хээрийн байр эзлээд байсан юм. Бидний эсрэг талын хайлаастай хэсэг манханд Японы армийн нэг хороо байр эзэлсэн нь мэдэгдэж байлаа. Хилийн шугамын хоёр талд өөд өөдөөсөө анасан бидний хооронд 200 метр л зай байсан байх. Нэг шөнө би нөхөртэйгөө хамт харуулд гарсан юм сан. Үүрийн өмнөх үнэгэн харанхуйгаар дайсны зүгээс гэнэт буу тачигнаж гарав. Тэгснээ чимээгүй болж, хоёр удаа цагаан пуужин хөөрөн ойр хавийг гэрэлтүүлээд бүдгэрэн бүдгэрсээр манхан руу унаж улам харанхуй боллоо. Бидний зүрх түгшүүртэйгээр цохилж, чих улам сонор болон таг харанхуй руу нүд цавчилгүй ширтэн байж билээ.

Үүрийн гозон гэгээнд бидний өмнөх жижиг манхны орой дээрх сэрвийсэн намхан хэдэн бут үзэгдэх болов. Яг энэ манхан дээгүүр хилийн шугам байгаа гэж дарга маань хэлж байсан юм. Тэгтэл... тэгтэл сэрэвгэр бутны дээгүүр нэг хүний толгой цухуйлаа. Би яаран бууныхаа хараанд оруултал ахлах нөхөр маань "Хүлээж бай" гэж шивэгнэв. Тэр амьдаар нь барихыг бодсон биз. Өнөөх толгой нэг далд орсноо дахин гарч ирэв. Бүр мөр, цээж нь ил болж, улмаар бүтэн биеэрээ мөлхөн гарч ирлээ. Тэндээ түр хэвтсэнээ гар сунгаж, элс самардан мөлхөх нь харагдав. Тэгээд манхны наад руу зүгээр л өнхрөн бэлд нь хүрээд хөдөлгөөнгүй болов. Нар цухуйж байхад тэр босоогүйгээр барахгүй хөдөлсөн ч үгүй. Манааны ахлагчийн тушаалаар тэр хүн рүү мөлхөн дөхлөө. Гэдрэг хараад хөдлөхгүй хэвтээ япон цэргийн дэргэд хүрээд, гохон дээр нь хуруугаа тавьсан буугаараа суга руу нь хатгахад ч хөдөлсөнгүй. Шөнөөр тачигнасан өөрсдийнхөө бууны суманд үхсэн бололтой. Мөр, цээжийг нь нэвт гарсан сумны шархнаас урссан цус аль эрт бүлхэрсэн байлаа. Би түүний царайг хараад гайхсандаа балартах шахав. Сартгар хамрынх нь зүүн угалзан дээрх хорголын чинээ хар мэнгэ, эрүүнийх нь баруун талаар сунасан хүрэн толбо! Ээ бурхан минь, тэр бол Бордэрэм байлаа. Тэр үед намайг хажуугаас харсан бол миний хоёр нүд бүлтрэх гэж байгаа юм шиг байсан байх. Бид хоёр нэг голын хөндийд төрж, нэг хайлаасны сүүдэрт тоглож, нэг танхимд сурч байсан хар багын найзууд сан. Гэтэл нэг л гайт өдөр Бордэрэм маань сураггүй алга болсон юм. Хожим дуулбал төрөөс Егүзэр хутагтыг баривчлан хороосонд балмагдан айсан, гомдож хорссон олон шавь нь хил даван өвөрлөгч рүү оргоход Бордэрэм тэднийг даган одсон ажээ. Би Бордэрэмийн хөдөлгөөнгүй нүүрийг балмагдан ширтсээр байлаа. Түүний байдгаараа бүлтийсэн хоёр нүд нь Монголынхоо халуу дүүгэсэн хөх тэнгэрийг гөлрөн ширтэх мэт. Би буцаж ирээд бага даргадаа "Манай нутгийн хүн, миний найз байна" гэж шивнэхэд гайхсан тэр "Нээрэн үү" хэмээн дув дуугүй намайг ширтээд ярьсныг минь сонсов. Тэгээд манаанаас бууж явахдаа "За Мажиг минь, амаа хавчиж бай. Энэ эх орноос урвасан дайсны холбоотон, сүлбээтэн болчиход амархан цаг шүү гэлээ. Залуу мөртлөө одоогийн надаас ч хашир хүн байсан байгаа биз. Үдийн алдад тэр намайг дуудаад "Чи бид хоёрыг дахин очоод бичиг баримт байвал авчир" гэлээ гэв. Түүнд ямар ч үнэмлэх баримт байсангүй. Харин гараа дарсан баруун энгэрийнх нь халааснаас нь нэг эвхээстэй бичиг гарсан юм. Ухаантай бага даргынхаа хэлснээр би тэр бичгийг тавин жил далдын далд хадгалж яваа юм гээд суугаагаараа эргэж авдраа уудлан бүр ёроолоос нь даавуунд ороосон нэг бичиг гаргаж надад өгөв. Монгол үсгээр яаруухан таталсан болов уу гэмээр боловч гаргацтай нэгэн захиа байна. Түүнд өгүүлсэн нь:

Эрхэм монгол дайчин минь ээ, эх орон, элэг сэтгэл нэгт монгол нөхөр чинь бичиж байна. Би ар Монгол газар төрж өссөн хүн. Хувь заяаны ширүүн салхинд туугдаж харь газарт очсон юм. Гэвч тэнд гэгээн хутагтын минь сүнс ч очсонгүй. Тэр их гэгээнтэн ухаантай хүн байсан болохоор төрийн цаазанд толгойгоо өгсөн ч, төрсөн газраасаа сүнс нь гараагүй байлгүй. Залуугийн хөөрүү сэтгэлдээ дийлдэн явж амьдаараа хатах зовлон олсноо би сүүлд мэдрэн гасалж байлаа. Өдрийн бодол, шөнийн зүүд минь төрсөн нутаг минь болж, хойд зүгийг ширтэн зүрхэндээ уйлж явсан өдрүүд ард хоцорч байна. Харийн газар зовж ядрахдаа нутгийн барга баяны хүүгийн өмнөөс цэрэгт явсан чинь Японы армид орж, нутгийнхаа хил дээр ирлээ. Энд баргын нэг хороо байгаа юм. Би та нарынхаа өөдөөс буу шагайх заяатай яавч эвлэрч чадсангүй. Ямар ч байсан та нар руугаа очихоор шийдлээ. Гашуун заяаныхаа эрхээр эх орноо орхисон нүгэлтэн би амьд явбал төрийнх нь ял цаазаар нүглээ цагаатгая. Зууртаа алагдвал намайг монгол хүү байсныг итгэхийг гуйя. Бордэрэм Монгол газрынхаа шороон дээр нүглээ тэврээстэй үхсэн гэдэг юм. Чоно харайхын голынхонд минь дуулгахыг гуйж байна. Миний араас сум нэхнэ. Гэвч би хилээ давахыг эцсээ хүртэл хичээнэ” гэж бичсэн байлаа. Хашир Мажиг гуай багын найзынхаа тухайд тавин жил дарсан нууцаа надад ийнхүү дэлгэв. Бордэрэмийн бичиг бол амь нас, заяасан эх орноо орхисон нүглээ ухааранд, залуу сайхан биеэ эргүүлэн авчирч газар шороонд нь өргөсөн нэгэн эрийн хатуу цагийн заяаны нэгэн зурвас байсан юм. /П.Пүрэвсүрэн/

1. Эхэд орсон дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийн дугаарыг олоорой.

1. суурин	a) уян бөгөөд бөх чанартай навчит мод
2. хайлаас	b) хайрхаг, элс ихтэй гүвээ газар
3. манхан	c) суурьшил бүхий томоохон газар
4. гох	d) бууны замаг буулгах дэгээ
5. санчиг	e) хоёр чамархай болон шанааны үс

A. 1c2e3b4a5d B. 1c2a3b4d5e C. 1e2c3b4d5a
D. 1a2b3c4d5e E. 1e2c3a4d5b

2. *“Үүрийн өмнөх үнэгэн харанхуйгаар дайсны зүгээс гэнэт буу тачигнаж гарав.”* өгүүлбэрийн онцолсон үгийн утгыг олоорой.
A. нар мандахын өмнөх хэсэг үе
B. шөнийн харанхуй
C. цагаан гэгээ тасрах үе
D. нар шингэж харанхуй болох үе
E. нэг хоногийн үдшээс өглөө хүртэлх цаг хугацаа

3. “Гашуун заяаныхаа эрхээр эх орноо орхисон нүгэлтэн би...” гэсэн санааг батлах баримт аль нь вэ?
A. нутгийн барга баяны хүүгийн өмнөөс цэрэгт явсан чинь Японы армид орж, нутгийнхаа хил дээр ирлээ.
B. төрөөс Егүзэр хутагтыг баривчлан хороосонд балмагдан айсан, гомдож хорссон олон шавь нь хил даван өвөрлөгч рүү оргоход Бордэрэм тэднийг даган одсон
C. амьд явбал төрийнх нь ял цаазаар нүглээ цагаатгая. Зууртаа алагдвал намайг монгол хүү байсныг итгэхийг гуйя.
D. их гэгээнтэн ухаантай хүн байсан болохоор төрийн цаазанд толгойгоо өгсөн ч, төрсөн газраасаа сүнс нь гараагүй байлгүй.
E. өдрийн бодол, шөнийн зүүд минь төрсөн нутаг минь болж, хойд зүгийг ширтэн зүрхэндээ уйлж явсан

4. Өгүүлэгчийн тааварлан барагцаалж буйг илтгэсэн өгүүлбэрийг олоорой.
A. Залуу мөртлөө одоогийн надаас ч хашир хүн байсан байгаа биз.
B. Нэг шөнө би нөхөртэйгөө хамт харуулд гарсан юм сан.
C. “Нээрэн үү” хэмээн дув дуугүй намайг ширтээд ярьсныг минь сонсов.
D. Тэр амьдаар нь барихыг бодсон биз.

E. Холоос очсон намайг сонжих мэт үе үе ажиглан байгаа цэхэр хүрээ суусан жартгай нүд нь ч гэсэн аргагүй л хашрыг илтгэнэ

5. *Залуугийн хөөрүү сэтгэлдээ дийлдэн явж амьдаараа хатах зовлон олсноо би сүүлд мэдрэн гасалж байлаа*.- өгүүлбэрийн санааг хэлцээр илэрхийлснийг олоорой.
   A. Хийхийн өмнө бод
      Хэлэхийн өмнө цэгнэ
   B. Дол үзсэн догь толгой
   C. Урт бодож, уужим сэтгэх
   D. Зусарч хүн зулгаа барна
   E. Е. Аяыг нь мэдэхгүй алсын газар
      Алийг нь ч танихгүй харийн улс

6. Бордэрэм хэдийд өөрсдийнхөө бууны суманд өртсөн бэ?
   A. үүрийн гозон гэгээнээр
   B. үүрийн өмнөх үнэгэн харанхуйгаар
   C. нар цухуйж байхад
   D. элс самардан мөлхөж байх үедээ
   E. манхны наад руу зүгээр л өнхрөн бэлд нь хүрэх үед

7. "*Түүний байдгаараа бүлтийсэн хоёр нүд нь Монголынхоо халуу дүүгэсэн хөх тэнгэрийг гөлрөн ширтэх мэт*."- өгүүлбэрийн дүрслэх ур маягийг олоорой.

   A. зүйрлэл B. төлөөлөл C. адилтгал
   D. тойруулал E. хүншүүлэл

8. Эхийн сэдэв буюу дэвшүүлэн тавьсан асуудлыг олоорой.
   A. Халх голын дайны тухай
   B. Тавин жил нуусан нэгэн зурвасын тухай
   C. Эх орноо орхисон нүгэлтний тухай
   D. Эх орон, эх нутаг аминаас ч үнэтэй байдаг тухай
   E. Хожимдсон ухаарлын тухай

9. Эхийн гол санааг илэрхийлсэн тулгуур өгүүлбэрийг олоорой.
   A. Цаг түгшүүртэй. Япончууд Халх голын цаад талд хүчээ хуралдуулж байв.
   B. Залуугийн хөөрүү сэтгэлдээ дийлдэн явж амьдаараа хатах зовлон олсноо би сүүлд мэдрэн гасалж байлаа.
   C. Өдрийн бодол, шөнийн зүүд минь төрсөн нутаг минь болж, хойд зүгийг ширтэн зүрхэндээ уйлж явсан өдрүүд ард хоцорч байна.
   D. Хувь заяаны ширүүн салхинд туугдаж харь газарт очсон юм. Гэвч тэнд гэгээн хутагтын минь сүнс ч очсонгүй.
   E. Мажиг гуайн үрчлээт нүүр тэнийсхийх шиг болон инээмсэглээд "Нэг байтугай хэдэн нас заяасан ч уйдаж салахын аргагүй нутаг шүү" гэлээ.

10. Эхийн онцолсон хэсэг нь тоочимж болохыг баталсан хэсгийг олоорой.
   A. Шалтгаан, үр дагавар, дүрэм тодорхойлолтод тулгуурлажээ.
   B. Юмс үзэгдлийн гол шинжийг нарийн дэс дараалалтай зураглан бичжээ.
   C. Хэрэг явдлын бодомжийн харьцаанаас шинэ дүгнэлт гаргажээ.
   D. Хэрэг явдлыг өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагт хүүрнэн бичжээ.
   E. Агуулга нь баримт жишээнд тулгуурлажээ.

ХОЁРДУГААР ХЭСЭГ [30 оноо]

2.1 Дараах эхийн хэсгийг уншаад зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай 1 үгийг олбол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо. [5 оноо]

Мал хорогдох вий гэхээс малдаа сэтгэл хорогдоно. Малаа намар сайн таргалуулвал хавар эрт тараглана. Дэлхий бөөрөнхий учир хүн гэрээсээ гараад ямагт өрнө зүгт явбал дорно зүгээс эргэж ирэх юм. Багш сурагчидаа ажил хуваарилав. Ижил буруу мал дасан дасзанасаар ижилсдэг байна. Хөдөлмөр бүхэн багаштай. Энгийн хүний ажишгүй зүйлийг шинжээч хүн ажина.

Ташаарсан нь	Залруулсан нь

2.2 Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. [5 оноо]



2.3 “Ухаарал” сэдвээр эх зохион бичээрэй. (Бичихдээ бүтэц, хэв шинж, сэдэв, агуулгын харьцаа болон найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглаарай) Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 150-180/ [20 оноо]

Хувилбар 12

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ [20 оноо]

Хялгасаар зүссэн чулуу

Ханхөхийн нутагт шинэ зам засуулж явсан залуу инженер Батболд нутгийн өвгөн Дорлигоос энэ домгийг сонсоод хот газар суудаг эхнэртээ захидал илгээжээ. Эхнэр нь үеийн бүсгүйчүүлдээ, тэд нар нь цааш нааш дамжуулан тарааснаас би сонслоо. Чухам үүнээс урьд хэдэн үе дамжин ярилцсаар хорьдугаар зууны сүүлийн хагаст хүрч ирснийг бүү мэд. Харин Дорлиг өвгөн Батболдод яагаад ийм домог ярих болсны хамаг учрыг тэр инженер захидалдаа тодорхой бичсэн байна.

Хүлэг морь, сарлагийн шарын туурайгаар гарсан нарийн жимийг тэлж атан тэмээ, ачааны тэрэгний даваа болгон засахын учир Дорлиг гуай шүүрс алдан хэсэг зуур дуугүй сууснаа инженерийг дуудаж онцгойдуухан аваачаад:

- Хүүхээ энэ даваг сэтлэхгүй байвал яасан юм бэ? Ийм өндөр даваа сэтэлнэ гэдэг мөн ч их ажил аа даа. Энэ жилдээ л лав барагдахгүй шүү дээ гэсэн гэнэ. Батболд, өвгөн хөтчийн татгалзсаны учрыг мэдэлгүй,
- Юу байх вэ, Дорлиг гуай. Бид чинь энэ байтугай өндрийг сэтэлж, өргөн голыг дамнуулан гүүр барилаа шүү дээ. Үүнийг сэтлээд зам гаргачихаар танай нэгдлийн машин тэрэгний зам наанадаж хоёр өртөө дөт болно, малчдын нүүдэл суудалд ч хэчнээн дөхөм хялбар болох билээ гэжээ. Өвгөн унтарсан тамхитай гаансаа хэдэнтээ хий сорсноо,
- Аа тийм бол яах вэ дээ. Цагийн юм цагтаа гэдэг хойно. Уул нь энэ даваны овоон дээрх авдрын хэрийн хоёр хар чулууны тухай тун сонин домог байдаг юм. Урьд цагт нэг чулуу байсан юм гэнэ билээ. Энжнээр та дуулсан ч болов уу даа? гэв. Батболд домгийг урьд өмнө сонсоогүйгээ хэлээд ярьж өгөхийг өвгөнөөс хүссэн учир тэр орой хоёулаа хэдэн хувин айраг уунгаа ярилцжээ.

... Эрт урьдын цагт энэ нутагт нэгэн бэлэвсэн авгай өнчин хүүгийнхээ хамт аж төрөн суудаг байжээ. Тэр хоёрын амь зуулга гэвэл унааны ганц цагаан гүү, ундны сүүний таван ямаа аж. Хүү нь эрийн цээнд хүрч, хүлгийн дөрөө дөрөөлөн тарвага зурамхан агнаж хоногийн хоол хүнс олох болов. Эх хүүгийн амьжиргаа ийнхүү дэвжин дээшлэхийн үест гэнэт нэгэн элч довтлон ирж, хүүг нь эзэн хааны цэргийн албанаа татжээ. Хөөрхий эмгэн эзэн хааны элчийн өлмийд сөхрөн унаж, - Эзэн дээдийн зарлигийг гүйцэтгэгч элч та соёрхож хайрла. Амьдрах наран, амьжрах гар минь болж заяасан ганц үрийг минь энэ албанаас энэрэн хэлтрүүлж , уул харах нүдгүй, уушги даах шүдгүй болсон намайг гялайлгаж хайрлаач. Өр төлөөс болгож унах унаа, өвлөх хөрөнгө, урц гэрээ ч болов харамгүй өргөн барья гэжээ. Элч хариу өчсөн нь:

- Буман зовлон үзсэн буянтай буурал чи сонс. Хааны зарлигийг халах, эзний шийдийг эвдэх эрх хэнд маань бий сэн билээ. Би таны хүүг цэргийн албанаас чөлөөлж яахан чадна. Та сэтгэлээ тал мэт уужим тавьж, санаагаа далай адил ариун байлгаж хүүгээ хүлээ. Хүү тань дайснаа дарж, дархан цолоо мандуулаад эргэж ирнэ. Тэр сайхан цагт тээр тотгоргүй учрахыг тэнгэр бурхан мэднэ гэжээ.

Хүүгийнх нь гаталж гарсан голын ус гурвантаа хөлдөж, гурвантаа гэслээ. Харь нутгаас ирсэн айлчин шувууд үр төлөө дагуулан ганганан гунганасаар өмнийг гурвантаа зорилоо. Гэлээ ч хөөрхий эхийн хатсан элгийг дэвтээх юм даан чиг болсонгүй ээ. Нутгийн нэр цуутай бөөд саалийн хэдэн ямаагаа барьц болгон өргөөд аврал тус эрж,

- “Мянган мэлмийт, түмэн сонорт тэнгэр дээдэс минь

Усан нүдтэй, цусан зүрхтэй хилэнцэт доорд намайг ганц хүүтэй минь амар мэнд уулзуулж хайрлаач” гэж гуйжээ. Бөө: - Ай хөөрхий зайлуул. Ганц хүү чинь айх аюулгүй, зовох зовлонгүй амар мэнд явж байна. Буцаж ирэх нь болзолгүй, эргэж уулзах нь итгэлгүй юм байна. Удаан түргэн ирэхийн учрыг гагцхүү эх чиний чин зориг шийднэ.

Хүүгийн чинь даваад явсан даваан дээр байгаа бул хар чулуу ирэх замыг нь хааж байна. Тэр чулууг хялгасаар зүсэж хуваасан цагт хүү чинь саадгүй ирнэ гэжээ. Үрээ мөрөөдөхийн зовлонд шаналсан эх замын саадыг арилгахаар бул чулууг гурван жил, гурван сар, гурван хоног хялгасаар хөрөөдсөөр зүсэж хуваасан гэдэг домогтой юм даа, хүү минь гэж хөтөч өвгөн ярьжээ.

- Тэгээд хүү нь ирээ болов уу? гэж залуу инженерийг асуухад өвгөн:
- Нэг жил ганц цагаагч гүүнээс нь эр хар унага гарчээ. Хөөрхий эх өлзийшөөн баярлаж, “Хүүгийн минь хүлэг морь хүрээд ирлээ. Одоо хүү минь мөдхөн ирнэ” гэж хөл газар хүрэхгүй хөөрөн чулуугаа улам ч хурдан хөрөөдөж гэнэ. Тэгтэл гай болж хялгас дуусаад олдохыг байв гэнэ. Сандрахдаа гүүнийхээ шодон сүүлийг хяргахаар очтол гүү нь унаганыхаа жавар талд нь нөмөрлөн зогсож байхаар нь “Хөөрхий дөө, энэ адгуус ч болтугай үрээ даарч хөрөхөөс биеэрээ хамгаалж байхад дэлийг нь авчхаад одоо бас үлдсэнийг нь мухарлах гэж үү? Яаж болох вэ? Тэгснээс...“ гээд бууралтсан гэзгээ хярган авч чулуугаа зүссэн юм гэнэ билээ. Гэлээ гээд дайн тулаанд эрсэдсэн хүү нь яахан амилж ирэх билээ” гээд өвгөн хууч яриагаа өндөрлөжээ.

Батболд захидлынхаа төгсгөлд: “Домогт зүсмэл чулууг байсан янзаар нь үлдээж , даваг өөр газраар сэтэлж байна гэж бичжээ.

/ М.Гүрсэд /

1. Дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийн дугаарыг олоорой.

1. Хөтөч	а) Амьтны үс ноосны ширхэг

2. Бэлэвсэн	b) Асар их тээр саад
3. Жим	c) Хань нөхрөө үхүүлсэн эргүй эм
4. Хялгас	d) Маш нарийн ором зам
5. Бул	e) Зам зааж дагуулан явах хүн

A. 1d 2e 3b 4a 5c B. 1d 2c 3e 4a 5b C. 1e 2c 3d 4a 5b
D. 1e 2d 3c 4a 5b E. 1c 2d 3e 4a 5b

2. Нутгийн өвгөн Батболдод дээрх домгийг ярьсны учир юу вэ?
   A. Хоёр хар чулууны домгийг таниулах гэсэндээ
   B. Уул даваагаа сэтлүүлэхгүй, буй хэвээр нь авч үлдэх гэсэндээ
   C. Эх хүний үрээ гэх сэтгэл хэчнээн агуу гэдгийг мэдрүүлэх гэсэндээ
   D. Хааны эзний алба, зарлиг тийм хэцүү хатуу байсныг сонирхуулах гэсэндээ
   E. Үргүй хүн үхэхийн цагт гутамшиг гэдгийг мэдрүүлэх гэсэндээ
3. Атан тэмээ, хүлэг морь, сарлагийн шар, ... гэсэн холбоо үгсийн эгнээнд орох үгийг нь сонгоорой.
   A. Зусган хонь B. Адуу C. Буур D. Ирэг E. Бух
4. "Эзэн дээдсийн зарлигийг гүйцэтгэгч элч та соёрхож хайрла" гэсэн өгүүлбэртэй хэлэх аялгаар эсрэгцэх өгүүлбэрийг сонгоорой.
   A. Хөөрхий эмгэн эзэн хааны элчийн өлмийд сөхрөн унаж
   B. Усан нүдтэй, цусан зүрхтэй хилэнцэт доорд намайг ганц хүүтэй минь амар мэнд уулзуулж хайрлаач.
   C. Буман зовлон үзсэн буянтай буурал чи сонс.
   D. Би таны хүүг цэргийн албанаас чөлөөлж яахан чадна.
   E. Ай хөөрхий зайлуул.

5. Эхэд дэвшүүлсэн асуудал буюу сэдэв нь юу вэ?
   A. Байгаль эжийн тухай
   B. Эхийн сэтгэлийн тухай
   C. Бүтээн байгуулалтын тухай
   D. Домгийн тухай
   E. Хоёр хар чулууны тухай

6. Эхийн гол санааг зөв тодорхойлсон хэсгийг сонгоорой.
   A. Монголчууд эх болсон байгалиа эжий шигээ хайрладаг.
   B. Эх хүний үрээ гэх сэтгэл юутай ч зүйрлэшгүй агуу.
   C. Эх болсон байгалиа ариун дагшнаар нь авч үлдэх хэрэгтэй.
   D. Тухайн цагийн шинэ зам гүүр тавих ажил манай орны хөгжилд чухал нөлөө үзүүлсэн .
   E. Домог хуучаас ихийг мэдэж авдаг.

7. "Сэтгэлээ тал мэт уужим, санаагаа далай мэт ариун байлга" өгүүлбэрийн дүрслэх ур маягийг зөв тайлбарласан хэсгийг дугуйлаарай.
   A. Сэтгэлийг талтай, санааг далайтай адилтгасан.
   B. Сэтгэлийг талаар, санааг далайгаар төлөөлүүлсэн.
   C. Сэтгэлийг тал, санааг далай хэмээн ихэсгэсэн.
   D. Сэтгэлийг талтай, санааг далайтай зүйрлэсэн.
   E. Сэтгэлийг талтай, санааг далайтай зүйрлэн ихэсгэсэн.

8. "Үрээ мөрөөдөхийн зовлонд шаналсан эх замын саадыг арилгахаар бул чулууг гурван жил, гурван сар, гурван хоног хялгасаар хөрөөдсөөр зүсэж хуваажээ." гэсэн өгүүлбэрийн санааг хэлцээр илэрхийлээрэй.
   A. Сэгсгэр ч гэсэн ээж минь
      Сиймхий ч гэсэн гэр минь
   B. Эхт өнчин өөдөлдөг
      Эцэгт өнчин урууддаг
   C. Эхийн санаа үрд
   D. Эхийгээ муулбал
      Сүн далай ширгэх
   E. Эхтэй хүн элэг зузаан

9. “Хүсэн, гуйсан” утга аль өгүүлбэрээр илэрч байна вэ?
   A. Ийм өндөр даваа сэтэлнэ гэдэг мөн ч их ажил аа даа.
   B. Хааны зарлигийг халах, эзний шийдийг эвдэх эрх хэнд маань бий сэн билээ.
   C. Ганц үрийг минь энэ албанаас энэрэн хэлтрүүлж, уул харах нүдгүй, уушги даах шүдгүй болсон намайг гялайлгаж хайрлаач.
   D. Ай хөөрхий зайлуул. Ганц хүү чинь айх аюулгүй, зовох зовлонгүй амар мэнд явж байна.
   E. Өр төлөөс болгож унах унаа, өвлөх хөрөнгө, урц гэрээ ч болов харамгүй өргөн барья.

10. Эхийн үйл явдлыг зөв дараалалд оруулсан хэсгийг олоорой.
   1. Гэлээ ч хөөрхий эхийн хатсан элгийг дэвтээх юм даан чиг болсонгүй ээ.
   2. Хүүхээ энэ даваг сэтлэхгүй байвал яасан юм бэ?
   3. Хүүгийн чинь даваад явсан даваан дээр байгаа бул хар чулуу ирэх замыг нь хааж байна.
   4. Тэгтэл гай болж хялгас дуусаад олдохыг байв гэнэ.
   5. Урьд цагт нэг чулуу байсан юм гэнэ билээ.
   6. Эх хүүгийн амьжиргаа ийнхүү дэвжин дээшлэхийн үест гэнэт нэгэн элч довтлон ирж, хүүг нь эзэн хааны цэргийн албанаа татжээ.

A. 5, 6, 2, 1, 3, 4 B. 2, 5, 6, 1, 3, 4 C. 2, 6, 3, 1, 5 ,4
D. 2, 5, 1, 6, 3, 4 E. 1, 3, 5, 2, 4, 6

ХОЁРДУГААР ХЭСЭГ [30 оноо]

2.1 Дараах эхийн хэсгийг уншаад зөв бичих дүрмийн алдаатай 5 үг олоод, засаж бичээрэй. Алдаатай нэг үг олбол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо. [5 оноо]

Хангайн сайхан нуруунаас гарсан Идрийн сайхан гол өндөр уулнаас буусан тул урсгал түргэн түргэн, бас л хөгжим шиг шуугьна. Хажууд нь суун чагнахад үнэхээр тааламжтай. Хүний өнгөрүүлэх зам ямар болхыг юунд урьдаас тайлбарлаж үл өгнө. Энэ тунгалаг ариун мөрөн хэчнээн мянган жил хэв хэвээр урссаар байтал, эрэг дагуу оршсон ёс гэтэл хүн амьтаны түүх байн байн хувилсаар ирэх нь тэмцээний үр байжээ. Орчин тойрон зэргэлсэн уулс бэрх өндөр, сэрвэн хад сэхийлцэн сахайлцан сүр жавхлан хэтэрхий, ой шугуй нягт зузаан, ус булаг хоржигнон хуржигнана.

Ташаарсан нь	Залруулсан нь

2.2 Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. [5 оноо]



2.3 “Эрдэнэ” сэдвээр эх зохион бичнэ үү. Бичихдээ эхийн сэдэв, агуулга, бүтэц, хэв шинж, найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл, уран дүрслэлээр баяжуулахыг зөвлөж байна. Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 150-180/ [20 оноо]

….....

Хувилбар 13

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ [20 оноо]

Итгэл хүлээж, урам өгөх нь жаргал болдог

Баянгол дүүргийн ...дүгээр сургуулийг нийслэлийн жишиг сургууль гэхэд буруудахгүй биз. Сургуулийн хөгжил менежментээсээ хамаарна. Зөв менежментийг сайн захирал удирдан чиглүүлнэ. Тус цогцолбор сургуульд энэ тохироо бүрджээ. Сургуулийн захирал нь үнэхээр итгэл даах хүн аж.

Өөдлөх айл өнгөнөөсөө гэж хэлэх нь бий. Өнгийг нь тандлаа. Өнгөлөг байна даа гэж бодогдсон. Эмх цэгц гэж энэ сургуульд ярилтгүй аж. Эмх цэгц нь дэглэм журмаа дагаж жигдэрдэг нь ёс. Захирал эмх цэгц, дэглэм журам хоёрыг эвцэлдүүлж чаджээ. Зарим нэг сургуульд үзэгддэг эрээн мяраан элдэв зураг, тайлбар, танин мэдэхүйн ач холбогдол багатай зүйл бараг алга. Харин нийслэл Улаанбаатар хотын үзэсгэлэнт газруудыг тов тод дүрслэн харуулсан нь хараа булааж байлаа.

...Юуны түрүүнд аливаа үйлдийнхээ учрыг олж, хужрыг тунгаахыг эрхэмлэдэг нь захирлын гэм биш, зан бололтой. Тэдний сургуулиас олдохгүй юм гэж байгаа болов уу. Нэг л юм олдохгүй. Тэр нь тогтоосон цагаасаа хоцорч эхэлдэг сургалт хүмүүжлийн ажил. Сургууль нь хаанахын аль ч сургуулийн хэнд ч гологдохгүй цөөн хэдэн танхимтай. Тэдгээр танхим нь яг л зориулалтынх. Бусад сургуулиас туршлага судлахаар очсон багш нар нүд хужирладаг биз. Тэдний сургууль тун ойрмогхон архиваа өөрчлөн шинэчилж, үлгэр жишээ гэмээр болгосон билээ. Аливааг хийе бүтээе гэсэн энэ хамт олонд сэтгэл дутаж, ур чадвар үгүйлэгдэх бэрхшээл тохиолдохгүй нь лавтай юм гэж надад санагдсан.

Номын сангаас эхлээд хүүхдийн нүдэнд туссан бүхэн танин мэдэхүйн ач холбогдолтой байвал үр дүн нь илүү байдаг гэж захирал үздэг байна. Тэрээр сургуулийнхаа номын санг танилцууллаа. Сургууль бол номын цагаан буян шингэсэн газар. Номгүй сургууль гэж энэ орчлонд үгүй. Сургуульгүй ном юунд хэрэгтэй гэж хэнд ухуулж хэлэх вэ? Энэ хамаарлыг ойлгохгүй хүн гэж үгүй байх. Харин энэ хамаарлыг чухам яс махандаа тултал ойлгосон хүнийг нэрлэ хэмээвэл тус сургуулийн захирал, багш, сурагчдыг онцлон нэрлэмээр санагдсан. Захирлыг номын сангаа танилцуулж байхад номын санч нь жинхэнэ “ясны” номын санч хүн юм даа гэсэн бодол уягдаж байсан сан. Бас энэ номын санч шиг номын санчийг сургууль бүрд ажиллуулж хүрэлцэхгүй байх даа гэсэн үл биелмээр мөрөөдөлд автаж сууснаа нуугаад яах вэ. Тэр зөвхөн ном уншуулдаг хүн биш юм. Хүүхдүүдийн эрдмийн жолоог нь залж, оюун сэтгэхүйг нь хөгжүүлэх олон төрлийн ажил зохиодог, ер нь л ном уншлагын багш юм билээ. Тэрээр номыг тойруулан АСК, АХА тэмцээн зохиох, номыг сэлбэн сайжруулж, үлгэрийн баатрын дүр бүтээх, номын өртөөгөөр аялах, тэдэнд ном сонгох, унших, эрж олох талаар зөвлөгөө өгөх гээд эцэс төгсгөлгүй олон хэлбэрийн ажлыг санаачлан зохиодог аж. Номын сан байнгын ажиллагаатай байдаг нь түүний хэрхэн ажилладгийг батална. Номын санч сайн ажиллана гэдэг бол хүүхдүүд номтой нөхөрлөдгийн нэгэн илэрхийлэл. Эдний сургуулийн олонх хүүхэд Д.Нацагдорж тэмдэгтэн гэнэ. Ийм сургууль хот хөдөөд хэр олон байдгийг мэдэхгүй юм. Харин энэ сургуулийнхан номтой нөхөрлөж, номын амт шимтэд нэгэнт орсон гэдгийг захиралтай нь ийнхүү ярилцаж байхдаа бодож суулаа. Р.Цэгмид “Нээлттэй сургууль” сонин

1. Нийтлэлийн гол баатрыг нэрлэнэ үү.
A. захирал B. Р.Цэгмэд C. номын санч D. Хүүхдүүд E. сургууль

2. Ямар тохироо бүрдсэн нь “Эрдмийн өргөө” цогцолбор сургууль хөгжих нөхцөл болсон бэ?
A. Сургуулийн эмх цэгц, дэглэм журам
B. Зөв менежмент, сайн захирал
C. Номын санч, сургуулийн номын сан
D. Хийж бүтээх сэтгэл, ур чадвар

E. Сургууль бол номын цагаан буян шингэсэн газар.

3. Сургуулийн захиралд байхгүй чанарыг олоорой.
A. итгэл даах хүн
B. эмх цэгц, дэглэм журмыг эвцэлдүүлж чаддаг хүн.
C. ажил нь тогтоосон цагаасаа хоцорч эхэлдэг.
D. хийж бүтээх сэтгэлтэй, хийж чаддаг хүн.
E. учрыг олж, хужрыг тунгаахыг эрхэмлэдэг.

4. Номын санчийг нийтлэлд хэрхэн онцолж, тодорхойлсон бэ?
A. ном уншуулдаг хүн
B. ном уншлагын багш
C. ном хариуцдаг хүн
D. Д.Нацагдорж тэмдэгтэн хүн
E. номын талаар зөвлөгөө өгдөг.

5. Өгүүлэгчийн бахархах сэтгэлийн өнгө аясыг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
A. Эмх цэгц гэж энэ сургуульд ярилтгүй аж.
B. Аливааг хийе бүтээе гэвэл сэтгэл дутаж, ур чадвар үгүйлэгдэх бэрхшээл энэ хамт тохиолдохгүй нь лавтай.
C. ... энэ сургуулийн номын санч “ясны” номын санч хүн юм даа гэсэн бодол уягдаж байсан сан.
D. эдний сургуулийнхан номтой нөхөрлөж, номын амт шимтэд шавь нар нь нэгэнт орсон бололтой.
E. Номын санч сайн ажиллана гэдэг бол хүүхдүүд номтой нөхөрлөдгийн нэгэн илэрхийлэл.

6. “ясны номын санч”- гэсэн холбоо үгийн “ясны” гэсэн үгийн утгыг олоорой.
A. яс сайтай хүн
B. жинхэнэ мэргэжлийн хүн
C. хүний мөс чанар сайтай хүн
D. олон ажил санаачлан хийдэг хүн
E. ажилд хариуцлагатай

7. Туршлага судлахаар очсон багш нар нүд хужирладаг. – гэсэн өгүүлбэрийн “нүд хужирладаг” гэсэн хэлцийн утгыг олоорой.
A. шимтэн үздэг
B. гайхан биширдэг
C. анхааралтай хардаг
D. баярлан магтдаг
E. их юм уншдаг.

8. “учрыг олж хужрыг тунгаах” гэсэн хэлцийн утгыг илэрхийлэх үгийг олоорой.
A. яаруу B. ууртай C. нухацтай D. тайван E. ухаантай

9. “ Хүүхдийн нүдэнд туссан бүхэн <u>танин мэдэхүйн ач холбогдолтой байвал</u> үр дүн нь илүү байдаг” - гэсэн нийлмэл өгүүлбэрийн тодотгосон өгүүлбэр дараагийн гол өгүүлбэрээ ямар утгаар дэлгэрүүлж байна вэ?
A. цагийн утгаар
B. шалтгааны утгаар
C. орон байрын утгаар
D. шинж чанарын утгаар
E. зорилгын утгаар

10. “Хүүхдийн эрдмийн жолоог нь залж” – өгүүлбэрийн “жолоо”- гэсэн үгийн утгыг зөв тайлбарласан хэсгийг олоорой.
A. залуурыг барьж жолоодох хүн
B. хазаарын зуузайд уясан, залж удирдах оосор
C. удирдах залуур
D. тэргүүлэн удирдах хүн
E. эрдмийн түлхүүр

ХОЁРДУГААР ХЭСЭГ [30 оноо]

2.1 Дараах эхийн хэсгийг уншаад зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай нэг үгийг олбол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо.[5 оноо]

Юм бүхэнд хэмжээ дамжаа хэрэгтэй. Илүүдсэн бүхэн хор болдгын адил ааш хэтэрвэл амьдралд цөвтэй. Авиргүй ааштай нөхрөөс амжаж түргэн холд. Илүү дутуу ааш араншингүй хүнтэй эвэлж зохицох амархан. Шудрага үг чихэнд хатуу ч явдалд тустай болхоор анд нөхрийнхөө алдаа оноог алдалгүй хэлж тусал.

Ташаарсан нь	Залруулсан нь

2.2 Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. [5 оноо]

Хөдөлмөр бол хүний амьдралыг баяжуулах, хөгжлийг хангах, нийгмийн ашиг тусыг бүтээдэг, хүний чадвар, ур чадвараас хамаарсан, ухаалаг, бүтээлч, ажилсаг, хүчтэй, эрүүл, ухаантай, ёс суртахуунтай, эх орондоо, ард түмэндээ, ажил хэрэгтэй, ... гэж ... гэдэг.

2.3 Өгөгдсөн хэсгийн гол санааг хадгалан түүнийг нэмэн дэлгэрүүлж, эх зохион бичнэ үү. Бүтээлчээр ургуулан бодож бичихдээ аль болох оновчтой үг хэллэг, уран яруу дүрслэл, баримт мэдээлэл ашиглаж, найруулга зүйн шаардлагыг ханган бичихийг зөвлөж байна. Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 150-180/ [20 оноо]

Би гагцхүү сайн үйлсээр амьдрах гэж газар дэлхийдээ ээзэн нь болж ирсэн.

Хувилбар 14

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ [20 оноо]

Бодончар богд

Бодончар орогшин хул мориныхоо согсоо гөхлийг ширтэн гэлдрүүлж явна. Тэр мунхаг ядуу гэж урагт үл тооцогдон ах нартаа адлагдан хөөгдсөндөө нэг их гутарсан ч үгүй. Харин ч ухаан тэлж, нэгийг бодон хоёрыг эргэцүүлэх хугацаатай боллоо гэж тайвширна. Олон сүргийн дундаас зүс буруу гэж энэ муу гол дайрт годил сүүлт орогшин хул морийг ах нар маань өгсөн юм. Нээрээ

морины минь гөхөл гэхэд л тийм гэж зүслэхийн аргагүй түмэн өнгийн үс холилдсон нь сонин юм. “Орогшин хул морь минь чи тэнгэрийн хөвгүүн хаан хүний нөхөр, эрдэнэт хүлэг гэдгээ мэдэж ав” гэж Бодончар мунхаг морьтойгоо ярьж явлаа.
Орогшин хул морь нь хэрэмний чих шиг урт шар хялгастай, бор улаан, ягаавтар зүс холилдсон үзэмжит урт чихээ солбиулан “За ойлгож байна аа эзэн богд минь” гэх шиг ялаархан, хазаар дарна. Бодончар мунхагт ах нар нь нум сум ч өгсөнгүй. Харин хүрэл бууран сав хоёрыг, нэг жижиг тогоо төдийхөн хувь хүртээснийг ширэн богцондоо хийн ганзагалжээ. Бодончар Алунгоо эхийнхээ таван мөсний сургаалыг эргэцүүлэхийн сацуу гэдсээ тэжээх аргыг мөн сүвэгчлэн хялгасан урхи томж түүгээрээ нэгэн харцага барьж аваад модны ёроолоос аргамжиж орхиод, эмбүүл суулаа ойн нууцхан чөлөөнд барив. Тэнгэр язгуурт Бодончар богдыг идэр насандаа ах нарын мунхгаас болоод өвсөн эмбүүлд толгой хоргодож байсныг миний орогшин хул морь, анч бор харцага хоёроос минь өөр амьтан мэдэх учиргүй гэж өөртөө тангараглав. Харцага нь Бодончарт заяагаар тохиосон бололтой. Нугас галуу барих аргыг төдөлгүй сурч эзнээ тэжээж эхэллээ.
Бодончар, амьдарч байгаа Балжийн арал гэдэг газраасаа тэрүүхэн дорогш буусан нэгэн бүлэг иргэнийд бууж мордон цэгээ уудаг болов. Тэрхүү бүлэг хүмүүс их бага, сайн муу, толгой шийр цөм нэгэн адил чацуу байгааг ажиглаад, эзлэхэд тун хялбар иргэн юм даа гэж бодох болов. Мөнөөх бүлэг иргэн гол дайрт, годил сүүлт орогшин хул морьтой, эр бор харцага барьсан хорь гаруйхан настай, идэрмэг сэргэлэн үг яриатай залуу эрийг ихэд сонирхон, байгаа бүхнээрээ дайлж цайлавч чухам түүнийг хаана амьдардаг, ямар овгийн хүмүүн болохыг асууж шалгаасан нь нэгээхэн үгүй. Харин эр бор харцагаа бидэнд өгөөч гэж ам бузарлаад авчээ. Бодончар энэ бор харцага бол орогшин хул морь бид хоёрын итгэлт нөхөр, миний сүлд хийморийн шүтээн юм гээд огт халгаасангүй. Түүнд, эрх чацуу бүлэг иргэд нэг их юм бодсонгүй, бас харцагыг яаж ингэж гаршуулдгийг ч асуусангүй. Бүлэг иргэний хүрээнд бууж гэдсээ цайлгасан Бодончар гэр сууц руугаа очиж, сэтгэлээ цайлгах минь гэж орогшин хул мориндоо хэлээд мордоно.
Муу мориныхоо ялаа ч үргээхгүй годил сүүлэнд хялгас нэмж, сугсарсан сүүлтэй болгосон нь орогшин хулд таатай сайхныг хэлээд яахав. Бодончар морио зүдрээчих вий гэж чонон шогшоогоор шогшсоор мөр зүгээ бага зэрэг буруулсхийн дөлсөөр, эмбүүл сууцнаа ирнэ.

Бодончарын эмбүүлийн хойморт Алунгоо эхийнх нь зүүж явсан тэнгэр шүтээн Бөртэ Чино, Хоо Маралын хүрэл зүүлт залаастай бий. Бодончар шүтээндээ залбираад, энэ шүтээн залаастай байгаа газар тэнгэрийн хөвгүүн газрын иргэдийг захирах хаан болгох хувь ирнэ гэдэг итгэлиг өвөрлөнө.
Намрын дунд сарын дүүрэн сартай нэгэн шөнө Бодончар эмбүүлийнхээ үүдэнд шөнөжин тэнгэр ширтэн суув. Тэнгэрийн заадас орогшин хул морины Балжийн арлыг баруунтаа нэг, зүүнтээ нэг давхисан цайвар зам шиг санагдана. Бодончар оддыг ширтэн одод хүртэл тод бүдэг, хол ойр байх атал энэ бүлэг иргэд ив ижил, тэв тэнцүү нь хачин юм гэж бодно. Бодончарыг эмбүүлдээ ирэхэд хоймрын хүрэл шүтээн сарны гэрэлд туяа цацраан гялсхийх шиг санагдаад орхив. Огт гялалзах учиргүй шүтээн минь яагаад гэрэл цацраах болов гэж Бодончар гайхасхийв.
Тэр шөнө идэр залуу Бодончарын зүүдэнд Алунгоо эх нь өвсөн эмбүүлд нь заларч мөнөөх хүүхэд ахуйд нь таван мөс багцлан, хугалуулах гэж байсан залуу дүрээрээ инээмсэглэн: Хүү минь. би чамд мөнөөх таван мөсийг авчирлаа. Миний хүү ах нартайгаа эв еийг эрхэмлэхийг хичээгээрэй. Мөн тэгээд бие тэргүүтэй, дээл захтайг бүү мартаарай гээд нэгэн их гэрэл цацруулаад үгүй болов. Бодончар тэр дорхноо сэрлээ. Сар шингэсэн тас харанхуй. Гадаа орогшин хул морь нь өвс ширд ширд хазлах дуулдана. Бодончар амандаа "Бие тэргүүтэй дээл захтай нь сайн, бие тэргүүтэй дээл захтай нь сайн" гэж шивнэлээ. Энэ үгийг мартаж болохгүй юм шүү гэж өөртөө андгайлав. (Ж.Саруулбуян)

1. “Бодончар орогшин хул мориныхоо **<u>согсоо</u>** гөхлийг ширтэн гэлдрүүлж явна.”- өгүүлбэрийн онцолсон үгийн утгыг олоорой.
   A. Мал амьтны шилбэ тагалцгийн уулзвар дахь хэсэг урт үс
   B. Унаганаас нь хяргаагүй ургуулсан дэл
   C. Шанхалж зассан дэл
   D. Адууны хоёр чихний хооронд үлдээсэн хэсэг үс
   E. Адууны хүзүү сэрвээний дээгүүр тууш ургасан урт хялгас
2. “Бодончарт хүрэл бууран сав хоёрыг, нэг жижиг тогоо төдийхөн хувь **<u>хүртээснийг</u>**... ганзагалжээ ” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг солин найруулахад утга найруулгын хувьд хамгийн тохиромжтой үгийг тэмдэглээрэй.
   A. түгээх

B. тараах
C. оноох
D. бэлэглэх
E. олгох

3. Боданчар мунхаг тэрхүү бүлэг иргэнийг эзлэхээр шийдсэн гол шалтгааныг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
A. Бүлэг иргэн бүгд ив ижил, тэв тэнцүү байх ёстой гэж үзсэн учраас
B. "....дайлж цайлавч чухам түүнийг хаана амьдардаг, ямар овгийн хүмүүн болохыг асууж шалгаасан нь нэгээхэн ч үгүй учраас
C. ...бүлэг хүмүүс их бага, сайн муу, толгой шийр цөм нэгэн адил чацуу байгаагүй учраас
D. Тэдгээр иргэн ...бие тэргүүтэй, дээл захтай байх ёстой гэж үзсэн учраас
E. Тэр мунхаг ядуу гэж урагт үл тооцогдон ах нартаа адлагдан хөөгдсөн тул

4. Боданчар мунхгаас орогшин хул мориндоо хандах сэтгэлийн өнгө аяс, үнэлэмжээрээ ялгаатай нэг өгүүлбэр байгааг олоорой.
A. Олон сүргийн дундаас зүс буруу гэж энэ муу гол дайрт, годил сүүлт орогшин хул морийг ах нар маань өгсөн
B. "....Орогшин хул морь минь чи тэнгэрийн хөвгүүн хаан хүний нөхөр"
C. ... Орогшин хул морь нь ч .... үзэмжит урт чихээ хайчлан"
D. Муу мориныхоо ялаа ч үргээхгүй годил сүүлэнд хялгас нэмж, сугсарсан сүүлтэй болгосон нь орогшин хулд таатай сайхныг хэлээд яахав
E. Бодончар морио зүдрээчих вий гэж чонон шогшоогоор шогшсоор...

5. Боданчар мунхгийн дараах үйлүүдийг нэгтгэн дүгнэсэн нэг хэлцийг олоорой. Бодончар мунхаг:
- Мунхаг ядуу гэж урагт үл тооцогдон ах нартаа адлагдан хөөгдсөн...
- Хялгасан урхи томж...нэгэн харцага барьж,..
- Эмбүүл сууцаа ойн нууцхан чөлөөнд барив
- Нэгэн бүлэг иргэнийд бууж мордон, цэгээ уудаг болов.
- Бодончар амандаа "Бие тэргүүтэй дээл захтай нь сайн, бие тэргүүтэй дээл захтай нь сайн" гэж шивнэлээ.

A. Мунхгийн санах нь хойноо, морины эцэх нь хойноо
B. Муу хүний хэрэг арван гурав, модон тэрэгний явдал түг таг
C. Сайн хүний санах сэрэх нь түргэн
D. Өмдгүй байж өвдөг цоорхойг шоолох
E. Амьд явбал алтан аяганаас ус уух

6. "Толгой шийр цөм нэгэн адил" гэсэн өгүүлбэрийн дүрслэх ур маягийг олоорой.
A. Хэтрүүлэл
B. Тойруулал
C. Егөөдөл
D. Төлөөлөл
E. Амьдчилал

7. Эхэд дэвшүүлсэн асуудал буюу сэдвийг олоорой.
A. Эв эе, ах захын ёсны тухай
B. Ах дүү нартаа хөөгдөж ядарч яваа Бодончар мунхгийн тухай
C. Хүний тэгш эрхийн тухай
D. Алунгоогийн хөвгүүдийн тухай
E. Орогшин хул морины тухай

8. Эхийн гол санааг олоорой...
A. Алунгоогийн хөвгүүд шиг үргэлжид эвдрэлцэж болохгүй.
B. Хүн ганцаар байхдаа их зүйл бодож ухаан тэлдэг
C. Хүмүүс эрх чацуу, ив ижил, тэв тэнцүү байх ёстой.
D. Эвлэх эелэх, ах захын ёсыг сахих хэрэгтэй.
E. Эр хүний нөхөр хүлэг морио хайрлах хэрэгтэй.

9. Үгсийн утгыг ажиглаад утгын өөр өөр хүрээнд хамаарах үгтэй хэсгийг олоорой.
A. Ялаархах, хазаар дарах, шогших, гэлдрүүлэх, давхих
B. Идэр залуу, урт шар, сайн муу, идэрмэг сэргэлэн, мунхаг ядуу
C. Орогшин хул, бор улаан, гол дайрт, годил сүүлт, зүс буруу
D. Хол ойр, намрын дунд сар, тэрүүхэн дорогш, дүүрэн сартай шөнө, баруун тийш
E. Хүрэл сав, жижиг тогоо, ширэн богц, хялгасан урхи, өвсөн эмбүүл

10. Намрын дунд сарын дүүрэн сартай нэгэн шөнө Бодончар эмбүүлийнхээ үүдэнд шөнөжин тэнгэр ширтэн суув. Тэнгэрийн заадас орогшин хул морины Балжийн арлыг баруунтаа нэг, зүүнтээ нэг давхисан цайвар зам шиг санагдана. Бодончар оддыг ширтэн одод хүртэл тод бүдэг, хол ойр байх атал энэ бүлэг иргэд ив ижил, тэв тэнцүү нь хачин юм гэж бодно.” цогцолборын хэв маягийг тодорхойлно уу.
    A. Тоочимж
    B. Тайлбарламж
    C. Хүүрнэмж
    D. Эргэцүүлэмж
    E. Хэв маягууд холилдсон

ХОЁРДУГААР ХЭСЭГ [30 оноо]

2.1 Дараах эхийн хэсгийг уншаад зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай нэг үгийг олбол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо. [5 оноо]

Хурмастын хөвсгөр зузаан үүлнээс нааш эргэлдэн бүжсээр орчлонгын элгэнд газардан унах сайхан цагаан цасан хорвоогийн амьсгалд уяран хайлж, ус болон хөрсөнд нэвчэж, эргээд хур болон тэнгэрт хөөрхийн адил хүний амьдрал ч эцэс төгсгөлгүй үргэлжлэн өөдлөж урууддаг тавилантай амуй. Өөдөлж уруудах гэдэг нь хөдөлгөөн аж. Хурдан болоод ирэхээрээ баяр болж, удааширан зогсохоор гуниг болдог юм биш байгаа.

Ташаарсан нь	Залруулсан нь

2.2 Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. [5 оноо]



2.3 Өгөгдсөн хэсгийн гол санааг хадгалан түүнийг нэмэн дэлгэрүүлж, эх зохион бичнэ үү. Бүтээлчээр ургуулан бодож бичихдээ аль болох оновчтой үг хэллэг, уран яруу дүрслэл, баримт мэдээлэл ашиглаж, найруулга зүйн шаардлагыг ханган бичихийг зөвлөж байна. Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 150-180/ [20 оноо]

Бүргэд хүртэл дэгдээхийгээ газарт буулгалгүй улам өндөр авхуулан хөөргөж, бүр эцэж цуцтал нь нисгэж сургадаг.

Хувилбар 15

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ [20 оноо]

А хэсэг

[...] Улаан шугамтай муутуу цаасан дээр бичсэн бичгийг нэг ч удаа түгдрэлгүй дуржигнуулан уншиж байгаа Эрдэнийг хараад Итгэлт ихэд гайхав.

- Торгон дээлтэй, нарийхан цагаан хуруутай ноён түшмэл нарын уншдаг бичгийг уранхай дээлтэй, туранхай царайтай хатуу ажилд эвэршиж борлосон гартай цагаачин уншиж байгаа нь Итгэлтэд үлэмж сонин хэрэг байв.

Итгэлт багадаа бичиг заалгах гэж оролдсон боловч сураагүй. Тэгээд одоо малынхаа дансыг хээлтэй малыг дотроо дугуйтай дөрвөлжин хүрээ, сувай малыг дөрвөлжин хүрээ хийх мэтийн тэмдгээр зурж тоолдог юм. Энэ учраас бичигтэй зарц өөрөө хүрээд ирнэ гэдэг бол зүүдлээгүй баяр байлаа.

Танай хошууныхныг хэцүү гэлцдэг. Гэвч олон мод өндөр намтай, олон хүн сайнтай муутай байдаг, бас тэгээд монгол ах дүү нар байна ядарсан хүнд туслахгүй яах вэ?! Ер нь шууд манай хаяанд ирээд бууж орхи гэж өрөвдсөн элэгсэг дуугаар хэлэв. Гачигдаж ядарсан хүн итгэхдээ амархан байдаг болохоор Итгэлтийн энэ үгэнд Эрдэнийн сэтгэл баяр найдвараар дүүрэв...

Б хэсэг

[...] - Итгэлт минь тэгээд тэр төлөөлөгч нь хэн гэж бодно. Санахаас бөөлжис хүрээд байна. Нөгөө танайд зарагдаж байсан гуйлгачин Эрдэнэ шүү гэж Бадарч “төлөөлөгч”, “гуйлгачин” гэдэг үгийг шүд зуун хэлэв.

-Эрдэнэ ээ! гээд Итгэлт жолоогоо угзран гэдрэг болов. Итгэлтийн бүх бие сулран, санаж явсан өргөн бодол нь атга элс цацсан юм шиг сарнин алга болж хоёр талын уул хавчин авах шиг боллоо. “Эрдэнэ надтай данс бодно.”, “Одоо яах вэ” гэдэг хоёр бодол жирэлзэн солигдож зогсолтгүй хариу шаардав.

-Тийм ээ. Тэр муу цагаачин, ноёны тамгыг хурааж авсан шүү гэхэд нь Бадарчийн нүд нүүр нь татганан чичирч байлаа. Харцаганд баригдах гээд бутны ёроолд бүлтгэнэж байгаа болжмор шиг болсон биеийнхээ байдлыг мэдмэгц Итгэлт бие сэтгэлээ барьж өвөр түрийгээ ухан гаанс тамхиа гаргаж аваад:

-Эрдэнэ ч чи бид хоёрын дэргэд эрдэм номтой хүн байхгүй юу гэлээ.

-Тэр гуйлгачны эрдэм ч нохой долоож үх дээ гэж Бадарч хэлээд мориноосоо буув...

(Ч.Лодойдамба,”Тунгалаг Тамир” романаас)

1. Дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийн дугаарыг олоорой.

1. муутуу цаас	a) Аливаа юмсыг жагсаан бичсэн дэвтэр, бүртгэл
2. цагаачин	b) Улс, буюу ардын нэрийн өмнөөс үүрэг хүлээсэн хүн
3. сувай	c) Олсоор хийсэн цаас
4. данс	d) Мал гөрөөсний боосохгүй жил өнжсөн нь
5. төлөөлөгч	e) Хэрэн хэсэж амьдрах хүн

A. 1c2e3b4a5d B. 1c2a3b4d5e C. 1e2c3b4d5a
D. 1a2b3c4d5e E. 1c2e3d4a5b

2. Итгэлт яагаад малынхаа дансыг тэмдэг дүрсээр тоолж тэмдэглэдэг вэ?
   A. Олон малтай учраас
   B. Бичиг үсэг тайлагдаагүй
   C. Хээлтэй, сувай малыг ялгахын тулд
   D. Өвгөдийн уламжлалыг дагаж
   E. Бог, бод малыг ялгахын тулд
3. Итгэлтийн зан төрхийн овжин, зальжин байдлыг илэрхийлсэн хэсгийг олоорой.
   A. Дуржигнуулан уншиж байгаа Эрдэнийг хараад Итгэлт ихэд гайхав.
   B. Цагаачин уншиж байгаа нь Итгэлтэд үлэмж сонин хэрэг байв.
   C. Итгэлт багадаа бичиг заалгах гэж оролдсон боловч сураагүй.
   D. Тэгээд одоо малынхаа дансыг ... тэмдгээр зурж тоолдог юм.
   E. Монгол ах дүү нар байна ядарсан хүнд туслахгүй яах вэ?!
4. Итгэлт “Ер нь шууд манай хаяанд ирээд бууж орхи.” гэж шуудхан хэлсний гол учир нь юу вэ?
   A. Уранхай дээлтэй, туранхай царайтай болохоор нь
   B. Цагаачин хүн болохоор нь
   C. Илтгэлт багадаа бичиг сураагүй учраас
   D. Бичигтэй зарц өөрөө хүрээд ирсэн болохоор

E. Ядарсан хүнд туслах бодол төрсөн учраас

5. А хэсгийн гол санаатай тохирох хэлцийг олоорой. А. Өөрөө ойчсон хүүхэд уйлдаггүй.
   B. Холыг бодвол хожмоо тустай.
   C. Ам бардам, гуя шалдан.
   D. Төрсөн газрын шороо эрдэнэ.
   E. Лам олдохгүй бол буцахдаа зална.
6. Б хэсгийн гол санаатай тохирох хэлцийг олоорой. А. Өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр.
   B. Санаа зөв бол заяа зөв.
   C. Эзэн хичээвэл заяа хичээнэ.
   D. Сайхан сэтгэлийн үзүүрт тос.
   E. Эрхэм баян эрдэм, ном.
7. Дараах хэсгүүдийн аль нь А хэсгийн санаануудын зөв дараалал вэ?
   A. гайхширал, гүйлгээ ухаан, баярласан сэтгэл, бодол эргэцүүлэл
   B. гүйлгээ ухаан, гайхширал, бодол эргэцүүлэл, баярласан сэтгэл
   C. гайхширал, бодол эргэцүүлэл, гүйлгээ ухаан, баярласан сэтгэл
   D. баярласан сэтгэл, бодол эргэцүүлэл, гүйлгээ ухаан, гайхширал
   E. бодол эргэцүүлэл, баярласан сэтгэл, гүйлгээ ухаан, гайхширал
8. "...монгол ах дүү нар байна **ядарсан хүнд** туслахгүй яах вэ?! " өгүүлбэрийн онцолсон хэсгийг аль үгээр солин найруулбал илүү тохиромжтой вэ?
   A. Цагаачин хүнд B. Эрдэмтэй хүнд
   C. Зүдэрсэн хүнд D. Учирсан хүнд
   E. Гутарсан хүнд
9. " Харцаганд баригдах гээд бутны ёроолд бүлтгэнэж байгаа болжмор шиг..." өгүүлбэрийн "харцага-болжмор" хоёрыг энэ эхэд ямар шинжээр нь эсрэгцүүлснийг олоорой.
   A. эрх, мэдэл B. ухаантай, мунхаг
   C. догшин, номхон D. эрэмгий, аймхай
   E.хурдан, удаан
10. Аль хэсэгт байгаа үйдлүүд Бадарчид хамаатай вэ?
   A. зарагдах, жолоогоо угзрах, бие сулрах, бүлтгэнэх
   B. шүд зуух, хэлэх, алга болох, гаанс тамхи гаргах
   C. бөөлжис хүрэх, шүд зуух, татганан чичрэх, мориноос буух
   D. татганан чичрэх, мэдэх, нохой долоох, хурааж авах
   E. гэдрэг болох, элс цацах, хавчин авах, хариу шаардах

ХОЁРДУГААР ХЭСЭГ [30 оноо]

2.1 Дараах эхийн хэсгийг уншаад зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай 1 үгийг олбол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо. [5 оноо]

Түүвэр өгүүлбэр

Анчид аа! Тахианы дэгдээхийгээ яасан бэ? Нөхөддөө байцай үзүүлье. Цахилгаан цахилахад цуурай давтана. Аргалийн сүрэг бэлчнэ. Цавьдар морио наадмаар уяя. Тэнгэр цэлмэсэн өдөр ургацаа хураахаар явлаа. Тэрхүү унасан дархи моддын үндсийг үерэлсэн горхи ууртайяа мөргөж, хөөс цахруулан шуугина. Үнээ тугаллаа. Хоёулаа явья.

Ташаарсан нь	**Залруулсан нь**

2.2 Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно.

[5 оноо]



2.3 Дараах сэдвээр эх зохион бичихдээ бүтэц, хэв шинж, сэдэв, агуулгын харьцаа болон найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглаарай. Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 150-180/ [20 оноо]

Монгол улсын нийслэл

….....

Хувилбар 16

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ [20 оноо]

Д.Намсрай

Жамухын өчил

Найман зууны тэртээх Жамухын шарил дээгүүр өнөөдөр талын болжмор жиргэж, эх нутгийн ноён салхинаа гудайсан хялганын толгой гашуудалтайяа бөхөлзөнө. Тэр газрын цээжийг аниртан чагнаваас монгол эрсийн нөхөрлөл, гунигт хагацлын тухай эмгэнэлт түүхийг өгүүлнэ. Олон аймгийн цуст тэмцэл, талын язгууртнуудын өрсөлдөөн Тэмүүжингийн ялалтаар төгсөж байсан тэр жил ... Хаан Жамух нөхдөдөө баригдаад Чингисийн өргөөнөө хүргэгдэж ирэв. Богд эзэндээ халдсан боол иргэдийг Чингис хаан өвс ногоо хүрэнттэл цаазалж Жамухыг суллаад өгүүлрүүн,

-Эв, ээ эвдрэлцэж, олонтаа будилсан ч амийг чинь хэлтрүүлье хаан анд минь. Эгнэгт нөхөрлөлөө бататгаж, эгүүрд хамт түшилцэн шүтэлцэн явтугай чи хэмээн өршөөлийг үзүүлэв. Гэвч нас сүүдэр ид дундаа, төрсөн биеийн хүч чадал төгөлдөржсөн хаан Жамух хариу өчсөн нь,

- Өндөр их хаан суудалдаа заларч, өрлөг есөн жанжны чинь тоо бүрэн бүтэн байхад би илүүдэх биз ээ анд минь. Чамд зай тавьж өгье. Үндэс мөчир бөхтэй Хорхоногийн саглагар мод шиг цэцэглэн ганхаж явсан юмсан. Үйлийн хонгор салхийг минь ямар тэнгэрийн зайран бөө хөөрөгдсөнийг бүү мэд. Атраг санаат эмийн үгэнд орж андгай тангаргаа няцсанаас хойш тавилан заяаны хувь зэрэгт улам бүр шахагдсаар хаан анд чиний өмнө хүрч ирлээ. Анд минь чи болгоогтун.

Тэнгэрт хос наран мандвал газар ган болж, гал шатна. Монголд хоёр хаан байвал дажин самуун тасрахгүй. Олон дайнд оролцон чадал хүчиндээ эрдэж явснаа санахад чиний илдийн дор явж би хэзээ ч чадахгүй. Нэгэнт дийлдэшгүй хүчийг олсон анд чи миний зарлигийн дор явахыг бас тэвчихгүй. Чи бол тэнгэрийн бөө, шадар баатруудад итгэгдсэн Чингис хаан. Би чамтай хамт өргөгдсөн хамаг Монголыг захирах Гүр хаан Жамух...

Гурван түмэн цэргийнхээ ялалтын уухайгаар Даланбалжуудад чамайг шахан сандаргаж явсан домогт тэр Жамух өнөөдөр хаан анд чиний төлөө орчлонгоос халихаар шийджээ. Чамд өнө үүрд итгэгдэх ийм замыг сонголоо. Дээд тэнгэрт нар нэгэн байг! Дэлүүн болдгийг гийгүүлэх сар бас нэгэн байг!

Өсөх насандаа Ононгийн мөсөн дээр шагалцан наадаж, өдгөө идэр цагтаа бүх Монголын хувь заяанд холбогдсон чи бид хоёр нэг нарны дор багтахгүй ээ. Учир иймд хоёр их хаан, хоёр их

баатар, хоёр монгол эрийн ёсоор энэ хэргийг нэг тийш болгоё. Хаан Жамухын суу алдрыг даяар монгол мэднэ. Энэ нэр сүрээрээ чиний хаан алдрыг өндөрт өргөөд би амиа тэвчье. Олны санаа бүү хоёрдог! Өлмий өвдөг дор чинь өөрийгөө би ивж өгье хаан анд минь!

Чиний нэр уудам агуу болог. Гүр хаан Жамух өөрөө чамд сөгдлөө гэдгийг дуулаад хамаг монгол дөрвөн зүг найман зовхист миний алдар урьд хожид үзэгдээгүйгээр дуурсах болно.

Нэгдсэн их гүрнийг нэг гарт хураан захируулахын тулд нэг нь нөгчиж, нөгөө нь хагацъя. Есөн хөлт цагаан туг, дайн тулааны хар сүлдэнд чинь хоёуланд нь сөгдөн гуйя хаан анд минь! Чи намайг өршөө! ... Өршөөхдөө цаазалж өршөө. Би чамтай нөхөрлөе! Нөхөрлөхдөө үхэж нөхөрлөе! Хүчирхэг гүрэн өнө мөнх оршихыг бэлгэдэж, хаан биеэрээ туг, сүлдийг чинь тахья! Эзэнт улсын төлөө миний өргөх өчүүхэн энэ хувь багадах учиргүйг тэнгэр мэднэ. Одоо чамайг дийлэх хүчтэн газар дээр үгүй ээ! Чиний баатар цэргүүдийн өмнө юу ч тэсэн тэвчиж чадахгүй.

Харь дайсан хатгалдахыг санаархвал монгол цэргийн тахир сэлмээр дэлхийн дайдыг нумлан хэмжигтүн! Дорно зүгт нар хаанаас манддагийг очиж үзэгтүн! Өрнө зүгт нар хаана шингэдгийг хүрч мэдэгтүн!

Бас эзэнт их гүрний хэргийг эмсийнхээ үгтэй хутгалдан зөвшигч надаар төгсгөл болог! Энэ мөчөөс хойш хаан Жамухын алдар, урван тэрслэгч хэнийг ч болов төрийн цээрлэл цааз үл тойрохын хууль болог! Өчих өчил минь гүйцлээ. Хаан анд минь, өшөө хорсол буцалсан хамгийн бэрх цагт ч Өэлүн эхийн сүү цусгүй байсныг санаж цус гаргалгүйгээр намайг алуулагтун!!! Үтэр түргэн тонилгогтун! Түүхийн хүрд саад тотгоргүй орчиг! гэвэй.

Чингис хаан хэсэг бодлогоширсноо тэргүүнээ өргөж шадар хүмүүсээ дуудан зарлиг болгов.

Хаан Чингисийн зарлиг биш гэдгийг мөнх тэнгэр соёрхтугай! Баатар Жамухын сүүлчийн өчил гэрээсийг биелүүлж цус гаргалгүй үхүүлэгтүн! Анддаа бэлэглэсэн алтан бүсийг минь бүслүүлж... аргамаг сайхан хүлгээр хаан Жамухыг тахиж, агсах зэвсэг, хуяг дуулгы нь асаан хүлэг баатрын ёсоор оршуулагтун! Эр хүн нөхөрлөхөд хад чулуу хайлж урсаж ч болдгийг, эр хүн эвдрэхэд хан тэнгэр хагарч цуурч болдгийг түмэн үе санатугай! Ийнхүү айлдан эргэхэд Чингис хааны ов тов буурал суусан, армаг тармаг сахал дээр нулимсан дусал гялтганав.

Хаадын зарлиг ёсоор болж, мөнх тэнгэрийн таалалд нийцэв.

Найман зууны тэртээх Жамухын шарил дээгүүр эх нутгийн ноён салхи гунигтайхан хэсүүчилж нөхрийн тухай үгсийг хялганын бутанд шивнэн эрин зуунд илгээнэ.

1. Дараах үгсийн утгыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

1. аниртах	a. Үлээлгэх, дэвэргэх
2. хэлтрүүлэх	b үхэх, нөгчих
3. халих	c өршөөх уучлах
4. орчих	d эргэх, өнгөрөх
5. хөөрөгдөх	e. сонсогдох, дуулдах

A. 1c2e3b4a5d B. 1e2b3a4d5c C. 1e2c3b4d5a
D. 1a2b3c4d5e E. 1b2e3a4c5d

2. “Эв, ээ эвдрэлцэж, олонтаа будилсан ч амийг чинь хэлтрүүлье хаан анд минь..” гэсэн өгүүлбэрийн онцолсон хэсгийг солин найруулбал аль хэсэг нь илүү тохиромжтой вэ?
   A. амийг чинь аваръя B. амийг чинь уучилъя
   C. амийг чинь нигүүлсье D. амийг чинь өршөөе
   E. амийг чинь үлдээе
3. “Гүр хаан Жамухын хүчирхэг, сайн явсан.” гэсэн санааг илэрхийлсэн хэсэг аль нь вэ?
   A. Олон дайнд оролцон чадал хүчиндээ эрдэж явснаа санахад чиний илдийн дор явж би хэзээ ч чадахгүй.
   B. Гэвч нас сүүдэр ид дундаа, төрсөн биеийн хүч чадал төгөлдөржсөн хаан Жамух хариу өчсөн нь,
   C. Би чамтай хамт өргөгдсөн хамаг Монголыг захирах Гүр хаан Жамух...
   D. Хаан Жамухын суу алдрыг даяар монгол мэднэ.
   E. Үндэс мөчир бөхтэй Хорхоногийн саглагар мод шиг цэцэглэн ганхаж явсан юмсан.
4. Жамухыг өрөвдөн харамсаж буй хандлагыг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
   A. Чингис хаан хэсэг бодлогоширсноо тэргүүнээ өргөж шадар хүмүүсээ дуудан зарлиг болгов.
   B. Хаан Чингисийн зарлиг биш гэдгийг мөнх тэнгэр соёрхтугай!
   C. Анддаа бэлэглэсэн алтан бүсийг минь бүслүүлж... аргамаг сайхан хүлгээр хаан Жамухыг тахиж, агсах зэвсэг, хуяг дуулгы нь асаан хүлэг баатрын ёсоор оршуулагтун!

D. Ийнхүү айлдан эргэхэд Чингис хааны ов тов буурал суусан, армаг тармаг сахал дээр нулимсан дусал гялтганав.
E. Эр хүн нөхөрлөхөд хад чулуу хайлж урсаж ч болдгийг, эр хүн эвдрэхэд хан тэнгэр хагарч цуурч болдгийг түмэн үе санатугай!

5. "Үйлийн хонгор салхийг минь ямар тэнгэрийн зайран бөө хөөрөгдсөнийг бүү мэд. Атгаг санаат эмийн үгэнд орж андгай тангаргаа няцсанаас хойш тавилан заяаны хувь зэрэгт улам бүр шахагдсаар хаан анд чиний өмнө хүрч ирлээ." гэсэн өгүүлбэрүүдээд илэрхийлсэн санаанд тохирох хэлцийг олоорой.
A. Эвийг эртнээс, эрдмийг залуугаас
B. Эвлэвэл бүтнэ, Ховловол гутна.
C. Сайнтай нөхөрлөвөл сарны гэрэл, муутай нөхөрлөвл могойн хорлол
D. Хэлсэн үгэндээ эзэн, идсэн хоолондоо сав болох
E. Муу үг модон улаатай.

6. Жамух хийсэн буруу үйлдлээ ойлгон ухаарсныг хамгийн оновчтой илэрхийлсэн өгүүлбэрийг олно уу?
A. Монголд хоёр хаан байвал дажин самуун тасрахгүй.
B. Хоёр их хаан, хоёр их баатар, хоёр монгол эрийн ёсоор энэ хэргийг нэг тийш болгоё.
C. Энэ мөчөөс хойш хаан Жамухын алдар, урван тэрслэгч хэнийг ч болов төрийн цээрлэл цааз үл тойрохын хууль болог!
D. Өндөр их хаан суудалдаа заларч, өрлөг есөн жанжны чинь тоо бүрэн бүтэн байхад би илүүдэх биз ээ анд минь.
E. Би чамтай нөхөрлөе! Нөхөрлөхдөө үхэж нөхөрлөе!

7. "Найман зууны тэртээх Жамухын шарил дээгүүр эх нутгийн ноён салхи гунигтайхан хэсүүчилж нөхрийн тухай үгсийг хялганын бутанд шивнэн эрин зуунд илгээнэ." гэсэн өгүүлбэрийн дүрслэх ур маягийг олоорой.
A. хүншүүлэл B. төлөөлөл C. зүйрлэл
D. тойруулал E. Ёгтлол

8. Өгүүллэгээр ямар санааг дэвшүүлэн тавьсан бэ?
A. Монгол хаадын тэмцлийн тухай
B. Жамухын хожимдсон ухаарлын тухай
C. Өөрийн үзэл бодолдоо тууштай байх тухай
D. Төр улс өнө мөнх орших ёстой тухай
E. Хүчтэний дэргэд хүчгүй нь мөхөс байдаг тухай

9. Өгүүллэгт ямар сэдэв, дэвшүүлсэн асуудал хөндсөнийг олно уу?
A. Эрх мэдлийн төлөө Монголын олон овог, аймгуудын тэмцлийн талаарх
B. Ертөнцийн жам ёсны тухай
C. Төр улсын эв нэгдлийн тухай
D. Монгол эр хүний ухаарал, холч ухааны тухай
E. Найз нөхдийн үнэнч нөхөрлөлийн тухай

10. Дараах өгүүлбэрүүдийг уншаад үйл явдлын зөв дараалалд оруулаарай.
1. Хүчирхэг гүрэн өнө мөнх оршихыг бэлгэдэж, хаан биеэрээ туг, сүлдийг чинь тахья!
2. Чингис хаан хэсэг бодлогоширсноо тэргүүнээ өргөж шадар хүмүүсээ дуудан зарлиг болгов.
3. Дээд тэнгэрт нар нэгэн байг! Дэлүүн болдгийг гийгүүлэх сар бас нэгэн байг!
4. Богд эзэндээ халдсан боол иргэдийг Чингис хаан өвс ногоо хүрэнттэл цаазалж ...
5. ... Чингис хааны ов тов буурал суусан, армаг тармаг сахал дээр нулимсан дусал гялтганав.
A. 1, 5, 2, 3, 4 B. 4, 3, 1, 2, 5 C. 1, 2, 3, 4, 5
D. 4, 3, 1, 5, 2 E. 3, 1, 2, 4, 5

ХОЁРДУГААР ХЭСЭГ [30 оноо]

2.1 Дараах түүвэр өгүүлбэрүүдийг уншаарай. Зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод засаж бичээрэй. Алдаатай 1 үгийг олбол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо. [5 оноо]

Дэвтрийг хүүхдийн сурлага, хүмүүжлийн толь гэдэг. Цэвэрхэн, нямбай бичсэн сурагчийн дэвтэр эзнээ сурлага, хүмүүжлээр сайн гэдгийг батлана.
Иргэн бүр төрөлх эх нутаг, хүрээлэн буй байгаль орчиноо унаган төрхөөр нь байлган хайрлаж хамгаалья.

Өнөө хэрэглэж буй цагыг үүсэн бий болхын өмнө хүмүүс амьдрал ахуйдаа элсэн цаг ашигладаг байжээ.

Ташаарсан нь	Залруулсан нь

2.2 Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. [5 оноо]



2.3 "*Өөрийн бодол өөртөө зөв*" сэдвээр эх зохион бичээрэй. (Бичихдээ бүтэц, хэв шинж, сэдэв, агуулгын харьцаа болон найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглаарай.) Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 150-180/ [20 оноо]

…….....

Хувилбар 17

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ [20 оноо]

Монгол гутал

Би эртний гуулин тоногтой авдраасаа хэдэн давхар даавуунд нандигнан баадагнасан хуучин монгол гутлаа гаргаж, хэдэн хором эргүүлж тойруулж харлаа. Өвөг эцгийн үлдээсэн энэ гутал гөлмөнд удаан үрэгдсэнээс түрий нь халцарч, зуузай нь хазайж өсгий, ул нь элэгдсэнээс үзэхүл он цагийн урт, хүнд бэрх аян замыг туулжээ гэдэг нь юм үзэж, нүд тайлсан хүнд андашгүй танигдана. Элдэв гоёл чимэггүй бүдүүн бааздуухан боловч аян жин, хар бор ажлын ая даахаар, хэдэн жилийн битгий хэл хэдэн зууныг ч өлхөн элээх гутал санж. Харваас түүнийг өнөөгийн хүн өмсөж хэрэглэхийг тэгтлээ сонирхохгүй, бас тийм хэрэгцээ ч гарахгүй. Харин музей, үзмэрт түүхэн үйл явдлын гэрч болгож тавибал илүү ач холбогдолтой байх биз.

Өвгийнхөө гутлыг харж суухад морин дэл дээр дөрөө жийн өндийж, махир сэлэм эргүүлсэн монгол цэргүүдийн уухайн дуу, туурайн тачигнаан, ирт сэлмийн харшилдаан, газар тэнгэр нийлтэл тоос босгон тулалдах дайчдын эрэмгий дүр төрх зурсхийн орж ирнэ. Өвөг эцэг минь зуугаад жилийн тэртээ энэ гуталтайгаа Манлайбаатар Дамдинсүрэнгийн цэрэгт элсэж, нэгдсэн Монгол Улсыг байгуулах их аян дайнд мордон, Цагаан хэрэм хүрээд буцсан гэдэг. Өндөр өвөг минь манжийн хааны төмөр сүргийн ихэнхийг бичин жилийн зуданд хиаруулж, ялд унан, банздуулсныхаа дараа шархаа даалгүй шоронд амиа алдсан аж. Дараа нь миний өвөө хөл хүнд ээжтэйгээ хамт хошуу дамжин зарагдаж, гашуун зовлонгийн туйлд сөхрөхдөө ээж нь хоёр яс салж чадалгүй

төрөхийн хүндрэлээр өөд болсон гэдэг юм. Өвөө минь арван гурав дөрөвхөн настайдаа хүний нутагт үнсэнд хаягдсан шалз шиг хоцорч, амь зуухын эрхээр тарвага, зурамны амь тасалдаг болсон гэж ярьж билээ.

Арван долоохон настайдаа зуун тарваганы арьсаар худалдаж авсан энэ гутлаа өмсөөд, цахиур буугаа үүрэн манж, хятадаас нутгаа чөлөөлөх цэрэгт морджээ. Өвөө минь "Цагаан хэрэм хүрдгийн даваан дээр гайтай гурван улсын хэлэлцээр болж, бид ялалтын аман дээрээс буцсан юм. Тэгээгүй бол өдийд хөх толбот монгол угсаатнууд нэгдчихсэн хүчирхэг Монгол Улс дэлхийн цээжин дээр ташаа тулан ханхалзаж байхгүй юу" гэж харамсал, бахархал хослуулан ярьж суусан нь дөнгөж өчигдөр юм шиг санаанд тодхон. Аав энэ гутлыг ямар ч шүтээнээсээ илүү нандигнан хадгалж, хэнд ч үл үзүүлнэ. Өвөө минь их хэлмэгдүүлэлтийн үед ногоон малгайтнууд "феодалын үлдэгдэл гутал" гээд шатаачих вий гэхээс айж, хадны завсар хүртэл нууж байсан гэдэг. Энэ бол манай удмын чанд нууц, ганц нандин дурсгал, ариун бахархал юм.

Өвөөгийн минь ар дагзанд тэнгэрийн заадас шиг урт цагаан сорви тархийг нь хоёр хуваан тодоос тод гялтайн харагддаг сан. Тэр сорви өвөөгийн минь орь залуу насандаа хүнд бэрх, баатарлаг тулаанд орж, сэлэм, жадны ирэн дунд амь дэнсэн алалцаж явсныг батлахаас гадна дайчин эрийн зориг самбааг нь ямар ч үгнээс илүү давхар гэрчилнэ.

Хятад, монгол хоёр хонь чоно шиг байсан цаг алга урвуулахын төдийд л арилж, эгээ л өвөр түрийдээ орохын толгой дээр ирсэн цаг. Ганзагын наймаа ид цэцэглэж, Эрээн, Хөх хот, Бээжин Улаанбаатарын хооронд монгол, хятад хүмүүсийн хөл тасрахаа больжээ. Би наймаа арилжаанд дөргүй ч, хэдэн хониныхоо ноос, арьс, махыг замын панзчингуудад хэр тааруу үнээр өгч, эгэл амьдралаа болгодог. Хэдэн бор юм илүүчилснийх толгойтой болгон мөрөө гаргахыг хүсдэг, бас өндөр өвгийн ханыг нь тулаад буцсан урт Цагаан хэрэмийг үзмээр санагдаад болдоггүй. Ингээд л гутлаа ганзагалан дотор газрыг зорьсон билээ. Аяны замд "гахай" чирч хамт явсан ганзагын наймаачид "Наадах гутал чинь дотор газар үнэ хүрэхгүй ээ. Харин эртний эдлэл цуглуулагчид худалдвал овоо юм чангаана. Гэхдээ Цагаан хэрэм дээр ирсэн америк, англичуудад долларaар өгч чадвал харин ч өвөр чинь түнтийгээд явчихна" гэхчлэн наймаачин хүний ухаанаар элдэвлэнэ. "Ямар зорилготой өвгийн гутлыг авч яваагаа та нарт битгий хэл эхнэртээ ч хэлээгүй, миний холын бодлыг та нар яаж ч ойлгох билээ дээ" гэсэн шүү юм бодож явлаа.

Хүсэл мөрөөдөл минь биелж, Цагаан хэрэм дээр ч гарлаа. Хэрэмний дээд хашлагын доод ёроолоор манай нутаг руу харсан талд нь гурав алхаад л нум сумны зурагтай нүхнүүд байна. Түүгээр лав манай өвөг дээдсийг намнаж байсан бололтой. Цагаан хэрэм дээр гарчхаад нутгийнхаа зүг харахад салхи нь хүртэл дотно сэвэлзэх нь цаанаа л элгэнд ойрхон. Би гэдэг хүн аагим халуун наранд цоргиулж, хар хөлсөө цувуулан, хамаг бие хувцастайгаа наалдан бүтэж үхэх гэж байсан ч халхгар цэмбэн дээлтэй, мөнгөн тоногтой суран бүстэй, хэт хутга бүсэндээ хавчуулан аахилж явлаа. Хамгийн гол нь өвөг эцгийн гутлыг өмсөөд, Цагаан хэрэмийн хашлаган дээр өрөөсөн хөлөөрөө гишгэн ташаагаа тулаад ханхалзаж буйгаар зургаа татуулах л чухам зорилго минь юм.

Дөрвөн зүг найман зовхисоос ирсэн зүсэн зүйлийн үндэстэн, ястан, хар, шар, цагаан арьстнууд талын монгол дайчин баатруудаас хятадууд хэрхэн сүнсээ зайлтал айж байсныг гэрчлэх миний өвөөгийн гутлыг шохоорхон сонирхож зургийг нь аппаратаа час час хийлгэн, тал талаас гэрэл анивчуулан авч байв.

"Хн, мөн тоогүй, Өвөг эцгийн махир сэлэм байсан болоосой. Тэрийг ташаандаа зүүчихсэн бол ч мөн догь оо" хэмээн бодож байтал шар арьстан нэг эрхэм "Та хаанаас ирсэн бэ. Таны энэ гутал хэддүгээр зууных вэ?" гэж орчуулагчаараа дамжуулан асуухад би, "Би дэлхийн дайдад нэрээ ч, мөрөө ч мөнхөлсөн Чингис хааны удамт монгол хүн. Миний өвөг эцэг зуугаад жилийн өмнө энэ гутлаа өмсчхөөд шоргоолж шиг язганасан хятад цэргүүдийг тариа хадах шиг хяргаж, морин туурайгаар гишгэж, энэ урт Цагаан хэрэмийг давуулж байсан гэдэг юм. Одоо би өвөг эцгийнхээ мөрөөдлийг биелүүлж, урт цагаан хэрмэн дээр гишгэж байна. Би энд татуулсан зургаа томоор угаалгаад гоё жаазанд хийж, хоймортоо бурханчлан тахина" хэмээн омог бардам хэллээ. Миний "Монгол" гэх омогшил өөрийн эрхгүй төрж, цөс хөөрөөд ирлээ. "Морин дэл дээр дарцаглаж Монголоо гэж чээжээ дэлдсэн Би монгол эр хүн" гээд Цагаан хэрэмийг доргитол дуулмаар омогшиж байна.

-За миний хүү, хэзээ нэгэн цагт тэр хүртэл тэмцэж байлдаж явсан гутлын минь мөрийг Цагаан хэрэм дээр чи л гаргаж өвөг дээдсийнхээ өнийн захиасыг биелүүлэх болтугай хэмээн үлдээсэн гутал нь юм чинь. Өвгийн эрхэм захиасыг ийнхүү гүйцэлдүүлсэндээ насны хүсэл биелсэн мэт сэтгэл хангалуун, чээж бардам алхаж явлаа.

Хэдхэн хоноод бид нутгийн зүг жолоо заллаа. Бусад маань олз омогтой, надаас бусад нь арав арван "гахай" чирч, галт тэрэгний өрөө, суудал, ор, завсар заалхай, бүр нарийхан давчуу

хонгилд хүртэл зүү орох зайгүй болтол бараа чихлээ. Тэр барааны ихэнх нь хятад шаахай, гутал гэдгийг би түвэггүй мэднэ.

“Гаалийн шалгалт” гэх чимээнээр зүс таних нэг бүсгүй “Ах аа, та энэ арван шаахайг нуугаад өгөөч. Миний бараа хэмжээнээсээ хэтэрчхээд хураалгачих гээд байна” гэхэд би “Би хаанаа нуух юм, ямар амандаа үмхэлтэй биш” гэтэл “Таны монгол гутлын түрийнд багтана шүү дээ” гэлээ. “Очиж очиж өвгийнхөө гуталд хятад шаахай чихэж гутамшиглах дээрээ тулсан адгийн панзчин гэж намайг санажээ” хэмээн бодогдоод, миний ар нуруугаар зарганах шиг болж, “Битгий галзуур чи” хэмээн уурандаа багтарч ядан хэллээ. Хүүхэн айх гайхах зэрэгцэн дүрлийтэл харснаа эргэж одлоо. Миний амьсгаа түргэсэж “үгүй ер” гээд эргэн “Өнөө гутал минь байдаг л байгаа даа” хэмээн сэжиглэж, ачаагаа үзлээ.

Гэтэл юу үзсэн гэж санана. Хэн нэг нь аль хэдийн гутлыг минь түнтийтэл хятад шаахай чихчихсэн байлаа.

-Ээ хөх тэнгэр минь. “Марал илжигний туурай, маалинган шаахайн мөр Халхын нутагт бүү гарга…!” хэмээсэн дээдсийн зарлиг яалаа гэх үг тархин дундуур минь галтай ташуур шиг тас буух нь тэр ээ. Миний толгой дүйрч, чих шуугин, галт тэрэгний давчуухан тасалгаанд өөрийн эрхгүй суун туслаа.

(Ц.Түмэнбаяр)

1. Дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

1. омогших	a) вааданд боох ороох
2. элдэвлэх	b) үлэмж ихээр сүйрүүлэх, үхүүлэх
3. баадагнах	c) юмны халуун илч, уур юманд хүрч халаах
4. цоргиулах	d) зүйл бүрийн арга сэдэх
5. хиаруулах	e) бардам дээрэнгүй болох

A. 1a2c3d4e5b B. 1a2b3e4c5d C. 1e2d3a4c5b
D. 1a2d3c4a5b E. 1d2c3a4e5b

2. *“Өвөг эцгийн үлдээсэн энэ гутал **гөлмөнд** удаан үрэгдсэнээс түрий нь халцарч, зуузай нь хазайж өсгий, ул нь элэгджээ.”* - өгүүлбэрийн онцолсон үгийн утгыг олоорой.
   A. Монгол эмээлд байдаг тусгай бэлтгэгдсэн арьс, шир, хивс даавуу зэргээр хийдэг олом жирмийн халхавч жийрэг
   B. Эмээл, янгирцаг мэтийн дор жийрэглэн тохох юм
   C. Тэмээний атавч, эмээл, хивсэн тохош
   D. Морины гэдсэн доогуур оруулан авчирч горхинд жирмийг оруулан татаж тогтоох голдуу хялгас томж хийх оосор
   E. Эмээлийн хавтасны өмнө хойдод унжуулсан сур
3. “Тэр монгол гутал он цагийн урт, хүнд бэрх аян замыг туулсан” гэсэн санааг батлах баримт аль нь вэ?
   A. Музей, үзмэрт түүхэн үйл явдлын гэрч болгож тавибал илүү ач холбогдолтой байх биз.
   B. Өвөг эцгийн үлдээсэн энэ гутал гөлмөнд удаан үрэгдсэнээс түрий нь халцарч, зуузай нь хазайж өсгий, ул нь элэгджээ.
   C. Элдэв гоёл чимэггүй бүдүүн бааздуухан боловч аян жин, хар бор ажлын ая даахаар, хэдэн жилийн битгий хэл хэдэн зууныг ч өлхөн элээх гутал санж.
   D. Энэ гутал бол манай удмын чанд нууц, ганц нандин дурсгал, ариун бахархал юм.
   E. Аав энэ гутлыг ямар ч шүтээнээсээ илүү нандигнан хадгалж, хэнд ч үл үзүүлнэ.
4. Зохиолын баатар ямар зорилгоор Цагаан хэрэм рүү явсан бэ?
   A. Өвгийнхөө үлдээсэн монгол гутлыг өндөр үнэ хүргэн зарах гэж
   B. Цагаан хэрэм үзэх гэж
   C. Өвөг дээдсийнхээ өнийн захиасыг биелүүлэх гэж
   D. Цуглуулсан хэдэн төгрөгөө өсгөж, ганзагын наймаа хийх гэж
   E. Цагаан хэрэм дээр гадаадын олон хүний өмнө үндэсний хувцсаараа гайхуулах гэж
5. Эхэд дэвшүүлсэн асуудал буюу сэдвийг олоорой.

A. Монгол гутлын тухай
B. Эх орны тусгаар тогтнолын тухай
C. Монгол өв соёлын тухай
D. Эр хүний омогшлын тухай
E. Монгол бахархлын тухай

6. Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
   A. Энэ бол манай удмын чанд нууц, ганц нандин дурсгал, ариун бахархал юм.
   B. “Морин дэл дээр дарцаглаж Монголоо гэж чээжээ дэлдсэн Би монгол эр хүн” гээд Цагаан хэрэмийг доргитол дуулмаар омогшиж байна.
   C. Аяны замд “гахай” чирч хамт явсан ганзагын наймаачид “Наадах гутал чинь дотор газар үнэ хүрэхгүй ээ. Харин эртний эдлэл цуглуулагчид худалдвал овоо юм чангаана.
   D. Ээ хөх тэнгэр минь. “Марал илжигний туурай, маалинган шаахайн мөр Халхын нутагт бүү гарга…!” хэмээсэн дээдсийн зарлиг яалаа гэх үг тархин дундуур минь галтай ташуур шиг тас буух нь тэр ээ.
   E. Би дэлхийн дайдад нэрээ ч, мөрөө ч мөнхөлсөн Чингис хааны удамт монгол хүн.

7. *“Өвгийн эрхэм захиасыг ийнхүү гүйцэлдүүлсэндээ насны хүсэл биелсэн мэт сэтгэл хангалуун, цээж бардам алхаж явлаа.”* гэсэн өгүүлбэрийн дүрслэх ур маягийг олоорой.
   A. Багасгал B. Амьдчилал C. Төлөөлөл
   D. Адилтгал E. Ёгтлол

8. Өвөөгийн яриаг дурсан санасан байдлаар илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
   A. Өвөө минь арван гурав дөрөвхөн настайдаа хүний нутагт үнсэнд хаягдсан шалз шиг хоцорч, амь зуухын эрхээр тарвага, зурамны амь тасалдаг болсон гэж ярьж билээ.
   B. Өвөөгийн минь ар дагзанд тэнгэрийн заадас шиг урт цагаан сорви тархийг нь хоёр хуваан тодоос тод гялтайн харагддаг сан.
   C. За миний хүү, хэзээ нэгэн цагт тэр хүртэл тэмцэж байлдаж явсан гутлын минь мөрийг Цагаан хэрэм дээр чи л гаргаж өвөг дээдсийнхээ өнийн захиасыг биелүүлэх болтугай хэмээн үлдээсэн гутал нь юм чинь.
   D. Өвөө минь их хэлмэгдүүлэлтийн үед ногоон малгайтнууд “феодалын үлдэгдэл гутал” гээд шатаачих вий гэхээс айж, хадны завсар хүртэл нууж байсан гэдэг.
   E. Өвөг эцэг минь зуугаад жилийн тэртээ энэ гуталтайгаа Манлайбаатар Дамдинсүрэнгийн цэрэгт элсэж, нэгдсэн Монгол Улсыг байгуулах их аян дайнд мордон, Цагаан хэрэм хүрээд буцсан гэдэг.

9. Дараах өгүүлбэрийг цаг хугацаагаар нь зөв дараалуулсан хэсгийн дугаарыг олоорой.
   1. Өвөг эцэг минь зуугаад жилийн тэртээ энэ гуталтайгаа Манлайбаатар Дамдинсүрэнгийн цэрэгт элсэж, нэгдсэн Монгол Улсыг байгуулах их аян дайнд мордон, Цагаан хэрэм хүрээд буцсан гэдэг.
   2. Өндөр өвөг минь Манжийн хааны төмөр сүргийн ихэнхийг бичин жилийн зуданд хиаруулж, ялд унан, банздуулсныхаа дараа шархаа даалгүй шоронд амиа алдсан аж.
   3. Аав энэ гутлыг ямар ч шүтээнээсээ илүү нандигнан хадгалж, хэнд ч үл үзүүлнэ.
   4. Өвөө минь арван долоохон настайдаа зуун тарваганы арьсаар худалдаж авсан энэ гутлаа өмсөөд, цахиур буугаа үүрэн манж, хятадаас нутгаа чөлөөлөх цэрэгт морджээ.
   5. Одоо би өвөг эцгийнхээ мөрөөдлийг биелүүлж, урт цагаан хэрмэн дээр гишгэж байна.
   A. 1, 2, 4, 3, 5 B. 2, 3, 1, 3, 5 C. 5, 3, 4, 2, 1
   D. 2, 1, 4, 3, 5 E. 2, 1, 3, 4, 5

10. *“Өвөө минь арван гурав дөрөвхөн настайдаа хүний нутагт үнсэнд хаягдсан шалз шиг хоцорч,* ***амь зуух****ын эрхээр тарвага, зурамны амь тасалдаг болсон гэж ярьж билээ.”* гэсэн өгүүлбэрийн онцолсон үгтэй утгаараа тохирох үгийг олоорой.
   A. цаг нөгцөөх B. хувиа борлуулах C. ходоод хонхолзох
   D. өдөр хоног өнгөрүүлэх E. амь зогоох

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1 Дараах эхээс уншаад зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай 1 үгийг олвол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо [5 оноо]

Хүн итгэсэн нөхөртөө л бэрхшээлээ тоочдог юм. Найз нөхөдийнхөө зовлон тоочхыг тэсвэртээгээр сонс. Тэгвэл түүний зовлон нимгэрч, сэтгэл нь уужирч байгааг царайны өнгө, дууны аялгаас нь чи аяндаа мэдэрнэ. Ингэснээр чи нөхрийнхөө давчуурсан сэтгэлийг тэлж өгнө. Найз нөхөдтэйгөө чин сэтгэлээсээ харицаж бай. Үнэнээрээ байх гоё. Худлаа инээснээс үнэнээсээ ууралсан нь хавьгүй дээр.

Ташаарсан нь	Залруулсан нь

2.2. Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. [5 оноо]



2.3 **“Зорилгогүй хүн сэлүүргүй завьтай адил”** сэдвээр эх зохион бичээрэй. Бичихдээ бүтэц, хэв шинж, сэдэв, агуулгын харьцаа болон найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглаарай. Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. (Үгийн тоо 150-180)

Хувилбар 18

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ [20 оноо]

Саарал даага

Шувтаргын дөрвөн бөх цол гуншингаа дуудуулсаар сүртэйеэ дэвэн гарахад наадмын асар тойрон гийнгоолж байсан хурдан морьтой хүүхдүүд давхилдан өнгөрч байлаа. Тэдний дунд би нэгдлийнхээ хөөрхөн саарал даагыг аааараа хөтлүүлэн явлаа. Ингэж хөтлүүлж явах нь надад эвгүй санагдавч хамаг амьтан ингэж байгаа юм чинь одоо яая гэх вэ дээ.

Миний саарал даага манай нэгдлийн уяанд хамгийн бага нь, би өөрөө морь унаж яваа хүүхдүүдийн хамгийн жижиг нь. Тийм учраас хамаг амьтан бид хоёрыг өхөөрдөж байлаа. Миний унаж яваа саарал даагыг нэгдлийн хурдан хээрийн унага гэж мэдэх хэдэн адуучин мал бригадын дарга Гүнрэв гуай зэрэг хэдхэн хүнээс бусад нь сайн давхина гэж зүүдэлсэнгүй бололтой. Хурдан морь сайн таньдаг гэгдэх хэдэн хашир өвгөчүүл ч эхээ хөхөж байсан хэдэн бүдүүн даагыг л сайн давхина гэж амлацгааж байлаа. Тэд саарал зүстэй байхлаар нь хурдан хээрийн унага гэж мэдсэнгүй л дээ. Энэ хээр азарга манайд байхдаа олон жил дараалан түрүүлсэн юм. Нэгдэлд

нийгэмчилснээс хойш ч жил бүр түрүүлж байгаа юм. Алс холоос морины хорхойтой хүмүүс ирж өндөр үнэ өгнө гэж хонуут өнжүүтээр шалаад аавыг залхаадагсан. Ойр хавийн морь уядаг хүмүүс аавд атаархаж тийм хурдантай болохын тулд хааяа манай адуунд ганц хоёр гүү авчраад тавьчихсан байдаг сан. Аавыг нэгдэлд хурдан хээр азаргаа нийгэмчлэхэд их л олон янзын яриа гарч билээ. Дорж хунз гэгч манайд согтуу ирээд аавыг элдвээр хэлж,

- Чи надад азаргаа өгсөнгүй. Очиж очиж нэгдэлд зүгээр өгчихнө гэнэ ээ! Заяагүй муу новш! Би чамд гаансан дээрээ дөрвөн бод нэмж өгье гэж мөн их гуйсан даа. Чиний муу хээр үрээг аваагүйгээр Дорж хунз хохироо ч уу, үгүй ч үү? Тэр сүйд болоод байгаа нэгдэл чинь чамайг яаж гялайлгахыг харахсан гээд "Түй" гэж нулимаад жороо хараа халбилзуулж хоёр тал дээр ээлжлэн гарсаар хойноосоо хөөсөн нохдыг хайр гамгүй зодог одсоныг л лав тод санаж байна.

Аав минь одоо нэгдлийн тэргүүний малчин, энгэр дээр нь алтан гадас одон гялалзаж байгаа. Аавын минь одонг жижиг хүүхдүүд шохоорхон харахад би өөрөө одонтой юм шиг бахархаж явдаг. Нэгдэл, хөдөлмөр хоёр аавыг минь яаж гялайлгасныг Дорж хунз одоо ч харж явна. Тэр бас морь уяжээ. Түүний хурдны шинж бүрдсэн өндөр хээр даага өнөөдөр хүн бүхний хараг булааж байна. Түүнийг түрүүлнэ гэж ихэнх хүмүүс ярина. Дорж хунз өөрөө элбэг халхгар торгон дээл өмсөж, бүсэндээ зандан хусуур хавчуулжээ. Дааганд нь тийнхүү амьтны ам сайн байгаад Дорж хунз их л бардам явна. Дороос нухаж зовоомоор мөнгөн хэрэглэлтэй эмээл дээрээ хазгай сууж, тэнзэн ташуур хөндөлдүүлэн барьжээ. Үнэтэй торгон өмд, түрийнээс цухуйх цав цагаан соруултай гаансаа үзүүлэхийн тулд хормойгоо шуужээ.

Морь эргэх газар нэлээд зайтай, нар орой болж байгаа учир ширүүхэн явцгаалаа. Ергөх нь морины гэдэс зайлчихна гэж хашир хүмүүс голдуу цогиулах ажээ. Удалгүй морь эргэх тэмдэгт газар ирцгээхэд аав намайг хөтөлж нэлээд түрүүгээр гаргаад тавилаа. Морь тавьсан улсуудын морьд цөм л дааганаас хоцрохоргүй байсан боловч журмыг сахиж томчууд морьдынхоо амыг татав. Дорж хунз л ганцаараа хоцорсонгүй тэр даагатайгаа зэрэгцэн давхиж,

- Амыг нь сайн татаад ширвээд бай. Жаахан явуул... Жолоогий нь сулруулахгүй юу, муу мангуу ! гэх зэргээр дуу хадуулж явлаа.

Газрын дунд орж ирэхэд дааганууд цуварч эхэллээ. Би Дорж хунзын хээр дааганы дараах хоёр дааганы ард л яваад байлаа. Миний өмнөх хоёр даага бие биенийхээ өмнө гарах гэж тэмцэлдсээр байгаад хүч нь суларчихсан тул аяндаа саарлаас минь хоцрох нь тэр.

Би хэдэнтээ хүчтэй ширвээд хашхираад орхисон чинь хээр даагатай зэрэгцээд очлоо. Дорж хунз муухай муухай хялалзаж өөрийн хүүхдэд юм заасаар байлаа. Тэр хэдэн удаа хүүхдэдээ "Гарга!" гэж хашгирсан боловч миний саарал салсангүй, барианы газар саахалт хэртэй болж ирэхэд нэг гуядаад авлаа.

Буруу талаар нь хариугүй хошуу өлгөөд ирлээ. Түрүүлэхэд нь баярласан гэж хязгаар алга. Гэтэл дааганы минь хоншоор дундуур ташуурын сур тас буув.

Саарал хажуу тийшээ огло харайлаа. Би арай л ойчсонгүй, тэвдэж эмээлийнхээ хажуу дээр гарсан боловч азаар тогтлоо. Гэвч ташуураа алдчихжээ. Энэ хооронд Дорж хунзын хээр даага нэлээд зайлчихсан байв. Өнгөрчээ...

Давирч гуугалсаар ард нь нэлээд ойрхон очлоо. "Гэвч хээр даага хэдхэн харайгаад барианд орно... за байз... яая даа... ташууртай ч болоосой".

Гэнэт барианы зүгээс хангинатал янцгаах сонсогдов. Миний саарлын нүд нь сэргэж, янцаглан хүчээ нэмлээ. Яах ийхийн завдалгүй саарал минь жирэлзэн хурдалж хээр даага, улаан дарцаг ээлжлэн өнгөрөв. Түрүүлчихлээ. Морь барих хүмүүс хүртэл барьж чадалгүй алдчихжээ. Саарал дааганы эх янцгаасан юмсанж. Тэр янцгаалт ямар ч ташуураас илүү хэрэг боллоо. Эхийн нь янцгаалт саарал дааганд юу юунаас илүү хүчийг өгчээ. Юутай сайхан янцгаалт, энэ янцгаалтыг би зөвхөн чихээрээ ч биш бүх эрхтнээрээ хүлээн мэдэрсэн биз. Энэ янцгаалт одоо ч гэсэн миний чихэнд хангинан сонсогдсоор билээ.

Хөлстэй тохмоо шилгээн эхээ хөхөж байсан хөөрхөн саарал даагыг минь хамаг амьтан бүчин ирлээ. Тэдний магтах, өхөөрдөх хоёрыг өгүүлээд баршгүй ээ. Харин хээр дааганыхаа хөлсийг хусаж зогсоо Дорж хунз дээр хэн ч очсонгүй. Гэвч Дорж хунз өөрөө наашаа ирэх байлгүй дээ. (Ж.Лхагва)

1. Дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

1. бүчих	a) унасан малыг хөл буюу дөрөөгөөр дэлдэх
2. нийгэмчлэх	b) юмаар сажиж цохих, цавчих
3. ширвэх	c) нийгмийн болгох, нийгэмчлэн татварлах
4. гуядах	d) хурж шавах

5. давирах	е) унасан морь мал зэргийг ташуур мэтийн юмаар гуяны тус газар занчих, дэлдэх

A. 1d2e3a4c5b *B. 1d2c3b4e5a* *C. 1d2e3b4a5c*
D. 1b2c3a4e5d *E. 1d2c3a4e5b*

2. "**Ергөх** нь морины гэдэс зайлчихна гэж хашир хүмүүс голдуу цогиулах ажээ"-өгүүлбэрийн онцолсон үгийн утгыг олоорой.
A. Морины шогших хатирах хоёрын дунд ширүүвтэрхэн явах явдал
B. Морины довтлон явах явдал
C. Морины хатираар явах явдал
D. Морь малын хатир сэглэгт хүрэхгүй шогшоо явдлаар явах
E. Морь малын өмнөд хоёр хөл зэргээр, хойд хоёр хөл зэргээр ээлжлэн харайлан явах

3. *"Эхийнх нь янцгаалт саарал даааганд юу юунаас илүү хүчийг өгсөн"* гэсэн санааг батлах баримт аль нь вэ?
A. Энэ янцгаалтыг би зөвхөн чихээрээ биш бүх эрхтнээрээ ч хүлээн мэдэрсэн биз.
B. Хөлстэй тохмоо шилгээн эхээ хөхөж байсан хөөрхөн саарал даагыг минь хамаг амьтан бүчин ирлээ.
C. Гэнэт барианы зүгээс хангинатал янцгаах дуу сонсогдов. Миний саарлын нүд нь сэргэж, янцаглан хүчээ нэмлээ.
D. Тэр янцгаалт ямар ч ташуураас илүү хэрэг боллоо.
E. Буруу талаар нь хариугүй хошуу өлгөөд ирлээ. Түрүүлэхэд нь баярласан гэж хязгаар алга.

Дорж хунз яагаад саарал дааганы хоншоор дундуур ташуурдсан бэ? А. Саарал даагыг нэгдлийн хурдан хээрийн удам гэдгийг мэдсэн учраас
B. Саарал даага өөрийнх нь хээр даагыг гүйцээд ирсэн учраас
C. Саарал даага наадамд түрүүлсэн учраас
D. Хээр даагаа дагаж давхиж байгаад санамсаргүй ташуурдсан Е. Дорж хунз ташуурдаагүй.

4. Эхэд дэвшүүлсэн асуудал буюу сэдвийг олоорой.
A. Саарал даганы тухай
B. Наадмын тухай
C. Даганы уралдааны тухай
D. Эх үрийн холбооны тухай
E. Шударга бус зангийн тухай

5. Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
A. Эхийн нь янцгаалт саарал даганд юу юунаас илүү хүчийг өгчээ.
B. Дорж хунз дээр хэн ч очсонгүй.
C. Гэвч Дорж хунз өөрөө наашаа ирэх байлгүй дээ.
D. Яах ийхийн завдалгүй саарал минь жирэлзэн хурдалж хээр даага, улаан дарцаг ээлжлэн өнгөрөв. Түрүүлчихлээ.
E. Түрүүлэхэд нь баярласан гэж хязгаар алга.

6. Өгүүлэгчийн харамсах сэтгэлийн байдлыг илэрхийлсэн өгүүлбэр аль нь вэ?
A. Яах ийхийн завдалгүй саарал минь жирэлзэн хурдалж хээр даага, улаан дарцаг ээлжлэн өнгөрөв. Түрүүлчихлээ.
B. Энэ хооронд Дорж хунзын хээр даага нэлээд зайлчихсан байв. Өнгөрчээ...
C. "Гэвч хээр даага хэдхэн харайгаад барианд орно... за байз... яая даа...
D. Гэвч Дорж хунз өөрөө наашаа ирэх байлгүй дээ.
E. Би хэдэнтээ хүчтэй ширвээд хашхираад орхисон чинь хээр даагатай зэрэгцээд очлоо.

7. *"... аяндаа **саарлаас минь** хоцрох нь тэр", "**жороо хараа** халбилзуулж", "тийм **хурдантай** болохын тулд*"- хэсгээс тодруулсан үгсийг ажиглан дүрслэх ур маягийг олоорой.
A. адилтгал B.ихэсгэл C. багасгал D. төлөөлөл F. тойруулал

8. Дорж хунзыг хөндлөнгөөс дүгнэсэн өгүүлбэрийг олоорой.
A. Чи надад азаргаа өгсөнгүй. Очиж очиж нэгдэлд зүгээр өгчихнө гэнэ ээ!
B. Чиний муу хээр үрээг аваагүйгээр Дорж хунз хохироо ч уу, үгүй ч үү?
C. Жаахан явуул... Жолоогий нь сулруулахгүй юу, муу мангуу!
D. Даганд нь тийнхүү амьтны ам сайн байгаад Дорж хунз их л бардам явна. Е. Би чамд гаансан дээрээ дөрвөн бод нэмж өгье гэж мөн их гуйсан даа

9. Өгүүлбэрийг эсрэг утгаар нь зөв харгалуулсан хэсгийг олоорой.

1. Морь тавьсан улсуудын морьд цөм л дааганаас хоцрохооргүй байсан боловч журмыг сахиж томчууд морьдынхоо амыг татав.

2. Тэр сүйд болоод байгаа нэгдэл чинь чамайг яаж гялайлгахыг харахсан.

3. Хөлстэй тохмоо шилгээн эхээ хөхөж байсан хөөрхөн саарал даагыг минь хамаг амьтан бүчин ирлээ.

4. Түүний хурдны шинж бүрдсэн өндөр хээр даагыг түрүүлнэ гэж ихэнх хүмүүс ярина.

5. Буруу талаар нь хариугүй хошуу өлгөөд ирлээ. Түрүүлэхэд нь баярласан гэж хязгаар алга.

a) Нэгдэл, хөдөлмөр хоёр аавыг минь яаж гялайлгасныг Дорж хунз одоо ч харж явна.

b) Миний ... саарал даагыг нэгдлийн хурдан хээрийн унага гэж мэдэх ... хэдхэн хүнээс бусад нь сайн давхина гэж зүүдэлсэнгүй бололтой.

c) Энэ хооронд Дорж хунзын хээр даага нэлээд зайлчихсан байв. Өнгөрчээ...

d) Дорж хунз л ганцаараа хоцорсонгүй тэр даагатайгаа зэрэгцэн давхиж, ... гэх зэргээр дуу хадуулж явлаа.

e) Хээр даганыхаа хөлсийг хусаж зогсоо Дорж хунз дээр хэн ч очсонгүй.

A. 1d2a3e4c5b B. 1d2a3c4e5b C. 1d2a3e4b5c
D. 1e2c3a4b5d E. 1d2e3a4b5c

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1 Дараах эхээс уншаад зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай 1 үгийг олвол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо [5 оноо]

“Айлаас ирэхээр авдраа уудла” гэсэн монгол үг бий. Хүн бүрийн оюун ухааны авдарт “хүслийг хангагч чандмань эрдэнэ” дүүрэн байдаг юм. Гагцхүү авдарынхаа тагыг итгэлтэй сөхөж, хэрэгтэй зүйлээ оролдлого зүтгэлээр эрж хайж, эцэж цуцашгүй чармайлтаар олж илрүүлэн, оновчтой ашиглах л хэрэгтэй. Мөрөөдөл тэмүүлэл, өөдрөг сэтгэл, хичээл зүтгэл, тэсвэр тэвчээр, цөхрөлтгүй оролдлого, ажилсаг бүтээлч чадвар энэ бүгд бүтээлч хүнд зайлашгүй байх шилдэг чанарууд.

Ташаарсан нь	**Залруулсан нь**

2.2. Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал
4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой
болно. [5 оноо]

᠂᠂᠂

"Тэмээ тахална гэдгийг анх л сонслоо. Тэгээд бас төмөр биш ширээр тахалдаг байх нь ээ" гэж хангайн зочин сониучлан бодсоноо:

- Элс юм цэвэрлэдэг ч юу л бол? гэв.
- Үдээс хойш энэ хойт Бөөргийн элс рүү очоод л үзье л дээ. Наад бахиал чинь тос нэвчээд үзэх аргагүй болж. Бөөргийн элсэнд хэд алхаад цэвэрлэж ав л даа. Далимд нь би нөгөө муу солбиу хүрэнгээ тахлаад орхиё. Тэрхэн элсэн тушаа байгаа гэж тэмээчин санал болгов.
- Яршиг ч юм уу даа! Манай хангайд бол ч өөр шүү дээ. Хэд алхаад л тошлой, үхрийн нүд, гүзээлзгэнэ... Харин энэ говьд ч жимс байтугай булгийн цэвэр ус ч олдохуйяа бэрх юм шиг вэ дээ гэж хангайн зочин тунирхлаа. Тэмээчин өвгөн:
- Бөөргийн элс хавиар хармаг ургадаг юм. Хармагны бутанд сууя. Тэр үхрийн нүд мүднээс чинь дутахгүй сайхан жимс байгаа юм. Түүж үзэхгүй юу? гэв. Жимсний сургаар хангайн зочны сэтгэл сэргэж
- Үнэн хэлж байна уу? Тэгвэл хоёулаа гарч салхилангаа тэр жимсийг чинь үзье.

Ер нь хармаг зармаг гэцгээгээд байдаг юм. Ямархуу эд вэ дээ! Үзэх минь гэв.

Мань хоёр тэгээд санал нийлж, Бөөргийн элсэнд очихоор явлаа. Тэмээчин хөвөнтэй дээлтэйгээ, хангайн зочин бараг чармай нүцгэнээрээ явжээ.

- Хангайг бодвол шумуулгүй нь харин сайхан юм гэж хангайн зочин олзуурхлаа. Удалгүй тэд Бөөргийн элсэнд хүрлээ.
- За энэ элсэн дундуур туучаад үз. Наад муу бахиал чинь цоо шинэ болоод л гараад ирнэ. Би тэр солбиу хүрэнг бариад ирье. Тэр сондуулын цаана байж байна гэж тэмээчин өвгөн хэлэв. Хангайн зочин давсарсан цас мэт нургилсан шар элсэн дундуур нааш цааш явж, гараар цацаж, нуруугаар хөлбөрч дураараа хэсэг зуур аяглав. Төдхөн солбиу хүрнээ хөтлөөд өвгөн ч ирлээ.

Хоёул хамжин тэрхүү солбиу хүрэн атыг ширээр тахлав. Тавхайн дундуур нь хэлбэсэн ширэн тахаа өмсгөж бүдүүн тэвнээр сүвэлсэн шөрмөсөөр тавхайтай нь оёж бөхөлснөөр тэмээ тахлах ажил дууслаа. Дараа нь хоёул хармаг жимс түүхээр болжээ. Элсэн дундуур туучиж, бутнаас бут дамжин явсаар байтал хангайн зочны гутлын хоншоор, зулаг нь үнэхээр зүлгэгдээд цэвэршээд иржээ.

- Элс чинь нээрээ л халгаатай эд юм байна даа гэж хангайн зочин сая л зөвшин ярив.

Хоёул хармаг түүж эхэллээ. Нар хурцаар шарж хангайн зочны нүцгэн бие дээгүүр хөлс урсан цувж, говийн тэмээчин сэтгэл өег байлаа. Тэгтэл хангайн зочин орь дуу тавьж зүүн гараа алгадан чарлав. Тэмээчин өвгөн цочин босож гүйж хүрвэл хангайн зочны зүүн гарын булчин дээр зэс өнгөтэй эрхий хуруун чинээ цох хорхой наалдсан байлаа.

- Хүүе, хүүе битгий цохиж сандраа. Наадах чинь цочоовол салдаггүй юм. Аргаар салгах учиртай гэж тэмээчин өвгөн хэлээд бүснээсээ хэт авахаар тэмтрэхэд хангайн зочин айсандаа өвгөний үгэнд орсонгүй, нөгөөх цох хорхойг гараараа авч шидэхээр зулгааж эхлэв.
- Хүүе, болохгүй. Аргаар авдаг юм хүчээр салгавал шархалж баалаад сүйд болно! гэж өвгөн хэлээд хэтээ гарган цахих зуур хангайн зочин тэсэж чадсангүй нөгөөх цохыг хүчээр угзран авч хаяв. Булчин дээрээс нь цус урсан элсэн дээр дуслав. Зэсэн улаан хөлөө арзайлгаад эрхий хуруун чинээ цох мөн л элсэн дунд ойчив. Тэгтэл мань хангайн зочин баруун гар дээр бас нэг хөмрөг шигдэн суугаад хазахыг өвгөн харав. Хангайн зочин орилон тийчлэв. Өвгөн хэт цохиж асаасан уулаа унгатгаж нэг гараар зочны баруун шууг атгаж нөгөөгөөр унгадах уулыг барьж хөмрөг цохын нуруун дээр төөнөв. Цох ч өөрөө хөсөр ойчлоо.
- Яасан аймаар хорхой вэ? Юу гэдэг юм бэ? гэж хангайн зочин гайхан шүүрс алдав.
- Хөмрөг гэдэг цох. Хазахаар нь хүч хэрэглэвэл салдаггүй, салбал баалж шархлуулдаг.

Харин хүж юмуу галаар төөнөвөл аяндаа өөрөө салаад гэм халгүй өнгөрдөг юм. Одоо зүүн гар чинь баална даа. Гурилаар хөхүүлэхээс биш! гэж тэмээчин өвгөн хэлэв.

Зэсэн өнгөт хөмрөг цохыг хангайн зочин элсэнд зүлгэгдсэн гутлаараа бяц гишгэлээ.

(Л.Түдэв)

1. Дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

1. хэт	a) үхэр, адуу, тэмээ, тураг гөрөөс зэргийн арьс
2. шир	b) гал асаах
3. баалах	c) гал ноцоох хэрэглэл
4. унгатгах	d) дов
5. сондуул	e) идээрлэх

A. 1d2e3a4c5b *B. 1d2c3b4e5a* *C. 1d2e3b4a5c*
D. 1c2a3e4b5d *E. 1d2c3a4e5b*

2. "*Ширээр давхар тахалчихвал нэлээн тэснэ дээ гэж* ***зугуухан*** *ярив."* гэсэн өгүүлбэри йн онцолсон үгийн утгыг олоорой.

A. уурлаж бухимдсан байдалтай
B. асар түргэн, чанга биш аажим алгуур
C. үгээ зөөж ядах
D. дооглож тохуурхсан байдалтай
E. дургүйцсэн байдалтай

3. *"Хангайн зочин* ***давсарсан цас мэт нургилсан шар элсэн*** *дундуур нааш цааш яв ж, гараар цацаж, нуруугаар хөлбөрч дураараа хэсэг зуур аяглав."* гэсэн өгүүлбэрий н тодруулсан хэсгийн дүрслэх ур маягийг олоорой.

A. Хэтрүүлэл B. Тойруулал C. Ёгтлол
D. Адилтгал E. Амьдчилал

4. Хангайн зочны говь нутгийн талаарх эерэг үнэлэмжийг олоорой.
A. ...говьд ч жимс байтугай булгийн цэвэр ус ч олдохуйяа бэрх юм шиг вэ дээ...
B. Ер нь хармаг зармаг гэцгээгээд байдаг юм. Ямархуу эд вэ дээ! Үзэх минь гэв.
C. Элс чинь нээрээ л халгаатай эд юм байна даа ...
D. Хангайг бодвол шумуулгүй нь харин сайхан юм ...
E. Та нар мөн бөх голтой улс аа!

5. Хангайн зочин, говийн малчин хоёр ямар холбоотой хүмүүс вэ?
A. Худ ургийн холбоотой
B. Анд нөхдийн холбоотой
C. Ажил төрлийн холбоотой
D. Хамаатан садны холбоотой
E. Нутаг орноороо холбоотой

6. *"Цэвэр элс гэдэг чинь өрөвтөл хуурайтай адил."* гэсэн санааг баталсан баримт аль нь вэ?
A. Нурсан зөөлхөн элсэнд тэмээн тавхай байтугай хүний хөл ч сайртахгүй биз.
B. Ер нь тэр хот газрын хими цэвэрлэгээнээс дутахгүй л дээ.
C. Элсэн дундуур туучиж, бутнаас бут дамжин явсаар байтал хангайн зочны гутлын хоншоор, зулаг нь үнэхээр зүлгэгдээд цэвэршээд иржээ.
D. Тэмээний тавхай элсэн дунд тэсдэггүй юм.
E. За энэ элсэн дундуур туучаад үз. Наад муу бахиал чинь цоо шинэ болоод л гараад ирнэ.

7. Эхэд дэвшүүлсэн асуудал буюу сэдвийг олоорой.
A. Говь нутгийн тухай
B. Хөмрөг цохны тухай
C. Хүн байгалийн харилцааны тухай
D. Хангай говийн ялгааны тухай
E. Хангайн хүмүүсийн тухай

8. Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
A. Хүн байгальтайгаа дасан зохицон амьдардаг.
B. Говьд амьдрах хэцүү бэрх байдаг.
C. Хөмрөг цох аюултай.
D. Хангайн хүмүүс хөнгөн, дураараа байдаг.
E. Хангай говь хоёр эрс тэс уур амьсгалтай.

9. Өгүүлбэрийг тгаар нь оновчтой эсрэгцүүлсэн хэсгийн дугаарыг олоорой.

1. Хангайн зочин говийн бүгчим халууныг гайхаж хамаг хувцсаа тайлж бараг л чармай нүцгэн суух болов.	a) Өөх тос, хир буртаг болчихсон дээлтэйгээ элсэн дээр хэд өнхрөхөд л бараг шинэ болоод орхидог юм.
2. Одоо элсэн дунд тэмээн тавхай элэгдэнэ гэж үү дээ?	b) Хүж юмуу галаар төөнөвөл аяндаа өөрөө салаад гэм халгүй өнгөрдөг юм.
3. Манай хангайд бол ч өөр шүү дээ. Хэд алхаад л тошлой, үхрийн нүд, гүзээлзгэнэ...	c) Хөвөнтэй дээл ч бас нимгэдээд байна. Үстэй үзүүрсэг өмсөөд явбал халуунд сайхан таардаг юм.
4. Элс юм цэвэрлэдэг ч юу л бол?	d) Говийн элсэн манхан дундуур удаан явбал юу ч тэсэхгүй!
5. Хазахаар нь хүч хэрэглэвэл салдаггүй, салбал баалж шархлуулдаг.	e) Харин энэ говьд ч жимс байтугай булгийн цэвэр ус ч олдохуйяа бэрх юм шиг вэ дээ гэж хангайн зочин тунирхлаа.

A. 1c2e3d4a5b B. 1c2d3e4a5b C. 1c2d3e4b5a
D. 1c2a3e4b5d E. 1d2c3a4e5b

10. “Та нар мөн **бөх голтой** улс аа! Энэ пүүгсэн халуунаар хөвөнтэй дээлнээс салдаггүй” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгтэй утгаараа тохирох үгийг олоорой.

A. амь бөхтэй B. бээрэг C. дотуур тамиртай
D. шөрмөстэй E. хар тэнхээтэй

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1 Дараах эхээс уншаад зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай 1 үгийг олвол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо [5 оноо]

Морь эргэх газар нилээд зайтай, нар орой болж байгаа учир ширүүхэн явцагаалаа. Ергөх нь морины гэдэс зайлчихна гэж хашир хүмүүс голдуу цогиулах ажээ. Удалгүй морь эргэх тэмдэгт газар ирцгээхэд аав намайг хөтлөж нэлээд түрүүгээр гаргаад тавьлаа. Морь тавьсан улсуудын морьд цөм л дааганаас хоцорхооргүй байсан боловч журмыг сахиж томчууд морьдынхоо амыг татав.

Ташаарсан нь	Залруулсан нь

2.2. Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. [5 оноо]



.....
.....
.....
.....
.....
.....
.....

2.3 **“Ухаарал”** сэдвээр эх зохион бичээрэй. Бичихдээ бүтэц, хэв шинж, сэдэв, агуулгын харьцаа болон найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглаарай. Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 150-180/ [20 оноо]

12 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ
(Хувилбар “А”)

САНАМЖ:

- Бүх даалгаврыг заавал гүйцэтгэнэ
- Унших чадвар сорьсон даалгаврыг 60 минутад, бичих чадвар сорьсон даалгаврыг 30 минутад
  тус тус багтаан гүйцэтгэнэ.
- Унших чадвар сорьсон даалгаврыг гүйцэтгэхдээ эхийн задлалын үнэлгээний шалгуурт нийцүүлээрэй.
- Бичих чадвар сорьсон даалгаврыг гүйцэтгэхдээ эх зохион бичих зорилго, сэдэв агуулгын харьцааг сайтар тооцоолоорой.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ-УНШИХ ЧАДВАР СОРЬСОН ДААЛГАВАР

Зохиолч Л. Түдэв гуайн "Хорвоотой танилцсан түүх” туужийн хэсгийг анхааралтай уншаад даалгаврыг
гүйцэтгээрэй.

Зурагтай танилцсан минь

Жаалхүү гэдэг өвгөнийх олон хүүхэдтэй айл байв. Нэгэн өдөр тэдний хамгийн том хүүхэд гэрийнхээ гадаа завилж суугаад, өвөр дээрээ дөрвөлжин мод тавьж ямар нэгэн юм хийж байхыг үзлээ. Юу хийж байгааг нь үзэх сэн гэхээс тэсэж суух аргагүй болов. Ороо хонь барих гэж байгаа юм шиг сэм сэмхэн гэтсээр, тэр хүүхдийн ар талд очоод өнгийн харвал онц сонин юм үзэв. Модон самбар дээр үнс түрхжээ. Нарийхан үзүүртэй савх модоор үнсэн дээрээ нааш цааш зурж байгааг нь харахад гайхмаар ажээ. Даваасамбуу гэж тэр хүүг нэрлэдэг юм. Даваасамбуугийн гар нь нааш цааш уяхнаар хөдлөх бүрийд үнс түрхсэн самбар дээр дүрс гарч байлаа. Бух урд хөлөөрөө газар цавчлан, хэлээ унжуулан, туужуу мэт сүүлээ хондлой дээрээ агсжээ.

Даваасамбуу намайг ар талдаа ирээд ажиглаж байхыг мэдсэнгүй. Цааш тавтайяа үргэлжлүүлэн зурсаар байв. Удаж төдөлгүй дахиад нэг сарлагийн бух зурчихлаа. Хоёр сарлагийн бух өөд өөдөөсөө харж зааглан мөргөлдөхийг завдаж буй ажээ. Би тэр сонин зургийг нүдээ бүлтэртэл гөлрөн харж, хамаг юмыг нэгэн агшнаа мартжээ. Модон дээр модоор тэгж сайхан зурж болдгийг анх удаа тийнхүү мэдэж авлаа. Гол нууц нь модон самбар дээр түрхсэн аргалын үнс гэдгийг нь би мэдлээ. Даваасамбуу гэв гэнэт нөгөөх зургаа үнс асган балласанд би харамсаж "Хүүе, битгий” гэж дуу алдав. Даваасамбуу над руу эргэж харснаа ухасхийн босож гэрийн зүг одлоо.

Санамсаргүй нээж олсон нууцаа туршиж үзэхээр би гэрийн зүг салхи мэт дэгдэн одлоо. Гэрт орж ямар нэгэн дөрвөлжин мод хайж гарлаа. Гэрт хэн ч үгүй тул дурааараа загнах эрхтэй байлаа. Гай болоход гэрт нэг ч хавтгай мод байсангүй. Цорын ганц боломжийн мод гэвэл өрөм хатаадаг тос нэвчсэн бор мод эргүүл /эргэнэг/ дээр байв. Хэсэг эргэлзсэний эцэст би тэр модыг олзлон авч, тулганы захаас аргалын цагаан үнс хайж олоод дээр нь нунтаглан түрхэв. Дөрвөлжтэй түлээн дотроос бяцхан савх мод олж хутгаар үзүүрлэв. Зурах ажилдаа орлоо. Сарлагийн бух зурж эхлэв. Даваасамбуу шиг уран зурах гэгч огт хялбар биш ажил байжээ. Хөлсөө гартал ноцолдоод нэг бух зурсан чинь хөрш айлын доголон халтар нохойтой адилхан амьтан болчихлоо. Эсрэг талд нь ахиад нэг нэг бух зурах гэж улайран сууж байтал гэв гэнэт хацар дээр халуун оргив.

-Чи яагаад өрөм хатаадаг мод бузарлав. Ээжид чинь хэлж турсагыг чинь хуулуулна даа! гэж загнах дуунаар өндийн үзвээс авга эгч зогсож байлаа. Бид нар түүнийг "Айдаа” гэж авгайлна. Харин хүмүүс "Тарган” гэж дуудна. Нэр хоч хоёр нь яг адилхан тийм хүн манай тэр голд ганцхан л Айдаа байж дээ.

- Айдаа, энийг хараач, юу вэ? гэж би зурсан зургаа заалаа.

-Аль вэ, яагаав Донтор л байна гэж Айдаа хөхөрч гарав. Донтор гэж хөрш айлын доголон халтар нохойн нэр л дээ.

-Донтор биш ээ. Аяа Балдангийн халзан бухыг зурсан юм гэж би ярьсанд Айдаагийн инээд улам хүрч бүр сүүлдээ эвхрэн ойчоод нүдний нь нулимс цувж, цээж нь хэржигнэн хөхөрсөөр байлаа. Айдаа инээдээ барьж чаддагүй хачин хүн л дээ. Түүнийг хөхөрч хэвтэх хоорондуур би гарч зугтаалаа.

Үнс түрхсэн самбараа аргал доор нуув. Түүнээс хойш миний хийдэг юм зураг боллоо. Зун бол голын хөвөөнөө нойтон шавар, торгон элс, өвөл бол цасан дээр элдэв амьтны дүрс зурна. Нэг удаа манайд айлчлан ирсэн Ехөөмянган өвгөний арьсан дээлийн ар дээр могой зурж орхив. Өвгөн түүнийг мэдсэнгүй. Өглөө тэр босоод дээлээ өмсөх гэснээ могойг үзэж нүд нь бүлтрэх шахан айж

- Ай хан хурмаст минь! гэж хашгираад дээлээ чулуудчихав. Тэр могойноос айдаг юм байжээ. Би тэр могойноос болж хоёр хацраа хорстол ”илүүлэв”.

Би нэрэлхэж "Ехөөмянган гуай миний хоёр хацрыг халуу шаттал илсэн” гэж найзууддаа ярьсан юм. Тэд инээлдэж нэг хэсэгтээ намайг "илүүлдэг” гэж хочлох болж билээ.

Би бас эмгэн ээжийг яг адилхан зурчхаад тэр хэргийн учир хэд сайн чимхүүлж авсан... "Муу ёрын золиг. Сүг зураад нүгэлт чигяатархи” гэж буурал ээж их л зэвүүцэн загнасан. Буурал ээж хэр баргийн юманд уурладаггүй байтлаа өөрийг нь зурахад яагаад сэжиглэдгийг би огт ухаардаггүй

байлаа.

Нэг мэдсэн би сайн зурдаг боллоо. Сайн зурдаг болсноо Мана хөгшнөөс сонсов. Би тэр өвгөний толиод орхисон арьсан дээр муур зурчихсан юм. Мана өвгөн мууранд бас дургүй хүн байлаа.

Тэр жилийн намар би сургуульд орлоо. Аймгийн төв дээр авчирч нагац ахынд суулгах болов. Нагац ах маань нэгэн өдөр надад хэдэн янзын өнгөтэй дүгрэг юм үзүүлээд:

- Энэ юу вэ? гэлээ.
- Энэ лав товч байх гэтэл нагац ах инээж
- Энэ усан будаг шүү гэв.
- Яадаг юм бэ гэж би асуухад нагац:
- Үүгээр зураг зурдаг юм гэв. Тэр үгийг сонсмогц миний сонирхол оволзлоо.
- Яаж зурдаг юм бэ?
- Ингэж зурна. Чи сайн хар! гээд үзүүрээрээ хурганы сүүл шиг үстэй модыг усанд дүрж нөгөө дүгрэгюман дээрээ нийлж байгаад цаасан дээр зурлаа. Цэнхэр өнгө гарлаа.
- Цэнхэр өнгөтэй ямар юм байдаг билээ? Аа тийм, яргуй гэж нагац ах яриад цаасан дээр яргуй шигюм зурлаа.
- Ай, миний гар ч эвлэх юм биш. Ай даа, би чам шиг бага сан болоосой. Тэгвэл цуутай зураач болохсон. Даанч хожимдож орхисон юм. Гар минь төмөр нүдэхээс өөр юманд хөдлөхөө байжээ. Минийдүү ахынхаа мөрөөдлийг ав даа! гэж нагац хэлээд надад нэг ширхэг хөх будаг өгөв. Бусдыг ньцааш далд хийлээ.
- Ах аа, бусдыг нь өгөөч дээ!
- Өгөх болоогүй. Чи хөх будгаараа хөх өнгөтэй юм юу байна вэ, түүнийг цөмийг зурж сур. Тэгээд надаас улаан будаг нэмж ав гэж надад хэлэв. Би улаан будаг авахын тулд бүхнийг мартан чармайлаа. Тэгж хичээн зүтгэсээр хоёр сарын дараа солонгын долоон өнгө бүрдлээ. Би солонгозурав. Их талын элгэн дээр нумран тогтсон долоон өнгийн солонго зураад нагацдаа үзүүлэв.
- Ай даа, одоо бич, зураад бай. Надад өөр будаг байхгүй шүү гэв. Би зурсаар байлаа.

Зохиолч Л. Түдэв гуай **“Хорвоотой танилцсан түүх”** тууждаа хорвоо ертөнцийн сонин хачинтай танилцаж байгаа бяцхан хүүгийн тухай өгүүлжээ. Эх зохиолыг дараах даалгаврын хүрээнд задлан шинжлээрэй. /25 оноо/

1. Зохиолын агуулгыг гаргахад хамгийн чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж байгаа 5 үг хэллэг, өгүүлбэр сонгон 80-90 үгэнд багтаан учрыг тайлбарлаарай. [5 оноо]

2. Жаал хүүгийн зан байдал, үйл хөдлөлийн эерэг, сөрөг талд үнэлгээ өгч, 80-100 үгэнд багтаан дүгнэлт бичээрэй. [7 оноо]

3. Эхийг найруулгын ямар хэв маяг ашиглан бичсэн байна вэ? 60-70 үгэнд багтаан батлан бичээрэй. [5 оноо

ХОЁРДУГААР ХЭСЭГ. БИЧИХ ЧАДВАР СОРЬСОН ДААЛГАВАР

Л. Түдэв гуайн **“Хорвоотой танилцсан түүх”** туужийн хэсгийн бичлэгийн арга барилыг ашиглан
“Миний хамгийн сайхан дурсамж” сэдвээр эх зохион бичээрэй. Үгийн тоо 250-300/25 оноо\

12 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ (Хувилбар “В”)

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ-УНШИХ ЧАДВАР СОРЬСОН ДААЛГАВАР

Зохиолч Л. Түдэв гуайн "Хорвоотой танилцсан түүх” туужийн хэсгийг анхааралтай уншаад нэгдүгээр даалгаврыг гүйцэтгэрэй.

Дуутай танилцсан минь

Аав нэгэн өдөр авдрынхаа арын хонгилоос нарийхан шар алаг хөндий мод гаргаж ирлээ.Хөндий хулсан саваны бөөрөн дээр нь хэдэн нүх гаргасан байлаа. Аав түүнийгээ хөндлөн барьж,бөөр лүү нь нэг үлээж үзснээ, хуруунуыхаа өндөгнүүдийг шүлэмдэж чийглэлээ. Дараа нь хулсан саваагхөндлөн барьж, нүх бүр дээр хуруу бүрийн өндгөөр дарж, уруулаа урагш цорвойн үлээж эхэллээ.

Эхлээд салхин уяхан исгэрэх мэт дуу гарч, төдөлгүй огцом өөрчлөгдөн усны урсгал адил болж,миний урьд өмнө хэзээ ч сонсож байгаагүй тийм сайхан дуу гарлаа. Аавын гарын хуруунууд хулсансаваны бөөрөн дээр ээлж дарааллан цовхин бүжих мэт дэгдэн товшиж, дууны аялгуу нь тэрийгдагалдан хувирч байлаа.

Хөндий тэр хулс аав хоёр тоглон наадаж, бие биеийг хөөцөлдөн, барин тавин байх мэтсанагдана. Аавын хуруу хулсан саваанаа буухад тэр нь баригдсандаа баясан инээх ба эсвэл гомдонгаслах, улмаар чарлан зүггүйтэх мэт ажээ. Тэрхүү хулсан саваны гаргаж байгаа дуу нь зуны сарынногоон ой хөвч шуугин исгэрэх шиг, цавчин элгэн хаднаас булгийн тунгалаг ус хоржигнон буух шиг,тэгснээ хөвчийн өндөр модонд хөхөө шувуу хавшин донгодох мэт, хан уулсын цэнхэр оргил дээгүүрусны шувуу гангар гунгар нисэн ирэх мэт санагдана. Өвөөлж бөвтнөж, хойлог ёолж, шар шувууууухилж, шаазгай шагширч, хэрээ гуагалан, элээ унгалдахыгч би тэрхүү хөндлөн модноос сонслоо. Намрын хонгор салхинд өвсөн толгой шуугиндавалгаалах, хонь мал төллөн хурга ишиг эхтэйгээнийлэхэд хадны цуурай тэднийг дуурайн майлах мэт дуу авиа ч бас л тэрхүү хөндлөн модноос гарна.

Миний өчүүхэн бор зүрх уяран хайлж, бадран догдолж, баясан цовхчиж, туранхай цээжнийминь чанад багтаж ядан, донсолж байлаа. Тэрхэн мөчид би хамаг бүхнийг мартаж, гагцхүү эцгийнэвэрлэг арван хуруу хулсан саваанаа дэгдэн наадахыг л ажиглан суулаа. Аавын духнаа гарсангүнзгий атирааг дагаад хөлс дааварлан гялтганаж, уруул нь үл мэдэн чичиргэнэн, нүдний нь харцалсын алсыг ширтсэн мэт намуухан болжээ.

Нэг мэдсэн харанхуй нөмрөөд орхих мэт хачин жигтэй, бас ч зэврүүхэн болжээ. Аав тоглохоо зогсоосноос тэр мэт хачин сэтгэгдэл төрлөө.

- Аав аа, энэ чинь юу юм бэ? гэж би сая ухаан орсон адил гайхан асуулаа.
- Лимбэ гэдэг хөгжим. Үүгээр орчлон хорвоогийн дуу чимээг үйлдвэрлэдэг юм гэж аав шоглох мэт хэллээ. Аав үйлдвэрийн ажилчин болсноос хойш тэгж үйлдвэр гэхчлэн ярьдаг болчихсон юм.
- Аав аа, юутай сайхан юм бэ? Надад зааж өгөөч гэж би гуйлаа.
- Өөрөө оролдож сур. Тэгвэл сурах эсэх нь мэдэгдэнэ. Өөрөө оролдоод чадахгүй бол, түүнд авьяасгүй гэж мэдээрэй.

Энэ ярианаас хойш би лимбэ гэдэг хөндий саваг толгойгоо дүйртэл үлээж, сар шахам боллоо. Тэр лимбэнээс ямар нэгэн дуу гарахгүй биш, гарч байв аа. Гэхдээ өвлийн шөнө хотны захад чоно улих юм уу, эсвэл гадаа тавьсан данхны цоргоор салхи орох үед юу дуулддаг билээ, тэр мэт дуу авиа гарч байлаа.

- Яршиг, дамшваа минь, толгой эргэж гүйцлээ.
- Чихний улиг барлаа! гэж эмэг ээж, залуу ээж цөмөөрө уцаарлаж байлаа. Тэр бүхэнд би шантарсангүй. Лимбэ үлээн ёнгинуулсаар байтал, ээж нэгэн өдөр намайг дуудаж:
- Миний хүү, би чамд өөр сайхан хөгжим зааж өгье. Энэ лимбэ чинь чих дөжрөөчих золиг байна, орхи! гэв ээ.Ээж маань чүдэнзний хайрцагнаас арай жижигхэн дөрвөлжин хулсыг буйлан дотроосоо гаргаж ирэв. Тэр дөрвөлжин хулсны голд нүхэлж хоёр нимгэхэн хэл шиг юм зоогоод нэг үзүүрт нь урт шар утас бэхэлжээ. Ээж:
- Аман хуур нэртэй юм гээд, нөгөөх дөрвөлжин хулсаа амны хөндийд байрлуулж, тагнай хэл хоёрын хоорондтогтоогоод, утасны үзүүрээс чичрэгнүүлэн татаж нэг чангалан, нэг султгаж уруулаа хөдөлгөн наадахад, аавын лимбэнээс дутахгүй мөртлөө намуухан дуу гарч эхлэв. Тэр дууны сайхан нь миний сэтгэлд таатай чихэнд чимэгтэй байлаа. Ээжээс бяцхан холдъё гэвэл, тэр аман хуурын дуу сонсогдохоо болино.
- Миний хүү чамд энэ ямар санагдаж байна? гэж ээж надаас асуув.

- Сайхан байна. Дуу нь жаахан бүдэг юм.
- Аав чинь "бас л сайхан дуутай юм байна” гэж аман хуурт дурладаг сан. Хуураа татаач гэж үргэлж гуйдаг сан. Тэгээд, аман хуурын дууг бүдэгхэн байна гэж, хацарт минь хацраа наан чагнадагсан гэж ээж яриад, санаа алдаж, миний толгойг илнэ.

Тэр цагаас хойш би дуунд дуртай боллоо. Аавын лимбэдэхийг, ээжийн хуурдахыг сонсох бүрий сэтгэл уярч, хоолой дээр минь бөөн юм зангиран ирдэг сэн. Тэгээд би хөгжимчин болохыг хүсэв.

Бааст гэдэг ногоовтор нүдтэй зузаан уруултай жаал шанага цохиж, пиржигнүүлэн дуугаргаж, нөгөө гараар ишин дээрээс нь атган, хуруугаар дарж байлаа.
- Юу вэ, жаал аа? гэв.
- Мандолин хөгжим гэж мэдэх үү? Чам шиг нусгай үүнийг шанага гэж андуурна даа хэмээн тэр хүү ёжлов. Тэр даруй би түүнийг шавь боллоо. Түүнд би нэг сайн чавх өгч, дээр нь хөөрхөн шар шил нэмэр болгов. Бааст түүнийг дуртайяа авч, над багшлах болов.

Миний зүүн гарын дөрвөн хурууны өндөг төдөлгүй цэврүүтлээ. Хөгжмийн утсанд хүрэхэд, халуу шатан өвдөнө. Гэвч хөгжимд дурлах сэтгэлийг минь зуурдын өвчин дийлсэнгүй. Цэврүү нь эвэр болон хувирлаа. Эвэр өндөгтэй болсноос хойш мандолин дарах хорхой минь улам нэмэгдэж, байж сууж ядах болов. Хоёр дууг сайн мандолиндаж сураад байтал, гай тохиолдлоо. Гарын хурууны чилэхийг мэдэхгүй тоглож байтал, жингэнэх дуун сонсогдож мандолины нэгэн утас нь тасран нисэж одлоо. Бааст бид хоёр гаслан уйллаа. Тийнхүү надад хөгжимчин болох аз дутжээ. Тэгээд би эцгийн адил лимбэ хагас дуугаргадаг төдийгөөр хөгжмийн боловсролоо дуусгажээ. Гэвч би хорвоогийн уяхан дууг хөгжмөөр дамжуулан мэдэрснээ үл мартав. Хорвоо исгэрч, уухилж, уянгалж, бахирч, гасалж уйлдаг юм билээ.

Зохиолч Л. Түдэв гуай **“Хорвоотой танилцсан түүх”** тууждаа хорвоо ертөнцийн сонин хачинтай танилцаж байгаа бяцхан хүүгийн тухай өгүүлжээ. Эх зохиолыг дараах даалгаврын хүрээнд задлан шинжлээрэй. /25 оноо/

1. Зохиолын агуулгыг гаргахад хамгийн чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж байгаа 5 үг хэллэг, өгүүлбэр сонгон 80-90 үгэнд багтаан учрыг тайлбарлаарай. [5 оноо]

2. Жаал хүүгийн зан байдал, үйл хөдлөлийн эерэг, сөрөг талд үнэлгээ өгч, 80-100 үгэнд

багтаан дүгнэлт бичээрэй [7 оноо]

3. Эхийг найруулгын ямар хэв маяг ашиглан бичсэн байна вэ? 60-70 үгэнд багтаан батлан бичээрэй. [5 оноо]

4. Зохиогч эхэд ямар санаа дэвшүүлэн тавьсныг жишээ баримтаар баяжуулан 80-100 үгэнд

багтаан дүгнэн бичээрэй. [8 оноо]

ХОЁРДУГААР ХЭСЭГ. БИЧИХ ЧАДВАР СОРЬСОН ДААЛГАВАР

Л. Түдэв гуайн **“Хорвоотой танилцсан түүх”** туужийн хэсгийн бичлэгийн арга барилыг ашиглан
“Миний хамгийн сайхан дурсамж” сэдвээр эх зохион бичээрэй. Үгийн тоо 250-300 /25 оноо\

Унших, бичих даалгаврыг үнэлэх шалгуур

№	Үнэлгээний чиглэл	Үнэлгээний шалгуур	Үнэлгээний нарийвчлал	Оноо
1.	Зорилгоо хангаж буй эсэх /15 оноо/	Сэдэв ба зорилго	Бичих сэдвээ мэдэрч, өөрийнхөө санааг хангалттай түвшинд илэрхийлсэн зорилгоо хангасан	6 оноо
2.			Бичих зорилгоо зөв ойлгож санааг боломжийн түвшинд илэрхийлсэн, нөлөөлөл сайтай	5 оноо
3.			Зорилгоо мэдэрч, агуулга сэдвийн хүрээнээс халиагүй, санааг зохих түвшинд илэрхийлсэн, нөлөөлөл илэрсэн	4 оноо
4.			Агуулга, сэдвийн холбоо алдагдсан, санаа бүрхэг, зорилгоо дундаж хангасан	3 оноо
5.			Зорилгоо ойлгоогүй ч сэдэвтэй холбоотой нэг хоёр санаа илэрсэн	2 оноо
6.			Зорилгоо ойлгоогүй, сэдэвтэй холбоотой ганц нэг санаа илэрсэн ч өөр зүйл бичсэн бол	1 оноо
7.			Зорилгоо ойлгоогүй, өөр зүйл бичсэн бол	0 оноо
8.			Юу ч бичээгүй	X
9.		Бүтэц	Бүтцийн хувьд эхлэл, гол, төгсгөл нь тодорхой заагтай, агуулга нь зөв дараалалтай, уялдаа логиктой	4 оноо
10.			Бүтцийн хувьд эхлэл, гол, төгсгөл нь тодорхой заагтай, агуулгын дараалал, уялдаа логик бага зэрэг алдагдсан	3 оноо
11.			Эхийн бүтцийн аль нэгийг орхисон, агуулга товч, ерөнхий эсвэл дараалал алдагдсан	2 оноо
12.			Эхийн бүтцийн дараалал алдагдсан ч ерөнхийд нь ойлгож болохоор бол	1 оноо
13.			Бүтцийг тодорхойлох боломжгүй, зааггүй. Агуулга нь дотооддоо зөрчилтэй	0 оноо
14.			Юу ч бичээгүй	X
15.		Эшлэл баримт	Эшлэл баримт /онцгой үг, хэллэг, дүрслэх хэрэглүүр, чимэг үг, яруу хэрэглүүр/ авч өөрийнхөөрөө тайлбарласан бол	3 оноо
16.			Эшлэл баримт хангалттай авсан ч бичиглэл тайлбар дутуу	2 оноо
17.			Эшлэл баримт хомс авсан, бичиглэл тайлбар дутуу	1 оноо
18.			Эшлэл баримт ашиглаагүй, эсвэл тайлбаргүй	0 оноо
19.			Юу ч бичээгүй	X
20.		Бичлэгийн хэлбэр, төрөл	Тухайн бичлэгийн хэлбэр төрлийг чадмаг ашигласан	2 оноо
21.			Тухайн бичлэгийн хэлбэр төрлийг хагас дутуу ашигласан л	1 оноо
22.			Бичлэгийн хэлбэр ашиглаагүй, оновчгүй	0 оноо
23.			Юу ч бичээгүй	X оноо
24.	Хэл найруулга /6 оноо/	Үг сонголт, өгүүлбэрийн бүтэц, хэв шинж	Үг сонголт оновчтой, өгүүлбэрийн бүтэц хэв шинж сайтай	3 оноо
25.			Үг сонголт оновчтой, өгүүлбэрийн бүтэц нь нэг хэв шинжийг голлосон, давтагдсан	2 оноо
26.			Сонгосон үг хоёрдмол утгатай, өгүүлбэрийн бүтэц, холбоо алдагдсан, бүрэн хэлбэржээгүй	1 оноо
27.			Сонгосон үг оновчгүй, явцуу, олон давтсан, өгүүлбэрийн бүтэц, холбоо алдагдсан, бүрэн хэлбэржээгүй	0 оноо
28.			Юу ч бичээгүй	X
29.		Хэлзүйн найруулга	Хэрэглээ ба хэлзүйн алдаагүй, эхийн найруулга сайн	2 оноо
30.			Хэрэглээ ба хэлзүйн санамсаргүй алдаа гаргасан нь эхийн найруулгад нөлөөлөхгүй	1 оноо
31.			Хэрэглээ ба хэлзүйн алдаа хэт их	0 оноо
32.			Юу ч бичээгүй	X
33.		Үгийн тоо	Үгийн тоондоо багтсан	1 оноо
34.			Үгийн тоо илт дутсан, хэт илүүдсэн	0 оноо
35.			Юу ч бичээгүй	X
36.	Бичгийн соёл /4 оноо/	Зөв бичгийн дүрмийн алдаа	Зөв бичгийн дүрмийн болон үгийн үндэс буруу бичсэн 2 хүртэл алдаатай	3 оноо
37.			Зөв бичгийн дүрмийн болон үгийн үндэс буруу бичсэн 3-5 хүртэл алдаатай	2 оноо
38.			Зөв бичгийн дүрмийн болон үгийн үндэс буруу бичсэн 6-10 алдаатай	1 оноо
39.			10-аас дээш алдаатай бичсэн болон юу ч бичээгүй	0 оноо
40.			Юу ч бичээгүй	X
41.		Бичгийн хэв	Бичвэр нь унших, ойлгоход нөлөөлөөгүй	1 оноо
42.			Бичвэр нь унших, ойлгоход сөргөөр нөлөөлсөн, унших, ойлгоход хэцүү	0 оноо
43.			Юу ч бичээгүй	X